Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Гол хөшүүрэг нь иргэдийн хүсэл эрмэлзэл

Давалгааг дага

Сонгуулийн эдийн засаг

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл 2012. 05 сар. №09 (019) www.mongolianeconomy.mn

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ТОМ ҮҮД НЭЭГДЛЭЭ



XacBank
Зөв Банк





- Зах зээл дээр өрсөлдөхүйц өндөр хүүтэй
- Хугацааны болон дүнгийн, хүүний өргөн сонголттой
- Бусдад бэлэглэх шилжүүлэх, өвлүүлэх худалдан борлуулах боломжтой

ХАМГИЙН ӨНДӨР ХҮҮТЭЙ

ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТ



info@xacbank.mn, www.xacbank.mn 1888, 318185, 328701

RioTinto

RioTinto

Монголын Үндэсний
Олимпийн хороо
АЛТАН ТҮНШ



Монголын Олимпийн баг,
Монгол улстай тогтоосон түншлэл -
Рио Тинтогийн бахархал

www.riotinto.com/london2012
www.ot.mn

**уурхайн гүнээс
аваргын энгэрт**



Innovating for success
Newcom Group

ÍÜÞÊÎÌ ÃÐÓÏÏÈÉÍ ÒÓÕÀÉ









Ньюком ХХК нь 1993 онд үүсгэн байгуулагдсан хүмүүсийг холбож, орон зайг ойртуулсан үндэсний томоохон хөрөнгө оруулагч юм. Өнөөдөр Ньюком Групп нь 2,200 гаруй ажиллагсадтай ба дэд бүтэц, харилцаа холбоо, мэдээллийн технологи, иргэний агаарын тээвэр, санхүүгийн үйлчилгээ, сэргээгдэх эрчим хүч, үл хөдлөх хөрөнгө болон уул уурхайн үйлчилгээ зэрэг талбарт тогтвортой хөрөнгө оруулалт хийж, улмаар 17 охин болон хараат компанитай болоод байна.

1996 онд Ньюком ХХК үүрэн утасны салбарт хөрөнгө оруулалт хийн Мобиком компанийг үүсгэн байгуулсанаар Монгол улсад анхлан үүрэн утсыг нэвтрүүлсэн бөгөөд өдгөө Мобиком компани нь Монгол улсын шилдэг үүрэн холбооны оператор болжээ. Ньюком ХХК-ийн 2006 онд байгуулсан агаарын тээврийн Изинис Эйрвэйз компани нь өнөөдөр Монголын шилдэг тээвэрлэгч болсон бөгөөд орон нутгийн бүх чиглэлд болон БНХАУ, ОХУ-ын хэд хэдэн хотруу хуваарьт болон захиалагт нислэг үйлдэж байна. Түүнчлэн 2009 онд Европын Хөрөнгө Оруулалт Сэргээн Босголтын Банктай хамтран эхлүүлсэн салхин цахилгаан станцыг байгуулах төслийн барилга угсралтын ажлыг 2012 онд гүйцээн төвийн сүлжээнд холбогдсон Анхны станцыг ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Ньюком ХХК нь цэвэр технологи, олон улсын мэдлэг туршлага, шинэлэг технологи хандлагыг нэвтрүүлж, эх орондоо нутагшуулан өрсөлдөх чадвараа дээшлүүлэн нийгэмдээ тогтвортой, хүртээмжтэй өсөлт хөгжлийг авчрахын төлөө ажилладаг. Ингэхдээ авлига, хүнд суртал, шударга бус бүхнийг үл тэвчин, тунгалаг, ил тод бизнесийн ёс зүйг эрхэмлэн ирсэн.





www.riotinto.com

Rio Tinto

2011 онд Монголд нийт **2.7** **ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫН** хөрөнгө оруулалт Рио Тинто хийсэн

Оюу Толгой төслийн үр дүнд Монголын эдийн засаг 2019 он гэхэд **36%** өснө

Монгол Улсын түүхэнд хамгийн их буюу **85** **САЯ АМ.ДОЛЛАРЫГ** Рио Тинто Монголын сургалтын хөтөлбөрт зарцуулж байна

3300 хүнийг шинээр сургаж, дадлагажуулна

Оюу Толгой төсөлд **9,250** Монгол хүн ажиллаж байна

Оюу Толгой төслийн хугацаанд татвар, ашигт малтмал олборлосны төлбөр, хураамж, ноогдол ашиг байдлаар **70%** хүртэлх хувийг Монгол Улсын Засгийн Газар хүртэнэ



Рио Тинто - Монголын хамгийн том хөрөнгө оруулагч, итгэлтэй түнш

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Үүсгэн байгуулагч, Эрхлэгч:
Д.Бэхбаяр
9999 4248

Үүсгэн байгуулагч, Орлогч Эрхлэгч:
И.Отгонжаргал
8800 6228

Англи хэлний редактор: Террэнс Эдвардс
Орчуулагч: Б.Үүрийнтуяа
Сэтгүүлчид: Б.Баяртогтох
Б.Энхцэцэг
Э.Зоригт
Б.Уганбаяр
Х.Хулан
Б.Энхмарт
Дизайнер, Вэб мастер: Ш.Оюундарь

Олон нийттэй харилцах менежер:
Ж.Алтантуяа 99051914
Маркетингийн менежер: Д.Барианжав 88800825
Б.Энхцэцэг 99015476
Борлуулалтын менежер: С.Цэнд-Аюуш

"Economy" ТВ студи
Дэд захирал: Ц.Буянбат 88112885
Зураглаач: Ц.Бат-Отгон
График дизайн Г.Буянбаатар

ХАЯГ:
Улаанбаатар, ЧД IV хороо,Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

Утас/Факс: 976 - 7011 5476

www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

"Улаанбаатар принт" ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

Борлуулах цэгүүд:
"Интер ном"
"Цэцэг төв"
"Минж плаза"
"Алтантүлхүүр" номын дэлгүүр
"Номин" супермаркетийн бүх салбар
"Макс" супермаркетийн бүх салбар
"Преско" супермаркет
BTSI супермаркет
"Аз орчлон" номын дэлгүүр
"Билэг" их дэлгүүрийн номын тасаг
"Гранд Плаза" дахь супермаркет
"Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza"
"Metro mall"
"Sky" супермаркет
"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар
"Max mal"

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Өнгөрсөн жилийн Монголын эрчим хүчний хөрөнгө оруулалтын чуулга уулзалтаас хойш тус салбарт багагүй өөрчлөлт оржээ. Тухайлбал, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Энэхүү нэмэлт өөрчлөлтүүд нь салбарын хөгжлийг зах зээлийн харилцаанд түлхүү оруулах, хууль эрх зүйн асуудлуудыг зохицуулахад чиглэжээ. ТЭЦ-V барих ажлын тендерт 15 компани материалаа ирүүлснээс өнөөдөр дөрөв нь үлдээд байгаа. Тус компаниудаас нэг л компани шалгарах юм. "Ньюком"-ын салхин станцын санхүүжилтын асуудал бүрэн шийдэгдэж, барилгын ажил нь эхэллээ. Мөн 2000 оноос хойш хэрэгжсэн "Буман нарны гэрэл" төсөл дуусаж байна. Олон мянган малчдыг лааны сүүдрээс гэрэл цахилгаантай ертөнцөд авчирсан уг төсөлд алдаа оноо байсан ч эцсийн үр дүн, ач холбогдлоо сайн өгсөн гэж дүгнэж болох болов уу. Үүнийг өнөөдрийн малчдын амьдрал харуулна.

"Монголын эрчим хүч-2012" олон улсын чуулга уулзалтын сэдэв, уриа нь тогтвортой хөгжил. Эрчим хүчний салбарт тогтвортой хөгжлийг хэрхэн бий болгох, ямар бодлого баримтлах зэрэг асуудлаар холбогдох байгууллагын мэргэжилтнүүд илтгэл тавьж, хэлэлцүүлнэ.

Монголчууд Азийн сэргээгдэх эрчим хүчний салбарт тэргүүлэгч болох, зөвхөн нүүрс, алт, зэсээ бус байгалийн шавхагдашгүй нөөц нар, салхи, усны эрчим хүчийг экспортлох тухай ярьж эхэллээ. Энэ бол хөгжлийн нэг алхам. Азийн бар орнууд ч Монголын говь нутгийг сонирхож, манай хувийн хэвшлийнхэнтэй хамтарсан компани байгуулах үндсийг тавьж байна. Гэхдээ тэд нүүрс бус нар, салхийг илүүд үзэж байна.

Африкийн Сахарын цөлийн гуравны нэгийг ашиглаад Европыг бүхэлд нь сэргээгдэх эрчим хүчээр хангах том хэмжээний төсөл хэрэгжээд явж буйг бид мэднэ. Тэгвэл Япон, Өмнөд Солонгос, Монголын санаачлагаар Азийн супер эрчим сүлжээ байгуулах тухай асуудлыг ярьж эхлээд байна. Ингэснээр дэлхийг хэрсэн байгальд ээлтэй эрчим хүчний супер сүлжээ бий болох ажээ. Энд Монгол Улс хэрхэн бэлтгэлтэй байгаа вэ? Боломжийг хөгжил болгох нөөц, чадавх байна уу?

Эдгээр асуудлаар "Mongolian Economy" сэтгүүлийн шинэ дугаарт түлхүү хөндлөө. Манай сэтгүүл Монголын эрчим хүчний хөрөнгө оруулалтын энэхүү олон улсын чуулганд хоёр дахь удаагаа мэдээллийн түншээр ажиллаж байгаа юм. Улс орны гал голомт болсон салбарын хөгжлийг тодорхойлж яваа ЭБЭХЯ, нөгөө талаас хөгжлийн тулгамдсан болоод ирээдүйн бодлого чиглэлийг олон нийтэд хүргэх зорилготой ажиллаж буй "Mongolian Economy" сэтгүүл, хамтын ажиллагаанд амжилт хүсье.

ЭРХЛЭГЧ Д.БЭХБАЯР

Займагийн борлуулагчаас NESTLE-гийн захирал хүртэл



Шинэ бүтээлээр тэсрэлт хийж, өрсөлдөгчөө хол хаях нь аль ч компанид хамгийн үнэ цэнэтэй асуудал юм...10

Эрх, бэрхийн эн тэнцүү ухаан

Сайн боловсрол сайхан хүмүүжлийн харгуйгаар үр хойчоо хөтлөн яваа нэгэн гэр бүлд манай сэтгүүлийн “Амьдрал” булан зочиллоо. ..16



Хогноос салах гол хөшүүрэг нь иргэдийн хүсэл эрмэлзэл



Манай нийслэлээс гарч буй хогны 60 орчим хувийг дахин боловсруулах боломжтой ч одоогоор огт боловсруулалт хийдэггүй. Дөнгөж 3-5 хувийг нь л хоёрдогч түүхий эд болгон экспортолж байгаа аж...30

Толгойгоо ажиллуулж, мөнгө олдог шинэ бизнесийг бий болголоо

Бидний эргэн тойронд байгаа байгалийн бас нэгэн баялаг болсон агаар, хоосон зайг ашиглаж бизнес явуулж байна. Энэ агуулгаараа байгальд үнэхээрийн ээлтэй үйл ажиллагаа явуулж байгаа гэж хэлж болно...36



БИЗНЕС

10 Займагийн борлуулагчаас NESTLE-гийн захирал хүртэл

14 Ямаа ба кофе

16 Эрх, бэрхийн эн тэнцүү ухаан

18 Чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх нь компанийн хариуцлага юм

19 Сонгуулийн эдийн засаг

22 Монгол нүүрсний баялгаа “ногоон” нүүрс болгох боломжтой

24 Буцалж буй Ханбогд

24 Монголд хөрөнгө оруулахад учирч болох улс төрийн эрсдэлүүд

27 Салхины үнэрээс хуваалцахуй

Эдийн засаг

30 Хогноос салах гол хөшүүрэг нь иргэдийн хүсэл эрмэлзэл

33 Хүнд ажлын хямд хөлс

36 Толгойгоо ажиллуулж, мөнгө олдог шинэ бизнесийг бий болголоо

40 Давалгааг дага

42 Азийн хөгжлийн загвараас бидэнд сурах зүйл бий юу?

ДЭД БҮТЭЦ

Төмөр замын суурь бүтэц барих концессын эрхийг Засгийн газрын энэ сарын 9-ний хуралдаанаар олгохоор шийдвэрлэлээ. Хуралдаанаар Сайншанд-Тавантолгой чиглэлийн 225 км, Ухаа худаг-Сайншанд чиглэлийн мөн 225 км төмөр замын суурь бүтцийг барих, ашиглах, төрийн өмчид шилжүүлэх эрх олгох концессын гэрээний төслүүдийг хэлэлцэн дэмжжээ. Төмөр замын суурь бүтэц барих концесст төрийн оролцоо, хяналтыг хангах зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” компанийг оролцуулахыг Төрийн өмчийн хороонд даалгасан байна.



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хувьцаа юу, сая төгрөг үү? “Эрдэнэс Тавантолгой”ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжид худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээг Засгийн газраас авлаа. Хувьцаагаа Засгийн газарт нэрлэсэн үнээр худалдах иргэдийн хүсэлтийг тавдугаар сарын 20-ны өдрөөр тасалбар болгон хүлээн авахаар болов. Заасан хугацаанд хувьцаагаа худалдах хүсэлт гаргаагүй иргэд болон бэлэн мөнгө хэлбэрээр нэг сая төгрөгийн хишиг, хувиа хүртэх хүсэлт гаргаагүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийг хувьцаа авах хүсэлтэй гэж тооцохоор боллоо.



НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

Тэтгэвэр хамгийн багадаа 23 хувиар нэмэгджээ. Зарим хүнийх гурав дахин нэмэгдсэн байна. Жишээлбэл, 1987-1991 онд тэтгэврээ тогтоолгосон автобусны жолооч 140300 төгрөг авдаг байсан бол одоо 282.0 мянга болж хоёр дахин нэмэгджээ. Мөн Ховд аймгийн харъяат барилгын архитектур мэргэжилтэй хүн 1995 оноос өмнөх цалингаар тооцож 140300 төгрөгийн тэтгэвэр тогтоолгосон бол өнөөдөр 400 гаруй мянган төгрөг авч үндсэндээ гурав дахин нэмэгдсэн байна. Дунджаар аваад үзэхэд 1995 оноос өмнөх цалин хөлснөөсөө тэтгэврээ тогтоолгосон хүмүүсийн тэтгэврийг 63 мянган төгрөгөөр нэмжээ. Ингэснээрээ Засгийн газраас ижил төстэй мэргэжлийн хүмүүсийн тэтгэврийн зөрүү бүрэн арилгасан хэмээн онцолж байна.

БИЗНЕС

Компанийн засаглалын хөгжлийн төв болон ОУСК хамтран “Монголын компанийн засаглал V” форумыг зохион байгууллаа. Форумын үеэр хэлэлцсэн гол сэдэв нь хувийн компани болон гэр бүлийн бизнесийн засаглалын асуудал байв. Учир нь, дэлхийд хамгийн хуучин зохион байгуулалттай боловч нийтлэг байдаг хэлбэр нь гэр бүлийн бизнес аж. ОУСК-ийн гаргасан судалгаагаар дэлхийн олон оронд нийт бизнесийн 70 гаруй хувийг гэр бүлийн бизнес эзэлж, ажлын байр олноор бий болгон, улсынхаа эдийн засгийн өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэдэг аж. Манай улсын хувьд ч хувийн хэвшлийн салбарт гэр бүлийн бизнес мөн зонхилж буй гэдгийг “Тэнгэр” санхүүгийн нэгдлийн гүйцэтгэх захирал М.Болд сануулсан. Тиймээс гэр бүлийн бизнесийн засаглалыг илүү хөгжүүлж, ил тод байдлыг хангаж, гэр бүлийн гишүүд компанийн төлөөлөн удирдах зөвлөл болон дээд удирдлагын зохистой тогтолцоог бий болгох нь чухал байгааг хурлын үеэр илтгэгчид сануулж байсан юм.

“Үнэт цаасны захын зээлийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын Төсвийн байнгын хорооогоор хэлэлцүүлэхээр зэхээд буй аж. Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын ахлах хянан шалгагч Т.Жамбаажамцын хэлснээр хуулийн шинэчилсэн найруулгад бодлогын хэмжээнд томоохон өөрчлөлтүүд орж буй учир хөрөнгө, санхүүгийн зах зээлд нэлээд том өөрчлөлт авчирна гэдгийг сануулсан. Үүнд юун түрүүнд мэргэжлийн брокер, дилер хөрөнгө оруулалтын компаниудын шаардлага шалгуурыг өндөрсгөж, үүргийг тодорхой болгож байгаагаараа онцлог болох аж.



Төрийн албан хаагчдын цалинг энэ сарын 1-нээс 23 хувиар нэмсэн билээ. Энэ нь Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн биелэлт бөгөөд он гарсаар цалин нийтдээ 53 хувиар нэмэгдсэн гэсэн үг аж. Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагчийн дундаж цалин 630 мянган төгрөгт хүрсэн байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар троллейбусны угсралтын үйлдвэр манай улсад анх удаа ашиглалтад орлоо. Машин үйлдвэрлэлийн шинэ салбар хэмээн тодорхойлж буй “Цахилгаан тээвэр” компанийн угсралтын үйлдвэрлэлийг шугаман дамжлагад шилжүүлснээр үйлдвэрлэлийн хүчин чадал гурав дахин нэмэгдэж, жилд 80-100 ширхэг троллейбус, доубус үйлдвэрлэх техник технологийн боломжоор хангагдсан байна. Тус компани 2006 онд анхны “JEA-800” маркийн троллейбус угсарснаас хойш нийт 41 троллейбус, үйлдвэрлэж, хоёрыг экспортлоод байна.

ТЕХНОЛОГИ

Монгол Улсын үндэсний анхны хиймэл дагуул “Монголсат”-ыг 2013 оны нэгдүгээр улиралд хөөргөхөөр болсон тухай “Монголсат” төслийн багийнхан мэдээллээ. Уг хиймэл дагуулаа АНУ-ын пуужинд суурилуулан хөөргөхөөр төлөвлөж байгаа бөгөөд төслийн ерөнхий зөвлөхөөр сансрын нисэгч Ж.Гүррагчаа, технологи хариуцсан ерөнхий зөвлөхөөр академич Б.Чадраа нар ажиллаж байна. Хиймэл дагуул сансарт 5-7 жил байх ёстой бөгөөд энэ хугацаанд эрдэм шинжилгээний чанартай шинжлэх ухааны хоёр туршилт, судалгаа болон мэдээллийн технологид суурилсан, соёл боловсролын цогц туршилтыг хийх гэнэ.

Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх зорилгоор ашиглагддаг төхөөрөмжүүдийн нэг нь салхин турбин юм. Харин францын “Eole Water” компани салхин турбиныг байгальд ээлтэй өөр нэгэн технологид ашиглах боломжтой болгосон байна. Тус компани агаарын чийглэгээс цэвэр ус үйлдвэрлэх “WMS1000” маркийн салхин турбин бүтээсэн бөгөөд энэ оны эцсээр худалдаанд гаргахаар төлөвлөжээ. Хүчин чадлын хувьд агаарын температур, агаарын чийглэгийн түвшин, салхины хурдаас хамааран нэг турбин хоногт дунджаар 1000 литр хүртэл хэмжээний цэвэр ус үйлдвэрлэх боломжтой аж. Газар нутаг болон орчны нөлөөллөөс хамааран шинэ турбиныг суурилуулах өртөг одоогоор 660 -790 мянган доллараар үнэлэгдэж байна. Уг ажил амжилттай болж чадвал энэ нь сэргээгдэх эрчим хүчний салбарт хийгдэх томоохон шинэчлэл юм.

ХЯТАД


Өнгөрсөн сарын байдлаар Хятадын инфляци 3,4 хувь болтлоо буурч тус улсын Төвбанк мөнгөний бодлогоо сулруулж эдийн засгийн өсөлтөө тогтвортой барих боломжтой болжээ. Харин нөгөө талаас тус улсын экспорт болон импортын өсөлт саарч эхэлжээ. Өнгөрсөн жилд урд хөршийн экспортын жилийн дундаж өсөлт 8.9 хувь байсан бол энэ онд 4,9 хувь болсон байна. Энэ нь гадаад зах зээлийн эрэлт буурч буй дохио болж байгаа юм. Харин импортын бүтээгдэхүүний өсөлт 0,3 хувиар нэмэгдсэн нь дотоодын эрэлтэд уналт бий болсныг харуулж байна хэмээн Блүүмберг агентлаг мэдээллээ.

ОРОС

Оросын шинэ ерөнхийлөгч 59 настай В.Путин Д.Медведевт өгсөн амлалтаа биелүүлж Оросын Парламентаар түүний сайдын сэнтийг батлуулжээ.



Энэхүү үйл явдлын дараа тэрбээр хэлэхдээ “Бид улс орныхоо бат бэх байдлын төлөө хамтдаа зүтгэж, тулгамдсан асуудлаас зөв гарцыг олж, төр, ард түмэнтэйгээ хамт гэдгийг батлан харуулна” хэмээн мэдэгдсэн байна. Өнгөрсөн ням гаригт В.Путиныг эсэргүүцсэн жагсаал хөдөлгөөн Москва хотод өрнөж, цагдаа нар 400 гаруй хүнийг баривчилсан боловч В.Путин даваа гаригт ОХУ-ын Ерөнхийлөгчийн тангараг өргөж, ОХУ-ыг ирэх зургаан жилд удирдах аж.





“МОНГОЛЫН ЭРЧИМ ХҮЧ-2012”

НҮБ-аас 2012 оныг тогтвортой эрчим хүчний жил болгон зарлалаа. Ер нь сүүлийн үед дэлхий дахинаа болж буй томоохон хурал семинарууд тогтвортой хөгжил, ногоон эдийн засаг, ногоон хөгжил гэсэн малгайн дор болж байна. Энэ нь дэлхий нийтээрээ байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулж, хүрээлэн буй орчинтойгоо зохицож амьдрах шаардлага бий болсныг харуулж буй тод жишээ юм.

Монгол Улсын хувьд ч дээрх уриалгыг дэмжиж, “Монголын эрчим хүч–2012: Тогтвортой эрчим хүч-Хөрөнгө оруулалт-Технологи” олон улсын чуулга уулзалтыг хоёр дахь удаагаа зохион байгуулах гэж байна. Монголын эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого, зорилтыг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад танилцуулах, хөрөнгө оруулалт татах, шинэ техник технологи нэвтрүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх, эрчим хүчний салбарын төр, хувийн хэвшлийн түншлэлийн боломж нөхцөлийн чиглэлээр хэлэлцүүлэг өрнүүлэх, мөн сонирхсон асуудлаараа хариулт авах зэргээр харилцан ярилцаж, санал бодлоо хуваалцах зорилготой юм.

“Монголын эрчим хүч-2012” чуулганаар “Эрчим хүчний бодлого, хууль эрхзүйн хүрээнд гарч буй өөрчлөлт, үндсэн чиг хандлага, салбар дахь ТХХТ-ийн бодлогын хэрэгжилт, анхаарах асуудлууд, Тогтвортой эрчим хүчнийхөгжлийн асуудлууд болон Эрчим хүчний салбар дахь хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтын асуудлууд” сэдэвт хэлэлцүүлэг өрнөнө.

Монгол Улсын эрчим хүчний салбарт хөрөнгө оруулах эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн гэж ЭБЭХ-ний сайд Д.Зоригт ярьж байна. Улс орны хөгжлийн суурь гэгддэг тус салбарыг шинэ шатанд гаргахад гадаад, дотоодын хөрнгө оруулагчдын хамтын ажиллагаа маш чухал билээ. Өнгөрсөн жилийн анхны чуулга уулзалтын хувьд салбарын хууль, эрх зүйн орчин, хөрөнгө оруулах боломжийн талаар мэдээ мэдээлэл дэлгэрэнгүй өгч чадсанаараа ач холбогдолтой хурал болсон гэж төлөөлөгчид дүгнэж байсан. Тиймээс энэхүү чуулга уулзалтыг цаашид жил бүр тогтмол зохион байгуулах юм.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭ ЭРИН

Ирээдүйд үүсэх эрчим хүчний хэрэгцээг өнөөдрийн хэмнэж буй эрчим хүчээрээ хангах, хэмнэлт, урамшууллын тогтолцоонд суурилсан хууль эрх зүйн орчин бүрдүүлнэ гэж Эрчим хүчний зохицуулах хорооноос мэдэгдсэн.

Б.БАЯРТОГТОХ

Өрийн дарамтад олон жил нуруугаа холгуулсан эрчим хүчний салбарынхны магнай тэнийж эхлэв. Улсын төсвийн татаасаар мөлхөж, урт хугацаатай зээлээр “тушаатай” аж төрж буй тус салбарт эрх зүйн хувьд урамтай шинэчлэл гарсныг УИХ-ын гишүүн А.Тлейхан хэллээ. Нэг үгээр хэлбэл, эрчим хүчний салбарт шинэ эрин үе эхэлж буйг тэрбээр тэмдэглэсэн юм.

Иргэд эрчим хүчний тухай хууль, дүрэм, журам тогтоолыг жилдээ нэг удаа ч болов эргүүлж, тойруулж, гарчиглах нь ахуй амьдрал, ажил хөдөлмөрт туйлаас нэмэртэй тухай мэргэжилтнүүд зөвлөдөг. Эрчим хүчний салбар “эдийн засагжих” тооцоог хууль эрх зүйн орчинд нэвтрүүлж, гүнзгий шинэчлэлт хийхээр төлөвлөж байна. Чухам энэхүү өөрчлөлт шинэчлэлт салбарын өнөөгийн төрх, маргаашийн өрсөлдөх чадварыг бий болгох биз ээ.

“Түлш эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2010 оны УИХ-ын 72 дугаар тогтоол хэрэгжсэнээр тус салбар эрүүлжих, зах зээлийн эдийн засагт өөрийгөө аваад явчих эрх зүйн болоод эдийн засгийн чадамж бүрдэх ажээ.

УИХ-ын 72 дугаар тогтоолын үр дүнд дараах өөрчлөлт гарчээ.

- Салбарын хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулж эхэлжээ.
- Гадаадын урт хугацаат зээлээс хамааралтай валютын ханшны зөрүүг Засгийн газар хүлээх юм.
- Хэрэглэгчдийн төлбөрийн чадвараас хамаарч, борлуулах эрчим хүчний үнийн өсөлтийн тодорхой хувийг улсын төсвөөс санхүүжүүлж татаас өгдөг болов.
- Эрчим хүчний үнэ тарифыг 2014 оноос чөлөөлнө.

Нэг асуудал…

“Эрчим хүчний салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх үйл явцыг эрчимжүүлэх, менежментийг сайжруулах, үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн үр ашгийг дээшлүүлэх, өртөг зардлыг хямдруулах талаар бодлого боловсруулж хэрэгжүүлнэ” хэмээн 72 дугаар тогтоолд тэмдэглэжээ. Мөн улсын төсвөөс түлш эрчим хүчний компаниудад олгож буй татаас, хөрөнгө оруулалтын хэмжээгээр салбарын үйлдвэрүүд хоорондын хуучин өрийн сүлжээг бүрэн хааж, балансыг цэвэрлэх ажил өрнөж байгаа аж.

Сүүлийн жилүүдэд салбарын санхүүгийн байдал доройтож ихээхэн хэмжээний алдагдалтай ажиллаж байсан бол дээрх тогтоолын дүнд мэдрэгдэхүйц өөрчлөлт гарч буйг мэргэжилтнүүд тэмдэглэдэг. Тус тогтоолд зааснаар дараах хоёр шийдвэр амжилттай хэрэгжиж, нэг асуудлыг хэлэлцэж байна.

Амжилт

1. Эрчим хүчний салбарын эдийн засаг, санхүүгийн байдлыг зөв гольдиролд оруулсан.

2. “Эрчим хүчний тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулснаар тус салбарыг зах зээлийн харилцаанд шилжих үйл явцыг гүнзгийрүүлсэн.

Алхам

Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль удахгүй мэндлэх нь. Азийн хөгжлийн банк, Германы техникийн хамтын ажиллагааны байгууллагатай хамтран ЭБЭХЯ-ны Ажлын хэсэг хуулийн төслийг бэлтгэжээ.

Эрчим хүч хэмнэх нь байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа. Бага нүүрс хэрэглэх тусам утаа багасна, техникийн элэгдэл, хорогдол буурна. Тиймээс цахилгаан дамжуулалт, түгээлт, хэрэглээний бүхий л түвшинд эрчим хүч хэмнэх хууль эрх зүйн орчин бүрдэх аж. Мөн Эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолд түлш эрчим хүчний салбарын эдийн засгийн чадавхыг сайжруулах, өр, авлагаас салгаж, зах зээлийн горимоор ажиллуулахаар тооцжээ. Үүний дүнд нь авлага, өглөгийн харьцаа өнөөдөр хэвийн горимд орж яваа гэнэ. Тухайлбал, өмнө нь өглөг нь авлагаасаа 30 гаруй тэрбум төгрөгөөр зөрдөг байсан эрчим хүчний салбарын өглөг өнөөгийн байдлаар 32 тэрбум төгрөгөөр буурчээ. Уурхай, станцын хоорондох өрийн асуудал энэ оны эцэс, дараа оны дунд гэхэд бүрэн арилах боломж харагдаж байгаа гэнэ.

Хуульд дахин нэмэлт, өөрчлөлт оруулна

“Эрчим хүчний салбар зах зээлийн харилцаанд огт шилжээгүй гэж үзэж болохгүй. 2001 онд Эрчим хүчний тухай хууль гарснаар манай салбар зах зээлийн арилжааны хэлбэрт шилжиж, төрийн үйлдвэр, компаниуд удирдлага, санхүүгийн хувьд бие даасан хэлбэрт орсон. Хуучин босоо удирдлагатай буюу нэг тогооны зарчмаас хэвтээ бүтэцтэй буюу компанийн өөрийн удирдлагын зарчимтай болсон” гэж Эрчим хүчний зохицуулах хорооны дарга Т.Цэрэнпүрэв хэллээ. Эрчим хүчний тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр эрчим хүчний салбарыг зах зээлийн харилцаанд орох үйл явцыг хурдасгах, Эрчим хүчний зохицуулах газрыг хороо болгон үйл ажиллагаа, үүрэг хариуцлагыг өргөжүүлэх, тус хороог орон тооны гурав, мөн хэрэглэгчийн төлөөлөл болсон орон тооны бус хоёр, нийт таван зохицуулагч удирдах асуудлыг шийдвэрлэсэн байна.

УИХ-ын 72 дугаар тогтоол болон “Эрчим хүчний тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулснаар гарсан үр дүн:

1. Эрчим хүчний зохицуулах газар нь хороо болсноор зарим нэмэлт ажил, үүргийг хариуцах, түүнчлэн хуулийн хүрээнд бие даасан байдлаа хангах боломж нөхцөл бүрдэх аж.

2. Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлэх асуудал хэрэгжих. Үнэ тарифийг уян хатан бодлогоор зохицуулах боломж нээлттэй болж байгаа юм байна.

3. Цаашид эрчим хүчний салбарын үнэ өртгийг тооцохдоо хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцож, үнэ тариф тогтоох зарчим шинэлэг байдлаар үйлчлэх болж байгаа аж. Өмнө нь нийт зардлыг дунджаар тооцон үнэ тарифыг тогтоодог байжээ.

4. УИХ-ын тогтоолын хүрээнд жил жилд үнэ тарифыг зохистой хувиар үе шаттайгаар нэмэгдүүлсэнээр Эрчим хүчний салбар 2014 он гэхэд өөрийгөө бүрэн санхүүжүүлж, алдагдалгүй ажиллаж эхэлнэ. Өөрөөр хэлбэл, ирэх 2014 оноос салбар төрөөс татаас авахгүй, бие даан ажиллана гэсэн үг.

5. Гадаадын хөрөнгө оруулагчид эрчим хүчний салбарт хөрөнгө оруулах эрх зүйн болон эдийн засгийн орчин нөхцөл бүрдэж эхэлжээ. Тухайлбал, Эрчим хүчний шинэ эх үүсвэрийг концессын гэрээгээр барьж байгуулах ажлын үр дүнд Могойн голын уурхайг түшиглэн 60 МВт цахилгаан станц Хятад, Монголын хамтарсан “Шинэ Ази майнинг” компани барьж байна. Тус компани 110 сая ам.долларын хөрөнгөөр цахилгаан станцыг барьж, 20 жилийн дараа төрд хүлээлгэн өгөх аж.

6. Эрчим хүчний ахуйн хэрэглэгчид сард 150 кВт.ц буюу түүнээс бага цахилгааныг хэрэглэсэн тохиолдолд цахилгааны төлбөрт гурван жилийн турш одоогийн үнээр мөрдөх нь. Хэрэглэгчдийг огцом үнийн өсөлт, дарамтаас хамгаалах үүднээс төрөөс татаас олгож буй учир хэрэглэж буй цахилгааны бодит үнээс тодорхой хувиар хөнгөлж байгаа аж. Харин Та 150 кВт.ц-аас дээш хэмжээний цахилгаан хэрэглэсэн бол бодит өртөг зардал бүхий үнээр тооцоо хийх юм байна.

7. Төвийн бүсийн эрчим хүчний үйл ажиллагааны орлого нэмэгджээ. Өмнө нь 150 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлдэг байсан Төвийн бүс өдгөө 213 тэрбум төгрөгийг төвлөрүүлж байна. Орлого нэмэгдсэн нь компаниудын санхүүгийн тогтвортой байдал сайжрахад ихэд нөлөөлжээ.

8. Эрчим хүчний салбарын нийт алдагдал энэ онд буурчээ. Төвийн бүсийн 12 компанийн алдагдал 45 тэрбумаас 27 тэрбум төгрөг болж, алдагдал нийтдээ 40 гаруй хувиар буурсан үзүүлэлт нь тус салбарын хувьд том үйл явдал. Ирэх жилээс үнэ тарифын зохицуулалт хийгдсэн тохиолдолд алдагдал ихээхэн буурч нэмэх үзүүлэлттэй гарах нөхцөл бүрдэнэ, энэ тал дээр төр, хэрэглэгчидтэй хамтарч дэмжлэг авч ажиллана гэдэгт найдаж байна гэж Эрчим хүчний зохицуулах хорооноос онцлов.

“Эрчим хүчний тухай хууль”-д дахин нэмэлт, өөрчлөлт оруулах болсон шалтгаан:

-Төрийн зохицуулалтаар үнэ тарифыг тогтоож, зөвшилцлийн хүрээнд шийдэж байгаа учраас Өрсөлдөөний газраар үнийг дахин хянуулах шаардлагагүй гэсэн заалтыг “Эрчим хүчний тухай хууль”-д нэмэлт өөрчлөлтөөр оруулна хэмээн УИХ-ын гишүүн А.Тлейхан онцлов. Учир нь, Эрчим хүчний зохицуулах хорооны таван зохицуулагчийн нэг нь Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн төлөөлөгч учраас ийн шаардлагагүй хэмээн үзжээ.

-Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихтэй холбогдуулан худалдах, худалдан авах гэрээний асуудлаар нэмэлт өөрчлөлт оруулах юм байна.

Зах зээлийн зарчмаар урагшаа

Улаанбаатар хотын хүн амын төвлөрөл өсөн нэмэгдэхийн хэрээр эрчим хүчний хэрэглээ, түүний үнэ цэнэ улам өссөөр. Цаашдаа хязгааргүй хэрэгцээг хэмжээтэй нийлүүлэлт хангаж чадах болов уу. Бүтээн байгуулалтын томоохон хөтөлбөрүүд хөлд орж, “100 мянган айл орон сууц” хөтөлбөр хэрэгжиж эхэлж буй энэ үед эрчим хүчний салбарт дэлхийн чиг хандлагатай нийцсэн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхийг эрмэлзэх болжээ.

Ирээдүйд үүсэх эрчим хүчний хэрэгцээг өнөөдрийн хэмнэж буй эрчим хүчээрээ хангах, хэмнэлт, урамшууллын тогтолцоонд суурилсан хууль эрх зүйн орчин бүрдүүлнэ гэж Эрчим хүчний зохицуулах хорооноос мэдэгдсэн.

“Эрчим хүчний салбарт урт хугацааны өр бий. Гэхдээ тус салбар эрүүлжиж байгаа учраас цаашдаа төлөх хугацаанд бэрхшээл гарахгүй. Өөрийгөө санхүүжүүлэх зарчимтай болсон. Гэрээний хугацаанд өрөө төлөх боломжтой. 2014 оноос эрчим хүчний салбар жинхэнэ утгаараа зах зээлийн зарчмаар ажиллах талаар мэргэжилтнүүд онцлон тэмдэглэж байна” хэмээн А.Тлейхан гишүүн ярьсан. ■

САЙД ЯРЬЖ БАЙНА

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ТОМ ҮҮД НЭЭГДЛЭЭ

Судалгаанаас харахад бид гаргаж авсан эрчим хүчнийхээ багагүй хувийг үргүй алдчихдаг гэсэн дүгнэлт гарсан. Хамгийн энгийн жишээ гэхэд хэрэглэгчид улайсдаг чийдэн хэрэглэх, үйлдвэрлэгчид зохих ёсны хэмнэлтийг хийхгүй байх зэрэг олон асуудал бий.



Д.БЭХЭЭ

Хоёр дахь жилээ зохиож буй “Монголын эрчим хүч-2012” олон улсын чуулга уулзалтыг уггаж *УИХ-ын гишүүн, ЭБЭХ-ний сайд Д.Зоригтой ярилцлаа.*

-Эрчим хүчний салбарт хөрөнгө оруулагчдыг татах хууль эрх зүйн орчин хэр бүрдсэн бэ?

-Эрчим хүчний тухай хуулийн шинэчлэлд хэд хэдэн нэмэлт өөрчлөлт оруулсан. Тухайлбал, “Эрчим хүчний зохицуулах хороо”-ны бие даасан байдлыг нэмэгдүүлэх тал дээр багагүй анхаарсан. Уг хууль 2001 оноос хэрэгжиж эхлээд өдий хүрсэн болохоор энэ хугацаанд гарсан алдаа дутагдал, засч залруулах шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг ч мөн хуулийн шинэчлэлд тусгаж өгсөн. Мөн салбарт хувийн хэвшлийг татах чиглэлээрх асуудлуудыг зохицуулсан.

Үүнээс гадна эрчим хүчний салбарын өөрийнх нь чадамж, үнэлэмж сайжирсан учраас тухайн салбарт дотоодын хөрөнгө оруулалт ч орж ирэх нөхцөл бүрдэж байгаа юм. УИХ-ын зарим гишүүн өмнөх хуулийн өөрчлөлтөөр дутуу орхисон зүйлүүдийг нэмээд Эрчим хүчний тухай хуульд дахин нэмэлт хийх төсөл оруулсан байна лээ. Энэ хуулийн төсөлд Засгийн газар, холбогдох байгууллагууд өөрсдийн санал санаачлагаа нэмэрлэсэн. Хэрвээ хаврын чуулганаар уг хуулийн төслийг авч хэлэлцэж нааштай үр дүнд хүрвэл эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулах боломж бүрэн бүрдэнэ гэсэн үг. Дээрээс нь Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн төслийг ч мөн УИХ-д мөргөн барина. Уг хууль нэлээд шинэлэг, тухайн салбарын үр ашгийн талаарх ойлголтыг багтааснаараа онцлог юм. ▸▸

Ер нь судалгаанаас харахад бид гаргаж авсан эрчим хүчнийхээ багагүй хувийг үргүй алдчихдаг гэсэн дүгнэлт гарсан. Хамгийн энгийн жишээ гэхэд хэрэглэгчид улайсдаг чийдэн хэрэглэх, үйлдвэрлэгчид зохих ёсны хэмнэлтийг хийхгүй байх зэрэг олон асуудал бий. Тийм учраас Хэмнэлтийн тухай хууль батлагдвал эрчим хүчээ хэмнэсэн айл өрх, үйлдвэрүүдийн газруудыг урамшуулах тогтолцоог бүрдүүлэх юм.

-Хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд иргэдийн сэтгэлгээг өөрчлөх хэрэгтэй болох байх. Хэмнэх сэтгэлгээг олон нийтэд хэрхэн бий болгох вэ?

-Иргэдийн сэтгэлгээг өөрчлөх нь хэцүү. Тиймээс тодорхой урамшууллын систем бий болгоод зогсохгүй сурталчилгааны ажлыг хамт хийх хэрэгтэй. Энэ хоёр аргыг хамтад нь хэрэгжүүлэхгүй бол зөвхөн хэрэглэгч та өдрийн гэрэл хэрэглэх нь сайн гээд яриад байвал үр дүн багатай болно. Харин өдрийн гэрэл нь эрчим хүчний ийм ийм хэмнэлттэй, энэ гэрлийг хэрэглэвэл тодорхой хэмжээний урамшуулал олгоно гэвэл илүү ач холбогдолтой болов уу.

-Эрчим хүчний салбарыг зах зээлийн харилцаанд хурдацтай шилжүүлэх талаар ямар бодлого барьж байгаа вэ?

-Эрчим хүчний салбар зах зээлийн харилцаанд огт шилжээгүй гэвэл энэ нь өрөөсгөл юм. Яагаад гэвэл 2000 оны эхээр эрчим хүчний хуулийг боловсруулж 2001-2002 оноос хэрэгжиж эхэлсэн тэр үеэс эрчим хүчний салбарыг зэх зээлд шилжүүлэх бүх суурь нөхцөл нь бүрдсэн.

Бие даасан Эрчим хүчний зохицуулах газрыг байгуулж, Засгийн газраас хараат бусаар эрчим хүчний үнийг тогтоох эрхтэй болсон. Энэ бол том давуу тал.

Мөн эрчим хүчний аж ахуйн нэгжүүдийг 100 хувь төрийн мэдэлд байсныг салгаж ХК, ХХК болгосон байгаа. Салбарын ТУЗ-ийн гишүүдийг бие даасан хараат бус байлгах ажил идэвхтэй хийгдэж байна. Эрчим хүч түгээх, дамжуулах компаниудыг салгалаа. Энэ мэт хийсэн ажил их бий.

Гэхдээ нэг зүйл дутагдаад байна. Тухайлбал, 2002 онд Эрчим хүчний зохицуулах газар эрчим хүчний үнийг нэмэх шийдвэр гаргахад УИХ-аас хориглосон. Энэ нь бид нэг гараараа хууль баталчихаад нөгөө гараараа хуулиа зөрчсөн үйлдэл болсон билээ. Тиймээс өнөөдөр Эрчим хүчний зохицуулах газрын бие даасан байдалд түлхүү анхаарч байна. Сүүлийн гурав, дөрвөн жил их сайн ажилласан. УИХ-аас 2014 он гэхэд эрчим хүчний тарифыг зах зээлийнх нь үнэд шилжүүлэх тухай тогтоол гаргасан байгаа. Энэ бол манай салбарын хөгжлийн том үүд хаалга нээгдлээ гэж ойлгож болно. Гэхдээ нэг зүйлийг хэлэх хэрэгтэй. Бид үнийг нэмэх гээд улайраад байгаадаа биш. Тухайлбал, бид хийсэн талхаа 600-1000 төгрөгөөр зарж байж эдийн засгийн эргэлтэд орох байтал төрөөс үгүй ээ чи 200 төгрөгөөр зар гээд байвал тухайн салбар дампуурна аа даа. Эрчим хүчний салбар яг л ийм байдалд орчихоод байгаа юм. Өнөөдөр нэг кВт цаг эрчим хүч 100 гаруй төгрөгийн бодит үнэтэй байсаар атал хямдаар зар гэхээр алдагдалд орох нь ойлгомжтой. Тэгэхээр энэ алдагдлыг ямар нэг газар нөхөж өгөх, эс бөгөөс үнийг зах зээлд нь даатгах хэрэгтэй болно. Урьд нь төрөөс л алдагдлын зарим хэсгийг нөхөж явдаг байсан. Одоо ч хэвээр байгаа шүү дээ.

-Уг нь хуулинд улс төрөөс хараат байна гээд заачихсан байдаг ч шийдвэрт нь улс төрийн гар хөл оролцоод нөлөөлөөд байгаа шүү дээ.

-Шинэ хуулийн төсөлд мөн улс төрөөс ангид байх санааг тусгаж өгсөн. Гэхдээ улс төр огт орж болохгүй гэх нь нэг талаар өрөөсгөл юм. Адаглаад ард түмний нуруун дээр үнийн дарамт очоод эхэлбэл УИХ-аас үнийг нь бууруулах шийдвэр гаргах нь зүй ёсны хэрэг. Харин ийм тохиолдолд, эрчим хүчний салбарынханд учрах алдагдлыг төрөөс нөхөж өгөх хэрэгтэй. Өнөөдөр бид энэ л механизмаар явж байна. Сүүлийн хоёр жилд улсын төсвөөс эрчим хүчний компаниудад 15 орчим тэрбум төгрөгийн татаас өглөө.

Өөрөөр хэлбэл, өнөөгийн эрчим хүчний үнэ зах зээлийн ханшаас



доогуур байгааг бид зөвшөөрч байна. Тиймээс энэ татаасыг өгч байгаа юм. Энэ жил гэхэд 7.5 тэрбум төгрөгийг татаас хэлбэрээр өгсөн. Эрчим хүчний үнэ нэг үеэ бодоход өссөн учраас төрөөс олгох татаасын хэмжээ буурсан гэж хэлж болно. Энэ мэтчилэн явсаар 2014 он гэхэд татаасын тухай ойлголт байхгүй болох учиртай.

-Эрчим хүчний салбарын хувьчлалын асуудлаар Та ямар байр суурьтай байгаа вэ?

-Одоогийн үйлдвэр, аж ахуйн нэгжүүдээ хувьчлахаас өмнө шинээр орж ирж буй томоохон төслүүдийг хувийн хөрөнгө оруулалтаар хийх нь зүйтэй гэж үзэж байгаа. Хамгийн эхний жишээ нь Ухаа худаг дахь 18 мВт-ын цахилгаан станц. Мөн 100 хувийн хөрөнгө оруулалтаар ТЭЦ V-ыг байгуулахыг зөвшөөрлөө. Энэ нь өөрөө эргээд эрчим хүчний зах зээлийн эрүүл орчинг бүрдүүлэх юм. Ийм орчин бүрдээд ирэхээр төрийн мэдлийн томоохон байгууллагуудын үйл ажиллагаа ч жигдрээд ирнэ. Тэр үед бид төрийн мэдлийн объектыг



хувьчлах уу, үгүй юү гэдгээ бодох хэрэгтэй. Хооронд нь харьцуулах зүйлтэй болно шүү дээ. Хувийнх нь ийм байхад төрийнх нь тийм байна гэдэг ч юм уу.

Хувьчлалын тухайд шинэчлэл, ахиц дэвшилтэй талууд байгаа. Тухайлбал, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” компанийг хувьчлах шийдвэрийг УИХ-аас гаргасан. Мөн ТЭЦ-V дээр хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих хэрэгтэй гэдэг дээр санал нэгдсэн. Харин ТЭЦ-III, Дархан, Эрдэнэтийн цахилгаан станцуудыг хувьчлах шийдвэр гараагүй. Учир нь арай л эрт байна гэж үзсэн.

Юу юуны духанд хүрэлгүй суурь гэгддэг салбарынхаа бүх үйлдвэрийг хувьчилчихаар сөрөг үр дагавар үүсвэл яах вэ. Эрсдэлээ тооцох нь чухал юм. Хамаагүй ханддаг салбар биш шүү дээ, эрчим хүч. Тиймээс түрүүний хэлсэнчлэн харьцуулах зүйлтэй болчихоод аль нь илүү ашигтай вэ гэдгийг мэдэж, харж байж дараагийн алхмаа хийх нь зүйтэй.

-PPP буюу концесс эрчим хүчний салбарт хэрэгжиж эхлээд байгаа. Гэхдээ УИХ-ын зарим гишүүн төр мөнгөтэй болж байгаа учраас цахилгаан станцаа улс өөрийн хөрөнгөөр, мөн олон улсын санхүүжилтээр барьж байгуулж болохтойгоо боллоо. Дан ганц төр, хувийн хэвшил гэх нь өрөөсгөл гэж ярьж байсан.

-Миний хувьд энэ тал дээр арай өөр бодолтой байгаа. Эдийн засгийн орчин эрүүлжээд хувийн хэвшил орж ирэх боломж бүрдэж буй тохиолдолд хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих л хэрэгтэй. Эрүүл мэндийн салбарт өнөөдөр хувийн олон эмнэлэг байна. Тэгвэл улс одоо мөнгөтэй болчихлоо, эмнэлгүүдээ хаа, бид эмнэлэг барина гэвэл юу болох вэ. Түүний оронд нөхцөл байдал сайжирч байгаа учраас хувийн томоохон эмнэлгүүдийг оруулж ирэх нь өрсөлдөөнийг улам сайжруулна гэдэг бодлого барьж байна. Яг л үүнтэй адилхан ашигтай үйл ажиллагаагаар хөрөнгөө буцаад нөхөж чадах тэр салбарт хувийн хэвшлийг оруулаад өг. Энэ нь эргээд эдийн засагтаа ашигтай.

Улсад үүнээс өөр хийх ажил олон бий. Тухайлбал, том том дамжуулах шугамаа барих шаардлагатай. Хөдөө, орон нутагт цахилгаан станцуудыг ашиглахад төр оролцох ёстой. Аймгуудын халуун ус, дулаан хангамжийн асуудал бий. Энэ нь тийм ч ашигтай бизнес биш. Тиймээс төр л энэ талд анхаарна. Ер нь ажлаа хуваах хэрэгтэй. Төсвийн тогтвортой байдлын хуульд энэ талаар зааж өгсөн байгаа. Тухайн төслийн ТЭЗҮ-г хийгээд ашиггүй гарсан ч нийгмийн шаардлага нь байвал төр хийнэ. Харин ашигтай бол хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах гэсэн санаа бүхий заалт байдаг.

-Гэрэл цахилгаангүй хэдэн сум байна вэ, манайд?

-Намайг ажил хүлээн авснаас хойш 77 сумын шугамын барилга угсралтын ажил дуусч, сумдад хүлээлгэн өгсөн. Хамгийн хүндрэлтэй байсан Говь-Алтай, Завханы асуудал шийдэгдсэн. Эдгээр аймгийн 33 сум өнөөдөр цахилгаан дамжуулах агаарын шугамд холбогдож эрчим хүч авч байгаа. Харанхуй байсан хоёр аймаг гэрэлтэй боллоо. Нийтдээ 331 сумын 316 нь цахилгаан шугамд холбогдож, 12 нь сэргээгдэх эрчим хүчнээс, хоёр сум дизель станцаас цахилгаан авч байгаа. Энэ жил 10 сумыг шинээр холбохоор улсын төсөвт хөрөнгө мөнгийг суулгаад байна. Цаашид эрчим хүчинд хилийн отряд, застав томоохон багийг холбох ажил хийнэ.

-Монгол Улсын эрчим хүчний салбар дахь шинэ хандлага бол яах аргагүй сэргээгдэх эрчим хүч буюу “ногоон” эрчим хүч юм. Сэргээгдэх эрчим хүчээр эх орондоо төдийгүй Азидаа тэргүүлэгч улс болох том зорилт дэвшүүллээ. Салбарын сайдын хувьд энэ нь хэр биелэлээ олох боломжтой мөрөөдөл вэ?

-Энэ бол бидний дараагийн том мөрөөдөл. Хийх ёстой ажил. Өнөөдөр Тавантолгой, Оюутолгой гээд л яриад байна. Тэгвэл өнөөдрөөс сэргээгдэх эрчим хүчний талаар ярьж, хийж эхлэх хэрэгтэй. Тухайлбал, манай орны нар салхины эрчим хүчний нөөц бололцоо Япон улсын нийт

суурилагдсан эрчим хүчний хүчин чадлаас 12 дахин их. Өөрөөр хэлбэл, дэлхийн гурав дахь том эдийн засагтай орны суурилагдсан эрчим хүчээс 12 дахин их байна гэдэг нь том зах зээл. Тиймээс энэ зах зээлийг эдийн засгийн эргэлтэд оруулахын тулд гаднын өндөр технологи, арга туршлагыг нэвтрүүлэх нь чухал. Ингэж чадвал бидний мөрөөдөл тийм ч чанад холын зүйл биш.

Европын орнуудхамтраадСахарын цөлд цэвэр эрчим хүч үйлдвэрлэж Европ руу гаргах төсөл хэрэгжүүлээд явж байна. Сахарын цөл нь дэлхийд хамгийн их нарны эрчим хүчний нөөц бүхий газар. Дараа нь манай говь, гуравдугаарт, Австралийн цөл ордог. Ингээд бодохоор манайд нөөц маш их байна. Нөөцөө эрчим хүч болгоод урд хөрш, Япон руу экспортлох тухай ярих тохиолдолд техник технологийн хувьд судлах ёстой. Энэ талаар зарим нэг хувийн компаниуд ажиллаад эхэлсэн. Тухайлбал, “Ньюком” компани Японы байгууллагатай хамтраад салхины эрчим хүчний чиглэлээр ажиллах компани байгуулсан байна. Цаашдаа бид 20-30 жилийн дараа уул уурхай дээрээ түшиглэх бус сэргээгдэх эрчим хүч дээр тулгуурласан эдийн засагтай орон болж чадвал шавхагдашгүй нөөц бүхий баялагтай баян орон болох юм.

-Японууд эрчим хүчний бодлогодоо эрс өөрчлөлт хийж, цөмийн энергиэс татгалзаж, ногоон эрчим хүчийг эрчимтэй хөгжүүлэх зорилт дэвшүүллээ. Герман цөмийн энергээс татгалзлаа. Манайд цөмийн эрчим хүчийг хөгжүүлэх тухай ярьж байна. Таны байр суурь ямар байгаа вэ?

-Цөмийн энергиэс дэлхий даяараа татгалзаагүй шүү дээ. Франц өөрийн эрчим хүчнийхээ 80 хувийг цөмийн энергиэс гаргаж авдаг. Гэхдээ Японы цунамигаас үүдсэн цөмийн эрчим хүчний талаарх асуудал дэлхий нийтэд том сургамж болсон нь үнэн. Гэлээ ч бүгд нэг мөр цөмийн эрчим хүчнээс татгалзах нь хэцүү. Энэ талын эрчим хүчний эх үүсвэр ирээдүйд илүү аюулгүй, хөгжингүй болох байх. Манай орны хувьд ч мөн ялгаагүй ураны тэр их нөөцөө зарим нэг талаар ашиглах л хэрэгтэй болов уу.

Цөмийн эрчим хүчийг ашиглах холын зорилгодоо тусгаж өгсөн зүйл шүү дээ. Өнөө маргаашгүй цөмийн ашиглана гэсэн зорилго алга. Харин энэ чиглэлээр боловсон хүчнийг одооноос бэлтгэх, сургах тал дээр анхаарах хэрэгтэй. Цөмийн эрчим хүч нь өөрөө шинжлэх ухааны хувьд асар том салбар. Тиймээс бид энэ салбарыг огт хаяж болохгүй. Шинжлэх ухааны том хөдөлгүүр юм. Түүнээс биш, станц бариад цөмийн энерги ашиглах талаар төлөвлөсөн зүйл байхгүй ээ.

Усан цахилгаан станцын тухай ярихад юуг яаж улс төржүүлж, “унагаж” болдгийн том жишээ юм. Энэ төсөл хэрэгцээтэй юү гэвэл хэрэгцээтэй. Хөрөнгө мөнгийг нь шийдэж байсан уу байсан. Хэд хэдэн удаа УИХ, Засгийн газраар орж байсан. Бүр 1980, 1990-ээд оноос ярьж эхэлсэн төсөл. Улс төрийн дуулиан болоод л өнгөрдөг нь нууц биш.

-Эрчим хүчний салбарынхны бас нэг мөрөөдөл том чадлын усан цахилгаан станц барих явдал. Уг нь биелэхэд маш ойртсон мөрөөдөл. Улс төрийн шалтгаанаар биелэгдэхгүй өнөөг хүрч байна. Энэ мөрөөдөл хэзээ биелэх вэ?

-Усан цахилгаан станцын тухай ярихад юуг яаж улс төржүүлж, “унагаж” болдгийн том жишээ юм. Энэ төсөл хэрэгцээтэй юү гэвэл хэрэгцээтэй. Хөрөнгө мөнгийг нь шийдэж байсан уу байсан. Хэд хэдэн удаа УИХ, Засгийн газраар орж байсан. Бүр 1980, 1990-ээд оноос ярьж эхэлсэн төсөл. Улс төрийн дуулиан болоод л өнгөрдөг нь нууц биш.

Өнөөдрийн байдлаар эрчим хүчний бүх талын бодлогын баримт бичигт том чадлын усан цахилгаан станц барих талаар тусгаж өгсөн. Хаана барих талаар судалж байна. Эгийн гол дээр судалгаа эртнээс хийсэн. Гэхдээ байгаль орчны хувьд зарим нэг асуудлыг араасаа дагуулж магадгүй. Тиймээс Сэлэнгэ мөрөн дээр 200 МВт-ын хүчин чадалтай станц барих талаар ярьж байна. Энэ бол бидний хувьд том чадлын станц. Гаднын орнуудын 5000 МВт-ын усан цахилгаан станцуудын хажууд өчүүхэн л дээ. Харин манайдаа том юм. Тэгэхээр 200 МВт-ын станцыг барих нь тийм ч хэцүү асуудал биш. Энэхүү ажлыг аль болох яаравчлах цаг болсон. Учир нь, улс орны эрчим хүчний аюулгүй байдлын хувьд ч ихэд ач холбогдолтой.

Монгол Улс ОХУ-аас эрчим хүч импортоор авдаг. Тиймээс оргил ачааллаа зарим нэг талаар хаая гэж бодож байгаа бол том чадлын усан цахилгаан станц л барьж ашиглалтад оруулах хэрэгтэй. Үүний тулд эхлээд хүмүүст ойлгуулж, судалж, хамтран зөвшилцөж л байж хийх нь зөв.

-Эрчим хүчний салбарт, нийгмийн хангамж, боловсон хүчин гээд ар араасаа цуварсан олон асуудал бий. Боловсон хүчний хувьд уул уурхай, хувийн томоохон компаниуд хөрөнгө мөнгөөр салбарын ажилтнуудыг авчихаж байгаа гэж сонссон. Үүнтэй холбоотой төрийн өмчит компаниуд боловсон хүчний дутагдалд орж эхлээд байна. Тиймээс энэ асуудал дээр ямар арга хэмжээ авах хэрэгтэй вэ?

-Өнөөдөр эрчим хүчний салбарын чиглэлээр сургууль төгсөж буй хүүхдүүдийн тоо харьцангуй олон. Тухайлбал, Оюутолгойн төслөөр олон зуун хүүхдийг эрчим хүч, уул уурхайн чиглэлээр сургахад хамгийн түрүүнд эрчим хүчээр сурсан хүүхдүүд баталгаат ажлын байртай болж байна гэсэн судалгаа гарчээ. Баярлуштай хэрэг. Үүнээс харахад бидэнд эрэлт байна аа. Гэхдээ эрчим хүчний салбарыг хүчирхэгжүүлэх шаардлага бий. БСШУЯ-тай хамтраад хөрөнгө мөнгө зарцуулж, техник технологийн чиглэлээр сургах хэрэгтэй байна.



Тухайлбал, БСШУЯ, ШУТИС, Канад улстай уул уурхайн чиглэлээр хүүхдүүд туршлага солилцож, сургалт явуулж байна. Эрчим хүчний салбарт яг л үүнтэй адил төсөл, хөтөлбөр явуулах хэрэгтэй. Цаашдаа бид эрчим хүчний судалгааны төвүүдийг хүчирхэгжүүлэх ажлыг хиймээр байна. Цалин мөнгөний тухайд манай салбарынхан хангалуун сайхан байгаа гэж хэлэхэд хэцүү. Гэхдээ сүүлийн жилүүдэд цалин тодорхой хувиар нэмэгдсэн. Цаашдаа цалинг нэмэх шаардлага байгаа.

-Стратегийн ач холбогдолтой орд газруудын эрчим хүчний асуудлыг шийдэх бодлогын баримт бичиг ямар шатандаа явж байна вэ?

-Бодлогын баримт бичиг батлагдсан. Үүний хүрээнд "Эрдэнэс Тавантолгой" компанид 300 МВт-ын тусгай зөвшөөрөл өгөх гэж байна. ТЭЗҮ нь удахгүй дуусна. Мөн Оюутолгойд 300 МВт-ын тусгай зөвшөөрөл олгохоор хэлэлцэж байна. Гэхдээ энэ тал дээр хамгийн тулгамдаж буй асуудал нь ус. Оюутолгойд 300 МВт-ын хүчин чадлын станц барих нь хүчин чадлын хувьд арай бага байх нь ойлгомжтой. Тиймээс Тавантолгой, Оюутолгойг холбосон хоёр талын сүлжээг бий болгох асуудлаар ажиллаж байна. Дээрээс нь төвийн бүсэд ТЭЦ V-аас гадна 600 МВт-ын хүчин чадалтай шинэ станц байх ёстой гэж үзсэн. Эхнээсээ хувийн хэвшлийн компаниудтай гэрээ байгуулж, ТЭЗҮ хийгээд явж байна.

-ТЭЦ V, Тавантолгой гээд том асуудал олон байна. Эдгээр ажил хэр урагштай явж байна вэ?

-ТЭЦ V-ын хувьд манай яамнаас хийх ажлууд дууссан. ТЭЗҮ-ээ хийсэн, Засгийн газарт уламжилсан, хэлэлцүүлээд батлуулсан. Одоо энэ ажил ТӨХ-ны мэдэлд өгсөн Тендерийн хувьд 11 компаниас дөрөв нь үлдсэн. Mitsubishi, Samsung, International Power гэсэн дэлхийн хэмжээний шилдгүүдээс аль нэг нь үлдэнэ. Харин ТЭЦ V-тай холбоотой нүүрсний хангамжийн асуудал, зам тээвэр, Бага нуур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг өргөтгөх гээд дагалдах жижиг сажиг асуудал бий. Гэхдээ бид ТЭЦ V-ын үндсэн асуудлыг энэ сард бүрэн дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.

Тавантолгойн хувьд орд газар нь эдийн засгийн эргэлтэд орсон. Одоогоор 1.5 сая орчим тонн нүүрс олборлосон. Олсон орлогоосоо өнгөрсөн жил 340 гаруй тэрбум төгрөгийг улсын төсөвт өгсөн. Уг төсвөөс хүний хөгжил сангийн 21 мянга, оюутнуудын 500 мянган төгрөгийг олгож байгаа. Энэ жил мөн 300 гаруй тэрбум төгрөгийг улсын төсөвт тушаана. Үүнээс нь хүний хөгжлийн нэг сая төгрөгийг олгох юм. Тиймээс Тавантолгойг зарим талаар урагшгүй байгаа мэт ярих нь буруу. Эдийн засгийн эргэлтэд орсон.

Харин тодорхой хэсэг дээр нь л гаднын хөрөнгө оруулагчдыг оруулах талаар хэлэлцэж байна. Шалтгаан нь, транзит тээвэр, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх шаардлагатай холбоотой.

Хэлэлцээрээр хаана ямар хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байна вэ, хэн нь ямар үүрэг оролцоотой байх вэ гэдэг асуудлууд эцэслэн шийдэгдээгүй учраас бага зэрэг хүлээлт бий болоод байгаа юм. Гэхдээ Тавантолгой эдийн засгийн эргэлтэд орж, ард түмэндээ ашгаа өгөөд эхэлсэн гэдгийг ойлгох хэрэгтэй.

АСУУДАЛ

ДАМПУУРЛААС СЭРГЭЛТ РҮҮ

“Жилээс жилд өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэглээг хангах асуудал эрчим хүчнийхний толгойны өвчин болж байна. Мэдээж шинэ эх үүсвэр яаралтай барих хэрэгтэй. Үүнээс гадна хэрэглээгээ хэмнэх ёстой.

Б.БАЯР

Хэмнэх сэтгэлгээ…

Монгол Улсад хэмнэх сэтгэлгээг үл төрүүлэхүйц, эдийн засагжаагүй хоёрхон зүйл бий. Хамгийн хямд үнэтэй учраас хайрлах, хэмнэх сэтгэхүй ард түмнийх нь дунд хөгжөөгүй хэмээн олон улсын байгууллагын мэргэжилтэн биднийг дүгнэжээ. Тэр нь ус, цахилгаан.

Ус, дулаан, цахилгаанаа хэмнэж чаддаггүй улс хэзээд алдагдалтай, ашигтай бус ажилладаг байна. Та өдөрт хэчнээн хэмжээний цахилгаан, дулаан хэмнэж чаддаг вэ? Үүнийгээ л тооцохгүй бол бодитой бус үр ашиггүй зарцуулсан эрчим хүчний мөнгийг та төлсөөр байх нь. Сар бүрийн эхний долоо хоногт тог цахилгаан, дулааны мөнгөө бид банк явж төлдөг. Тухайн сард гарч буй мөнгөний хэдэн хувийг нь та үр ашиггүй, зарцуулсан эрчим хүчид төлсөн бол оо. Ингэж нэг удаа ч болов тооцож үзсэн үү. Хэмнэлтийн сэтгэлгээ хаана байна вэ?

Цаашдаа хэмнэлтийн горимд өөрөө, мөн үр хүүхдээ сургахгүй бол танайх эрчим хүчний сул зарлагаас толгой өндийхгүй байж мэдэх нь. Тиймээс өрхийн төсвөө алдагдалд оруулахгүйн тулд, өөрөө ч үнийн дарамтад өртөхгүйн төлөө өнөөдрөөс эхлээд ногоон эдийн засгийг дэмжин, байгаль дэлхийгээ хайрлаж, хэмнэлтийн сэтгэхүйд нийтээрээ шилжих шаардлагатай тулгарч байна.

УИХ-ын 2010 оны “Түлш эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” 72 дугаар тогтоол нь сөхөрч яваа эрчим хүчний салбараа дэмжиж, сөгдөж унахаас нь өмнө өндийлгөх гэсэн зорилго агуулсан билээ. Өөрөөр хэлбэл, энэ салбарыг аварч үлдэхийн тулд 2014 он гэхэд хэрэглэгчдийн нэг кВт.ц цахилгааны үнийг 115 төгрөгт хүргэхээр болжээ. Тус тогтоол нь иргэдээ тог цахилгаантай, гэрэл гэгээтэй, халуун, дулаан аж төрөх тогтвортой орчин бүрдүүлэхэд орших аж. Тиймээс эрчим хүчний үнэ тарифыг бүхий л талаас нь судалж, хэрэглэгчдийн үнийг үе шаттайгаар нэмэх, зарим хэрэглэгчээ хамгаалах арга хэмжээг давхар авсан байна.

Уул уурхайн салбарын хэрэглэгчид өнөөдөр нэг кВт.ц цахилгаанд 100 төгрөг төлж байгаа нь хамгийн “үнэтэй” тариф, манай улсын хувьд.Төвийн бүсэд амьдарч буй иргэд өдгөө нэг кВт.ц цахилгааныг 84 төгрөгөөр худалдаж авч байна. Гэхдээ 84 төгрөг нь эрчим хүчний бодит үнэ биш. Эцсийн хэрэглэгчдэд 100 гаруй төгрөгөөр гэрэл цахилгаан очихоор байгаа. Тиймээс иргэдийн амьжиргааны түвшинтэй уялдуулан үнийг чөлөөлөх 2014 оныг хүртэл улсын төсвөөс жил бүр 15 тэрбум төгрөг Төвийн бүсэд зарцуулах ажээ. Энэ мөнгө бол иргэд дээр очих ачааллыг багасгах түр зуурын арга. Харин хоёр жилийн дараагаас эрчим хүчний салбар биеэ дааж ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлсэн тул төрөөс олгодог татаас зогсох нь. Бодит үнээр төлбөрөө төлнө гэсэн үг. Тэгэхээр өнөөдрийн сэтгэлгээгээр цахилгаан, дулаанд хандаж амьдарвал танайх эрчим хүчдээ багагүй мөнгө зарцуулах болох нь ээ.

150 кВт.ц-аас илүүгүй бол хөнгөлөлт эдлэнэ

Танайх сардаа ийм хэмжээний, үүнээс бага цахилгаан хэрэглэдэг бол нэг кВт.цахилгаанд 79 төгрөг 80 мөнгө төлнө. Харин заасан хэмжээнээс их цахилгаан хэрэглэвэл бодит үнээр нь худалдан авна. Эрчим хүчний зохицуулах хорооноос150 кВт.ц-аас дээш эрчим хүч хэрэглэж буй айл өрхийн үнэ тарифыг нэмэх юм байна. Тогтоолд ч ийм зүйл заалт бий ажээ. “Хэдийгээр айл өрхийн тариф 79 төгрөгөөс 84 төгрөг болж, үнэ өссөн ч зардлын өсөлтийг нөхөж чадахгүй байна” хэмээн Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч Н.Мягмарсүрэн учирласан юм. Хамгийн хямд шөнийн тариф зөвхөн Монголд л бий. Эрчим хүчний салбартаа хөнгөлөлттэй, халамжийн бодлого хэрэгжүүлдэг улсад мөн л манайх багтаж байна. Эмзэг бүлгийн, гэрэлтүүлгийн гээд эрчим хүчний хямд тарифын

систем бас л үйлчилдэг. Тэгэхээр сэтгэлгээгээ өөрчлөх цаг иржээ. Өртгөө нөхсөн үнэ тариф мөрдсөнөөр дорх үр дүн гарах аж.

Үнэ тарифаа үнэлж үзэхүй

“Цахилгаан эрчим хүчний үнэ өөрийн өртгөөс хямд яваа. Өртгөөс хямд зарж байгаа учраас алдагдалтай. Өнгөрсөн онд эрчим хүчний салбар Монгол Улсын хэмжээнд нийтдээ 39 орчим тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна. 2001 онд батлагдаж, 2011 онд шинэчлэгдсэн Монгол Улсын Эрчим хүчний тухай хуульд Бодит зардлыг хаасан ашигтай үнэ тариф мөрдөнө гээд заачихсан байдаг аж. Гэтэл ашгийн төлөө бус өртгөө л нөхөхийн төлөө тус хороо өнөөдрийн байдлаар ажиллаж байна. Гол шалтгаан нь эрчим хүчний үнэ тариф нэмэх нь иргэдийн амьдралд сөргөөр нөлөөлнө гэж улстөрчид үздэг. Тэгэхээр жил бүр бага багаар нэмсээр хоёр жилийн дараа хэрэглэгчдийн нэг кВт.ц цахилгааны үнийг 115 төгрөг болгох бодлого баримтлах юм байна.

Бодит өртгөө нөхсөн үнэ тариф мөрдөхийн тулд

1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах дөрвөн төрлийн үйл ажиллагаа явуулж, эрчим хүч ч дээрх шат дамжлагуудыг дамжин хэрэглэгчдэд очдог. Эдгээр шат дамжлагын санхүү, эдийн засгийн нөөц бололцоог өртгөө



нөхсөн үнэ тариф хангах юм байна. Алдагдалгүй үнэ тарифаар эрчим хүч борлуулснаар компаниудын засвар үйлчилгээ чанаржиж техник технологио сайжруулах техникийн алдагдлаа бууруулах боломж гарч улмаар найдвартай үйл ажиллагаа нь дээшилж хэрэглэгчдэд чанартай үйлчилгээ хүрнэ. Ингэснээр хэрэглэгч мөн хожих нь байна.

2. Гадаадын хөрөнгө оруулалтыг татна. Одоогийн алдагдалтай үнэ тарифаар цаашилбал хэн ч хөрөнгө оруулахгүй, хэн ч сонирхохгүй.

3. Хэрэглэгчдэд хэмнэх сэтгэлгээг бий болгоно.

4. Ногоон эрчим хүч, ногоон эдийн засгийг хөгжүүлэхэд үр өгөөжтэй.

Эрчим хүчийг индексжүүлнэ


Эрчим хүчний салбарын үнэ тарифыг 2014 оноос индексжүүлж, эдийн засгийн тооцоо судалгааг тун нарийн хийх гэнэ. Индексжүүлэх гэдэг нь эрчим хүчний үнийг гол зардлуудын өөрчлөлтөөс хамааруулан автоматаар өөрчилнө гэсэн үг. Тус салбарын гол зардалд түлшний/нүүрс,мазут тээврийн/ зардал ордог. Станцын зардлын 50 гаруй хувийг түлшний зардал эзэлнэ. Мөн валютын ханшны зөрүүний зардал гэж бий. Учир нь, манайх бүх сэлбэг хэрэгслээ гаднаас авч валютаар төлдөг. Жилдээ 200 гаруй сая кВт.ц эрчим хүч импортолж мөн л валютаар тооцоо хийнэ. Урт хугацаатай зээлийн хүүг ч валютаар төлнө. Хэрэв эрчим хүчний үнийг индексжүүлсэн тохиолдолд түлшний үнэ, валютын ханш, хэрэглээнийн үнийн индексээс хамаарч, цахилгаан, дулааны үнэ өсөж, буурах боломжтой болох юм байна.

“Жилээс жилд өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэглээг хангах асуудал эрчим хүчнийхний толгойны өвчин болж байна. Мэдээж шинэ эх үүсвэр яаралтай барих хэрэгтэй. Үүнээс гадна хэрэглээгээ хэмнэх ёстой. Хэмнэлтийг дэмжсэн бодлого барих нь чухал. Жишээ нь дулааны алдагдал маш их байна. Цонх, хана, хаалгаар их дулаан алддаг. Манайхан хэтэрхий үрэлгэн байна” гэж Н.Мягмарсүрэн ярьсан.Тэрбээр “Эрчим хүчний салбар сүүлийн хоёр жилд өндийж байгаа. Хуучин сөнөлөө гэдэг байсан. Богино хугацаат өр төлбөр буурч байна. Өмнө нь авлага нь өглөгөөсөө бага гардаг байсан. Одоо авлага нь өглөгөөсөө илүү гарч байна. Өрийн сүлжээ тайлагдаж эхэлсэн. Гэхдээ энэ нь бүх юм сайхан болчихсон гэсэн үг биш сайжрахын эхний шинж тэмдгүүд” гэсэн юм.

Нүүрсний уурхай, станцын олон жилийн хуучин өр төлбөрөөс өнгөрсөн онд нэлээд буурчээ. Уурхайд авсан нүүрснийхээ мөнгийг тухай бүр нь төлөөд явах шинэ тогтолцоо руу шилжсэнийг салбарынхан онцлов. Алдагдалтай ажиллаж байсан эрчим хүчний салбар ямартаа ч гаргасан зардлаа нөхөж, эдийн засгийн эерэг баланстай ажиллах цаг удахгүй ирэх биз нь. Гадаадын хөрөнгө оруулалт эрчим хүчний салбарт орж ирэх хандлага мэдрэгдэж эхэлснийг мэргэжилтнүүд тэмдэглэсэн. ■

ҮНЭ ТАРИФ


Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудын орон сууцны халаалтын үнийн өсөлт




	1990	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011
Улаанбаатар	3	4.5	4.5	19	30	30	48	60	65	65	160	160	160	160	160	191	191	191	265	265	304	341
Дархан, Эрдэнэт	3	4.5	4.5	19	30	30	48	60	65	65	160	160	160	160	160	191	191	247	265	265	304	341

Тайлбар: 2002 оны сүүлийн хагас жилээс эхлэн орон сууцны гал зуухны өрөөний халаалтын хөлсийг тарифаар тооцож авдаг болсон.

Эрчим хүчний компаниудын үйл ажиллагааны орлогын дүн /тэрбум төгрөгөөр/



Төвийн бүсийн цахилгааны үнийн өсөлт



	1990	1991	1992	19/1/93	1/6/1993	5/6/1993	1994	1995	1996	1997	1/6/1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011
Орон сууц	0.35	0.5	2	2	10	10	16	16	16	28	32	35	35	35	45	47	47	47	51	51	53.2	68	68	79.8	84
ААНБ	0.35	0.35	2	6.75	13	15	16	16	26	34	38	41	41	41	45	47	47	47	51	51	53.2	68	68	79.8	88
Гэр хороолол	0.35	0.5	2	2	10	10	16	16	16	28	32	35	35	35	45	47	47	47	48.8	48.8	51	66	66	77	81

Тайлбар: Орон сууцны болон гэр хорооллын айл өрхийн сард хэрэглэсэн цахилгааны хэмжээнээс хамаарсан ялгавартай тарифыг 2008 оны долдугаар сараас мөрдөж эхэлсэн тул дээрх графикт 2008-2011 онуудын хамгийн өндөр тарифыг харуулав.


Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэрүүдэд худалдах цахилгааны тарифыг 2011 оноос 100 төг/кВт.ц болгосон.

Монгол Улсын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл-2011 он

		/сая кВт.ц/
Дулааны цахилгаан станц	92.70 хувь	4450
Усан цахилгаан станц	1.10 хувь	52.6/
Импорт	5.80 хувь	278 /
Дизель цахилгаан станц	0.42 хувь	278 /

Тайлбар: Хэрэглэгч зөвхөн өөрийн хэрэгцээндээ зориулж өөрөө үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг энэхүү графикт тусгаагүй болно.


Нүүрсний томоохон уурхайнуудын нүүрсний үнийн өсөлт



	2000	2001	2002	2003	2004/ 1	2004/11	2005	2006	2007/10	2007//11	2008	2009	2010/1	2010/11	2011
Шарын гол	8500	9500	10000	10000	10000	12000	13600	13600	14600	16600	21400	21400	22680	26275	26275
Багануур	8050	9000	9250	9250	10730	11500	11500	12500	12500	12500	16200	16200	18200	18200	20500
Шивээ-Овоо	5500	5800	5800	5800	6000	7200	7500	7500	8500	8500	11400	11400	13960	13960	15560
Тавантолгой	8000	8000	8000	8000	8000	8000	8000	8000	8000	8000	8000	8000	8000	8000	8000
Адуунчулуун	3200	3200	3200	3750	3750	3750	4807.4	5100	5100	6100	7500	7500	8584	8584	9600

Тайлбар: Багануур, Шивээ-Овоогийн уурхайн нүүрсний үнэ 2011 оны тавдугаар сараас, Адуунчулууны уурхайн нүүрсний үнэ арваннэгдүгээр сараас тус тус өөрчлөгдсөн

Өндөр хөгжилтэй зарим орны хэрэглэгчдийн цахилгааны үнийг харьцуулсан судалгаа



	Дани	Итали	Ирланд	Бельги	Нидерланд	Швед	Люксембург	Португали	Швейцари	Норвеги	Англи	Франц	АНУ	Канад	Монгол
Үйлдвэр, ААНБ	11.4	25.8	13.7	12.5	12.3	9.6	12.2	12	10.2	7.4	9.5	10.6	6.8	7	6.8
Айл өрх	35.6	26.3	23.3	23.2	22.1	21.8	21.6	21.5	18	17.6	17.5	15.7	11.6	9.5	6.5

Тайлбар: Энэхүү мэдээллийг Олон улсын эрчим хүчний агентлагаас 2011 онд гаргасан судалгаанаас авав.
**Нэмэгдсэн өртгийн татварыг оруулаагүй ба нэг ам.долларыг 1300 төгрөгөөр тооцов.*

Эх сурвалж: Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд-2011" Эрчим хүчний зохицуулах хороо

ТҮНШЛЭЛ

Б.ЗАЯАБАЛ: СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨСЛҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БОЛЛОО

Тавдугаар цахилгаан станц, Дорнодын 100 МВт хүчин чадалтай цахилгаан станцын төслүүдийн тендер байгаа, хог хаягдал боловсруулж эрчим хүч гаргах төслийн судалгаа, бэлтгэл ажлыг хийж байгаа.

Х.ХУЛАН

Эрчим хүчний салбар дахь төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар Төрийн өмчийн хорооны даргын үүрэг гүйцэтгэгч Б.Заяабалаас тодрууллаа.

Төр, хувийн хэвшлийн түншлэл эрчим хүчний салбарт ямар хөгжил авчрах вэ?

-Аливаа хөгжиж байгаа эдийн засагтай орнуудад тогтвортой хөгжлийг хангах, ядуурлыг бууруулахад дэд бүтцийн салбар, ялангуяа эрчим хүчний салбар чухал үүрэг гүйцэтгэдэг. Монгол шиг уул уурхайн баялгийн орлогоос хамааран эдийн засаг нь эрс өсөж буй оронд “баялгийн хараал”-аас зайлсхийх, үр дагаврыг нь арилгахад чиглэсэн алхмуудын нэг нь дэд бүтцийн салбарт хангалттай хэмжээний хөрөнгө оруулалт хийж,эдийн засгийн уул уурхайгаас бусад салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх явдал юм.

2011-2012 оны өрсөлдөх чадварын индексийн судалгаагаар Монгол Улс дэд бүтцийн хөгжлийн үзүүлэлтээрээ 142 орноос 136-д, цахилгаан эрчим хүчний нийлүүлэлтийн чанарын үзүүлэлтээр 108-д орсон байгаа нь тун хангалтгүй үзүүлэлт. Дэд бүтэц, түүний дундаас эрчим хүчний салбарт байгаа ашиглалтын хугацаа нь хэтэрч элэгдэж хуучирсан, бүтээгдэхүүний өөрийн өртөг өндөртэй, хуучин технологитой хөрөнгийг шинэчлэх, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх, шинээр барьж байгуулахад шаардагдах хөрөнгө оруулалтыг төсвийн санхүүжилтээр шийдвэрлэх нөөц бололцоо, цаг хугацаа хомс байгааг бид бүгд ойлгож байгаа. Энэ асуудлыг шийдвэрлэх нэг гарц нь төр, хувийн хэвшлийн түншлэл юм.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийг эрчим хүчний салбарт нэвтрүүлснээр иргэд ижил зардлаар өртөг багатай, орчин үеийн, найдвартай үйлчилгээг авах, урьд нь эрчим хүчний үйлчилгээ хүрдэггүй, дутагдалтай байсан газруудад богино хугацаанд нийлүүлэлтийг хүргэх, хувийн хэвшлийнхэнд урт хугацааны тогтвортой бизнес эрхлэх, бизнесийн зах зээлээ өргөжүүлэх боломж бүрдүүлнэ. Мөн төр нь шаардлагатай хөрөнгө оруулалтыг төсөвт дарамт учруулахгүйгээр шийдвэрлэж зардал, цаг хугацаа хожих, бодлогын зорилтуудаа биелүүлэх, хувийн хэвшлийн мэдлэг, ур чадвар, менежментийг нэвтрүүлж төрийн өөрийн оролцоог зохистой байлгах, нийгэм өөрөө үр ашиг өндөртэй, байгаль орчинд ээлтэй техник, технологийн үр шимийг хүртэх боломжтой болно.

Төр, хувийн хэвшлийн түншлэл эрчим хүчний салбарт хөгжсөнөөр дулааны, цахилгаан, усан цахилгаан станц зэрэг уламжлалт төслүүдээс гадна нар, салхи,



газрын гүний дулааны эрчим хүчний станц, биомасс, биогаз ашиглаж, хог хаягдал боловсруулж эрчим хүч гаргах гэх мэт сэргээгдэх эрчим хүчний орчин үеийн технологитой төслүүдийг хэрэгжүүлэх үүд хаалга нээгдэж байна.

-Төр, хувийн хэвшлийн түншлэл эрчим хүчний салбарт хэрэгжээд нэг жил болж байна. Одоогийн байдлаар энэ чиглэлээр ямар үйл ажиллагаа явуулж байна вэ?

-Төрийн өмчийн хороо нь Концессын тухай хуульд заасны дагуу төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад орсон төслүүдийг хэрэгжүүлдэг. Засгийн газрын 2010 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан тус жагсаалтад эрчим хүчний салбар гэсэн ангилалд нийт 16 төсөл бий. Тэдгээрээс төслийн бэлтгэл хангасан, төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэхгүйгээр хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах боломжтой зарим төслийг сонгож, хэрэгжүүлэхээр Төрийн өмчийн хороо, Эрдэс баялаг, эрчим хүчний яам болон холбогдох байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгүүдийг байгуулан ажиллаж байна.

Одоогийн байдлаар 60 МВт хүчин чадалтай Могойнголын дулааны цахилгаан станцын концессын гэрээг байгуулсан, Улаанбаатар хотод дулаан, цахилгааны эрчим хүчний шинэ эх үүсвэрийг барих тавдугаар цахилгаан станц, Дорнодын 100 МВт хүчин чадалтай цахилгаан станцын төслүүдийн тендер шалгаруулалт явагдаж байгаа, хог хаягдал боловсруулж эрчим хүч гаргах төслийн судалгаа, бэлтгэл ажлыг хийж байгаа гэсэн хэрэгжилттэй байна.

-Гадаадад эрчим хүчний төслийг төр, хувийн хэвшлээр үлгэр жишээ үзүүлэхүйц хэрэгжүүлсэн ямар төсөл буй талаар сонирхуулна уу?

-Хөгжилтэй орнуудтай харьцуулахад хөгжиж буй орнуудын дэд бүтцийн салбар дахь хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага өндөр байдаг. 1990-ээд оноос эхлэн 1997 оны Азийн санхүүгийн хямрал эхлэх хүртэлх хугацаанд хөгжиж буй орнуудын хувийн хэвшлээс эрчим хүчний салбарт оруулж буй хөрөнгө оруулалт эрс нэмэгдсэн, 1998 оны дунд үе гэхэд хөгжиж буй 73 орон эрчим хүчний салбартаа хувийн хэвшлийн оролцоог нэвтрүүлэх алхам хийж, 600 гаруй эрчим хүчний төслийг хэрэгжүүлэхээр бэлтгэж байсан мэдээ бий.

Азийн санхүүгийн хямрал гэх мэт бусад хүчин зүйлээс шалтгаалан таван жил гаруй уналтад орсон эрчим хүчний салбар дахь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 2001 оноос сэргэж, 2005 оныг хүртэл жилд дунджаар 11-16 тэрбум ам.доллар хүрч байсан бол 2005 оноос огцом өсч, 2009 он гэхэд 60 тэрбум ам.доллар хүрэх болсон.

Одоо дэлхий даяар дэд бүтцийн салбарт оруулж буй хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын 44 хувийг эрчим хүчний салбар, 25 хувийг тээвэр, 26 хувийг мэдээлэл, харилцаа холбооны салбар эзэлдэг гэсэн статистик бий.Эндээс харахад эрчим хүчний салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж байгаа төслүүд олон байгааг харж болно. Том хэмжээтэй цахилгаан станцын төслөөс илүүтэй жижигхэн сэргээгдэх эрчим хүчний төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг жишээ болговол сонирхолтой байх болов уу.

АНУ-ын Денверийн олон улсын нисэх буудлын дэргэд гурван га талбайд хоёр мВт-ын хүчин чадалтай нарны эрчим хүчээр цахилгаан гаргах системийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулсан нь жилд гурван сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх мөн тус онгоцны буудлыг жилд гаргах нүүрс хүчлийн хийг 2,268 тн-оор бууруулах боломжтой болгосон байна. ■

КОНЦЕССЫН ЖАГСААЛТ

Эрчим хүчний салбар дахь төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт

Концессын зүйлийн нэр	Концессын зүйлийн тодорхойлолт	Концессын төрөл	Гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ	Төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах эсэх	Уралдаант шалгаруулалт явуулах, шууд гэрээ байгуулах эсэх
Тавантолгойн цахилгаан станц	Говийн бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэгцээг хангахуйц цахилгаан эрчим хүчний үйлдвэрийг Таван толгойн нүүрсний станцыг түшиглэн барих	Барих-өмчлөх-ашиглах	Эрчим хүчний барилга байгууламж барих, цахилгаан үйлдвэрлэх, эзэмших	Шаардлагагүй	Уралдаант шалгаруулалт явуулах
Дулааны Ү цахилгаан станц	Улаанбаатар хотын цахилгаан болон дулааны хэрэгцээг хангах зорилго бүхий дулааны цахилгаан станц барих	Барих-өмчлөх-ашиглах	Эрчим хүчний барилга байгууламж барих, цахилгаан, дулаан үйлдвэрлэх, эзэмших	Шаардлагагүй	Уралдаант шалгаруулалт явуулах
УБ хотын "Их тойруу" цагираг шугам сүлжээ байгуулах	Улаанбаатар хотын хүн амын цахилгаан, эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх	Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх	Улаанбаатар хотын цахилгааны 110 кВт-ын "Их тойруу" цагираг шугам сүлжээний зураг төсөл болосвруулах, санхүүжүүлэх, барих, шилжүүлэх	Судлан шийдвэрлэх	Уралдаант шалгаруулалт явуулах
Дулаан хангамжийг нэмэгдүүлэх	Улаанбаатар хотын хүн амын дулаан хангамжийг нэмэгдүүлэх	Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх	Улаанбаатар хотын дулааны шугам сүлжээг шинээр болон шинэтгэн өргөтгөх ажлуудын зураг төсөл боловсруулах, санхүүжүүлэх, барих, шилжүүлэх	Судлан шийдвэрлэх	Уралдаант шалгаруулалт явуулах
Дорнодын дулааны цахилгаан станц	100 МВт хүчин чадалтай дулааны цахилгаан станц барих	Барих-өмчлах-ашиглах	Эрчим хүчний барилга байгууламж барих, дулаан үйлдвэрлэх, ашиглах, шилжүүлэх.	Шаардлагагүй	Уралдаант шалгаруулалт явуулах
Могойнголын дулааны цахилгаан станц	60 МВт хүчин чадалтай цахилгаан станц барих ажил	Барих- ашиглах-шилжүүлэх	Эрчим хүчний барилга байгууламж барих, цахилгаан үйлдвэрлэх, ашиглах, шилжүүлэх	Шаардлагагүй	Гэрээг шинэчлэн байгуулах
Шивээ-Овоо төсөл	БНХАУ-д цахилгаан эрчим хүчийг экспортлох зорилготой нүүрсний уурхай, дулааны цахилгаан станцын цогцолбор болон цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугам сүлжээ барих	Барих-өмчлөх-ашиглах	Эрчим хүчний барилга байгууламж барих, цахилгаан үйлдвэрлэх, ашиглах, шилжүүлэх	Шаардлагагүй	Засгийн газар хоорондын тохиролцооны дагуу гэрээ байгуулах
Улаанбаатар-Мандалговийн цахилгаан дамжуулах агаарын шугам	260 км урттай 220 кВт-ын хоёр хэлхээт 2хАС-400/51 дамжуулагч утастай, 2 тростой, цахилгаан дамжуулах агаарын шугам барих	Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх	Цахилгаан дамжуулах агаарын шугам барих	Судлан шийдвэрлэх	Уралдаант шалгаруулалт явуулах
Багануур-Чойрын цахилгаан дамжуулах гаарын шугам	180 км урттай 220 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барих	Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-ашиглах-шилжүүлэх	Цахилгаан дамжуулах агаарын шугам барих	Шаардлагагүй	Уралдаант шалгаруулалт явуулах
Чойр-Цагаан-суварга цахилгаан дамжуулах агаарын шугам	Улаанбаатар хотын хүн амын дулаан хангамжийг нэмэгдүүлэх	Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-ашиглах-шилжүүлэх	Цахилгаан, дулаан үйлдвэрлэх, ашиглах, эзэмших	Шаардлагагүй	Уралдаант шалгаруулалт явуулах

“Дулааны III цахилгаан станц ХК” төсөл	280 км урттай 220 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барих	Шинэчлэн сайжруулах-ашиглах-эзэмших	Цахилгаан, дулаан үйлдвэрлэх, ашиглах, эзэмших	Шаардлагагүй	Уралдаант шалгаруулалт явуулах
“Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ХК” төсөл	Дулаан үйлдвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник технологийг шинэчлэх	Шинэчлэн сайжруулах-ашиглах-эзэмших	Цахилгаан, дулаан үйлдвэрлэх, ашиглах, эзэмших	Шаардлагагүй	Уралдаант шалгаруулалт явуулах
“Орхон-говь” усан сан байгуулах	100 МВт хүчин чадалтай дулааны цахилгаан станц барих	Барих-өмчлөх-ашиглах	Ус хоолойгоор дамжуулан ус нийлүүлэх, эрчим хүчний барилга байгууламж барих, цахилгаан үйлдвэрлэх, ашиглах, шилжүүлэх	Шаардлагагүй	Уралдаант шалгаруулалт явуулах
“Туул-Сонгино” усны нөөцийн цогцолбор	Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник технологийг шинэчлэх	Барих-өмчлөх-ашиглах	Бохир ус цэвэрлэх, ундны ус ханган нийлүүлэх, ус хоолойгоор дамжуулан нийлүүлэх, эрчим хүчний барилга байгууламж барих, цахилгаан үйлдвэрлэх, ашиглах, эзэмших.	Шаардлагагүй	Уралдаант шалгаруулалт явуулах
Хог хаягдал боловсруулан эрчим хүч үйлдвэрлэх	Говийн бүсийн усан хангамж, байгаль орчны доройтлыг нөхөн сэргээх зорилго бүхий усан сан, хоолой барих	Барих-өмчлөх-ашиглах	Хог хаягдал боловсруулах, эрчим хүч, эрчим хүчний барилга байгууламж барих, цахилгаан үйлдвэрлэх, ашиглах, шилжүүлэх	Шаардлагагүй	Уралдаант шалгаруулалт явуулах
Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламж болон урьдчилан цэвэрлэх байгууламжийг шинэчлэн сайжруулах	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж болон урьдчилан цэвэрлэх байгууламжийг шинэчлэн сайжруулах замаар хүн амыг баталгаат ундны усаар хангах, байгаль орчин, хөрс усны бохирдлыг багасгах	Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-ашиглах-шилжүүлэх	Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламж болон үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламжийг байгаль орчинд хор нөлөөгүй технологиор шинэчлэн сайжруулах, ашиглах, шилжүүлэх	Судлан шийдвэрлэх	Уралдаант шалгаруулалт явуулах

ГАДНЫН ТУРШЛАГА

НОГООН ХОЛБООС БА ХӨГЖИЛ

Түншлэл гэдэг ойлголт нь арав, хорь, гуч, дөчин жил үргэлжилдэг урт удаан хугацааны хамтын үйл ажиллагааг хэлдэг. Тэрнээс биш гүйцэтгэгч тал “халтар хултар” ажиллачихаад, богино хугацаанд өндөр ашиг олно гэсэн үг биш .

Х.ХУЛАН

ТХХТ-ийн суурь зарчим

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг тодорхой хэмжээнд татах замаар дэд бүтцийн салбарын зарим асуудлыг шийдвэрлэх туршлагыг дэлхийн хэмжээнд ашигладаг. Дэд бүтцийн салбарын төр, хувийн хэвшлийн түншлэл манай улсад хэрэгцээтэй байгааг төр, бизнесийн салбар, олон улсын байгууллагууд санал нэгтэйгээр дэмжиж байна. Гэхдээ үүнд анхаарах нэг зүйл бий. »



Денверийн нисэх буудал

Түншлэлийн гэрээгээр хийх ажил нь заавал олон нийтийн эрх ашгийг тусгасан байх ёстойг УХШХ-ны Хувийн хэвшил, инновацийн бодлогын хэлтсийн дарга Б.Арвинбаяр ярьсан. Өөрөөр хэлбэл, нэг талаас бизнесийн сонирхолтой хувийн хэвшлийн, нөгөө талаас олон нийтийн эрх ашиг байна.

Түншлэл гэдэг ойлголт нь арав, хорь, гуч, дөчин жил үргэлжилдэг урт удаан хугацааны хамтын үйл ажиллагааг хэлдэг. Тэрнээс биш гүйцэтгэгч тал "халтар хултар" ажиллачихаад, богино хугацаанд өндөр ашиг олно гэсэн үг биш аж. Энэ тухай Мелбурны их сургуулийн хуулийн магистрант Д.Мөнхтуяа "Эрчим хүч нь маргаангүй нийтийн эрх ашгийг тусгасан стратегийн салбар мөн. Концессын зүйлийн жагсаалтад төр, хувийн хэвшлийн зарчмаар цахилгаан станц барих төслүүд орсон байгаа" гэв.

Харин эрчим хүчний төр, хувийн түншлэлээр хэрэгжих цахилгаан станцын хувьд хамгийн үр ашигтай технологийг хэрэглэх шалгуур цензурыг тавих ёстойг Б.Арвинбаяр онцоллоо. Энэхүү стандарт, шаардлагыг төрийн зүгээс тогтоох аж. ТХХТ-ээр хэрэгжүүлж, амжилтад хүрсэн гаднын туршлагаас товч танилцуулж байна.

Гадны туршлага

ТХХТ-ийг хэрэгжүүлсэн туршлагыг авч үзэхэд "бүтэлгүйтсэн" жишээнүүд нь гол төлөв улс төрийн эрсдэлийн улмаас үүдэлтэй байна гэж санхүүч Эндрю Х.Чен бичсэн байна. Тэрбээр "Хөрөнгийн зах зээл, даяаршил, эдийн засгийн хөгжил" номын "Төслийн санхүүжилт" хэсэгт энэ тухай дэлгэрэнгүй өгүүлжээ. Түүний дурдсан жишээнүүд хөгжиж буй орнуудад тохиожээ. Тухайлбал, Энэтхэгийн Махарашта мужид "Энрон" корпорацийн 2.9 тэрбум ам.доллараар барьсан цахилгаан станц үүний нэгэн жишээ болсон аж.

Гэхдээ ТХХТ-ийн зарчмыг эрчим хүчний салбарт амжилттай хэрэгжүүлсэн түүх, төслүүд ч дэлхийн хэмжээнд цөөнгүй байдаг. Б.Заяабал даргын ярилцлагадаа дурдсан эрчим хүчний салбарт үр дүнтэй хэрэгжсэн дараах хоёр жишээг дэлгэрүүлэн сонирхуулж байна.

1. Денверийн Олон улсын нисэх онгоцны буудлын дэргэдэх нарны эрчим хүчний систем

Та "Ногоон нисэх буудал" гэж сонсож байсан уу? Ногоон эдийн засаг, ногоон хот, ногоон хөгжил гэхчлэн олон холбоос байдаг. Дэлхий нийтээрээ энэхүү "ногоон" чиглэл рүү явах үед онгоцны буудлууд хүртэл цаана чинь "ногоорч", байгаль орчинд хувь нэмрээ оруулах боллоо.

АНУ-ын Денвер хотын олон улсын нисэх буудал нь дэлхийд эхний аравт жагсдаг. Жилдээ 50 сая зорчигчид үйлчилдэг энэхүү нисэх буудал нь дэргэдэх гурван га /7.5 акр/ талбайдаа төр, хувийн хэвшлийн түншлэлээр эрчим хүч гаргаж авах системийг 2008 онд суурилуулжээ. Энэхүү систем нь хоёр мВт-ын хүчин чадалтай бөгөөд жилдээ 3.5 сая гаруй кВт.ц сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэдэг. Улсынхаа хамгийн нарлаг хотод /жилд гурван мянган нартай цаг/ оршдог нисэх буудал нь "Sharp" компанийн 9200 нарны панелийг суурилуулжээ. Цахилгаан гаргах систем нь 13 сая ам.долларын өртөгтэй. Тус онгоцны буудал Денвер хотын төвөөс 40 км зайтай оршдог аж. Сэргээгдэх эрчим хүчний систем нь онгоцны буудлын жилд гаргах нүүрсхүчлийн хийг 2,268 тонн буюу 6.3 сая англий паундаар бууруулсан байна. Тус систем нь Денверийн олон улсын онгоцны буудлын жилийн эрчим хүчийн хэрэгцээний зургаан хувьтай тэнцэж байна.



2. Бангладешийн Мегнагатын цахилгаан станц

150-иад сая хүн амтай Бангладешийн эдийн засгийн өсөлт, ядуурлыг бууруулах үйл явцын чөдөр нь олон жилийн турш эрчим хүчний хангамжийн асуудал байсаариржээ. 1990-ээд оны сүүл үе хүртэл хүн амын 30-аас бага хувь нь эрчим хүчээр хангагддаг гэсэн мэдээлэлтэй байв. Эрчим хүчний салбарын хоёрхон гол компанитай байсан тус улс эдүгээ төр, хувийн хэвшлийн түншлэлээр 360 мВт-ын хүчин чадал бүхий Харипурын болон 450 мВт-ын Мегнагатын цахилгаан станцуудыг амжилттай ашиглалтад оруулжээ. Тус хоёр цахилгаан станц улсынхаа нийт эрчим хүчний 30-аад хувийг үйлдвэрлэж, олон сая хүний эрх ашигт нийцүүлэн үйл ажиллагаагаа найдвартай явуулж байна.

Мегнагатын цахилгаан станцыг барих-өмчлөх-ашиглах концессын төрлөөр төр, хувийн хэвшил хамтран хэрэгжүүлжээ. Дака хотоос 22 км зайд орших тус станцад 289.6 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийсэн байна. Концессыг Америкийн AES корпорацид олгосон бөгөөд Азийн хөгжлийн банкнаас зээл шууд олгохоос гадна эрсдэлийн батлан даалт 70,0 сая ам.долларыг баталсан байна. AES корпораци 2003 онд цахилгаан станцыг англиийн CDC Globeleq компанид зарсан бөгөөд шинэ эзэмшигч Бангладешийн Эрчим хүчний агентлагтай 22 жилийн төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээг шилжүүлэн авчээ.

Аливаа төслийн хэр сайн хэрэгжих нь боловсруулсан төлөвлөгөө, үндсэн болон дагалдах гэрээ, бодлогын дүн шинжилгээнээс ихээхэн шалтгаалдаг. Мегнагатын цахилгаан станц байгаль орчинд нөлөөлөх үнэлгээгээ маш тодорхой хийсэн. Үүнд цаг уурын нөхцөл, ус судлал, агаарын шинж чанар, нийгэм эдийн засгийн суурь судалгааг оруулсан байна. Урьдчилсан судалгааг хийснээр талууд эрсдэлээ нарийн тооцдог. Эрчим хүчний салбарын төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэхэд зөвхөн тухайн салбарын бус, харин олон талын мэргэжилтэн оролцож, тал бүрийн зөвлөмж, дүгнэлтийг хамтран бэлтгэж байж бүрэн хэмжээний төсөл болдгийг харуулж байна.

Бангладешийн цахилгаан станцын энэхүү төсөл төр, хувийн хэвшлийн цахилгаан станцыг хэрхэн төлөвлөж, хэрэгжүүлдгийг харуулсан үлгэр жишээ болсон нь техник технолог төлөвлөлтөө сайн гаргасан нь нөлөөлсөн. Энэ тал дээр манай улсад суралцах зүйл олон байгаа билээ. ■



Мегнагатын станц

"MONGOLIAN ECONOMY" СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ

-Эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтын орчин хэр бүрдсэн гэж Та бодож байна вэ?

-Энэ салбарын цаашдын хөгжлийг хэрхэн төсөөлж байна вэ?



Ц.БАЯРБААТАР /Эрчим хүчний газрын дарга /

Эрх зүйн орчин 100 хувь бүрдсэн гэж хэлэх болоогүй

Манайд эрх зүйн орчин 100 хувь бүрдсэн гэж хэлэх хараахан болоогүй. Нэмж хийх зүйл нэлээдгүй байна. Жишээлбэл, гаднаас цахилгаан худалдан авах, худалдах гэрээний орчин бүрдээгүй. Манай хэрэглээ нэг болохоор дутмаг, эсвэл жаахан ачаалал нэмэгдэхээр илүү гарчих гээд байх жишээтэй.

Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр гадаадынхан хөрөнгө оруулалт хийе гэхэд үнэ тариф тодорхой гараагүй. Засгийн газраас Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль гарсан боловч зохицуулалтын асуудлуудыг тодорхой нарийн зааж өгөөгүй байна. Засгийн газраас хэдэн хувийг татаасаар өгөх, иргэдээс хэдэн хувийг нь гэдэг тодорхой гараагүй байна. Ямар сангаас хэн бүрдүүлээд, хэн хуримтлуулж, зохицуулалтыг яаж хийх нь тодорхой биш гэсэн үг.

Эрчим хүчний салбарын хөгжил 1980 оны сүүл 1990 оны дунд хүртэл нэлээд урагштай явсан ч 20 жил хаягдсан. Одоо эргээд салбарыг хөгжүүлэх тухай яриаг идэвхжүүлснээр ойрын 10-20 жилд эрчим хүчний салбар хөгжлийн шинэ түвшинд гарах гэж байна. Үүн дотроо уламжлалт станцуудыг барих, ус, салхины эрчим хүчийг шинэ түвшинд аваачих бүтээн байгуулалтын томоохон ажил хийх гэж байна. Үүнтэй уялдуулж манай улс хөндлөн, босоо чиглэлд эрчим хүчнийхээ системийг өргөтгөх ажлыг мөн эхлээд байна.



Р.ГАНЖУУР /*Монголын эрчим хүчний инженерүүдийн холбооны ерөнхийлөгч* /

Цоо шинэ хөгжлийн бодлого, шинэчлэлийг шаардаж байна

Манайд эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтын орчин тодорхой биш байна. Тиймээс ч хөрөнгө оруулалтгүй байгаа гэж хэлж болно. Үнэхээр ямар нэг компани, байгууллага хөрөнгө оруулалт хийлээ гэхэд эргээд нөхөх боломжгүй байдалд ордог. Өнөөдөр манайд хувийн салбараас "Ньюком" компани л ганцаараа энэ салбарт хөрөнгө гаргаж байгаа. Түүнчлэн эрчим хүчний асуудал Сангийн яам, ЭБЭХЯ, Төрийн өмчийн хороо гэсэн гурван газар хуваагдаж, хүчээ тарамдсан байдалтай явж байна.

Юун түрүүнд төрийн өмчит хувьцаат компанийнхаа хувьцааг зах зээлд гаргах шаардлага тулгараад байна. Ингэснээрээ олон нийтийн өмчит болж, хяналт тавьдаг болно. Жишээ нь, ТЭЦ IV гэхэд 51 хувийг төрийн өмч давамгайлсан, харин 49 хувийг нь хөрөнгийн бирж дээр хувьцаа болгон гаргах хэрэгтэй. ОХУ-ын Эрчим хүчний агентлагаас гаргасан судалгаагаар манай эрчим хүчний салбар хөгжлөөрөө дэлхийн 137 орноос 117-д явж байна. Энэ нь хөгжлийн хувьд доогуур буйг л харуулсан үзүүлэлт. 1990 оноос хойш 20 гаруй жил хуучин бүтэц, хуучин бодлогоороо явж байгаа гэхэд хилсдэхгүй.

Одоо цаг үе биднээс цоо шинэ хөгжлийн бодлого, шинэчлэлийг шаардаж байна. Цаашдаа эдийн засаг өсч, үйлдвэрлэл үйлчилгээ нэмэгдэх тусам илүү их эрчим хүчийг шаардах болно. Хэрэв бид эрчим хүчний эх үүсвэрээ боломжит нөхцөлөө ашиглан шийдэж, салбарын удаашралтай бодлогоо дээшлүүлэхгүй бол эргээд эдийн засгийн хөгжлөө хазаарлах нэг хүчин зүйл болох юм.



Б.БЯМБАСАЙХАН
/Ньюком группын гүйцэтгэх захирал/

Бүс нутагтаа цэвэр эрчим хүчний манлайлагч болъё

-Манай эрчим хүчний салбарт хууль эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр бүрдсэн. Гэхдээ үүнийг нэмэгдүүлэхэд шаардлагатай нэг чухал хүчин зүйл бол эрчим хүчний бие даасан зохицуулалт үгүйлэгдэж байна. Тиймээс энэхүү эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоогоо улам боловсронгуй, үр ашигтай болгохын төлөө л ажиллах хэрэгтэй болов уу. Эрчим хүч эдийн засгийн суурь, үндэс. Цахилгаан, дулаанаа өөрсдөө үйлдвэрлэх нь эдийн засгийн хөгжлийн баталгаа, аюулгүй байдлын тулгуур юм. Ойрын арван жилд энэ салбарт томоохон хөрөнгө оруулалт хийгдэж, их бүтээн байгуулалт өрнөнө.

Монгол бол эрчим хүчний диваажин гэж би боддог. Хүмүүс Монголын баялгыг газрын хэвлийд, хөрсөндөө байна. Манай эх орны нийт газар нутгийн 80 хувьд нь нүүрс бий гэдэг. Харин би хувьдаа Монголын баялаг газар дээрээ байна гэж үздэг. Бүтээлч, эрч хүчтэй, өөдрөг мөрөөдөлтэй монгол хүн манай баялаг. Харин салхи, нар нь байгалийн бидний баялаг. Сэргээгдэх эрчим хүчний үндэсний лабораториос гаргасан судалгаагаар, Монгол Улс нь жилдээ 2550 тераВатт эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадал бүхий сайн, маш сайн хэмээн үнэлэгдэх салхины нөөцтэй гэж тогтоогджээ.

Хөдөө орон нутгийг эрчим хүчээр хангахуйц дунд зэргийн салхины нөөцийг энэ тоон дээрээ нэмбэл, Монгол Улс жилдээ 8123 тераВатт хүртэл эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай гэсэн тооцоо бий. Энэ нөөцдөө тулгуурлан бид эдүгээ хоёр дахь салхин цахилгаан станцынхаа Техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг боловсруулж байна. Энэ бол 300 мВт-ын хүчин чадалтай станц байх юм. Шавхагдашгүй нөөцөө ашиглан эрчим хүч үйлдвэрлэж, зөвхөн дотооддоо бус, нийт бүс нутгаа цэвэр эрчим хүчээр хангах бодит боломж бий.

“Азийн эрчмийн супер сүлжээ” гэж төсөл санаачлагдаад эдүгээ ид яригдаж байна. Монголын их говиос эхтэй бүс нутгийг хамрах сүлжээ юм л даа. Азийн эрчмийн супер сүлжээ бол мөрөөдөл биш, энэ бол бодит санаа, хэрэгжих боломжтой, хэрэгжүүлэх шаардлагатай төсөл. Монгол энэ төслийн нэн чухал оролцогч байх болно. Эрчим хүчээ цэвэр эх үүсвэрээр үйлдвэрлэж, бүс нутагтаа цэвэр эрчим хүчний манлайлагч болох ирээдүй бол Монголын ирээдүй, бидний зорилго.



Ц. ТҮМЭНЦОГТ
/Женерал Электрик компанийн Монгол дахь Суурин төлөөлөгч/

Цахилгаан хангамжийг шийдэж байж л хөгжих боломжтой

Эрчим хүчний тухай хууль 2011 онд батлагдсанаар эрчим хүчний салбар бие даасан, хараат бус байдалтай болж чадсан. Гэхдээ цаашид илүү боловсронгуй болгох шаардлага, тулгамдсан асуудлууд олон бий. Үнэ тарифаа боловсронгуй болгох, зах зээлийн харилцаанд нийцүүлж, шилжүүлэх ажил явагдаж байна. Энэ зорилтдоо 2015 он гэхэд хүрэхээр төлөвлөж байгаа. Манай эрчим хүчний салбарт томоохон хөрөнгө оруулалт орж ирэхгүй байгаа. Тиймээс ядаж уул уурхайгаас гарч буй орлогоо эрчим хүчний салбартаа шингээх шаардлага байгаа юм. Бид өнөөдөр дулааны хэрэгцээг хангаж чадахгүй байдалтай сууж байна. Мөн говийн бүсэд ч цахилгаан байхгүйгээс үйлдвэржилтэд саад учирч эхэллээ. Тиймээс юун түрүүнд цахилгаан хангамжийн асуудлыг ул суурьтай, зөв тийш нь шийдэж байж л хөгжих боломжтой. Жишээ нь, нар, салхины эрчим хүчний үйлдвэрлэгч болох боломж бидэнд бий. Цаашид ирээдүй гэрэлтэй харагдаж байгаа ч шийдэгдээгүй олон асуудал өмнө байна.



М.ЧИМЭД
/MCS группийн тэргүүн дэд захирал/

Эрчим хүчний салбарын эрх зүйн орчин гэж тусгайлан бодож боловсруулсан баримт бичиг тогтоол, хууль байгаа боловч сайн мөрдөгдөхгүй байна. Энэ нь тухайн үеийн Засгийн газрын бодлогоор зохицуулагдах тал байгаад байна. Эрчим хүчний салбар нь хэрэглэгчдэд ус агаар мэт хэрэгцээтэй нь ойлгомжтой. Тийм болохоор хөгжиж л таараа гэсэн өөдрөг үзэлтэй явдаг. Гэвч сүүлийн 20-иод жилд энэ салбарт дорвитой хөрөнгө оруулалт хийсэнгүй. Мөн энэ хугацаанд салбарыг удирдаж байсан буюу удирдаж буй нөхдүүд санаачилга муутай ажиллаж байгаагаас улс тэр чигээрээ эрчим хүчний гүн дутагдалд ороод байна. Эрчим хүчний хөгжлийн бодлого буюу мастер төлөвлөгөө байгаа авч түүнийгээ мөрдөж хэрэгжүүлдэггүй дутагдал байна. Тэгэхээр цаашид энэ чиглэлд хурдацтай ажиллах шаардлагатай. ■

Ч.ОТГОЧУЛУУГИЙН БУЛАН



ЛИБЕРАЛ МОНГОЛ + ЦАХИЛГААНЖУУЛАЛТ = КАПИТАЛИЗМ

Үзэл суртлаараа хуваагдсан хүйтэн дайны үед БНМАУ ЗХУ-аа олон юм авсан бас хуулсан. Эрчим хүчний салбарт өнөөдөр ч энэ энерц хэвээр байгаа юм.

Монголчууд хоёр дахь мянганы босгон дээр “Зууны манлай” нараа тодруулсан. Түүн дотор харин “Зууны манлай хувьсгалч” гэж харагдаагүй. Хэрэв тодруулсан бол жанжин Сүхбаатар эсхүл Барон Унгерн шалгарах магадлал бий. Харин дэлхийн тавцанд “Зууны манлай хувьсгалч” гэвэл Ленинг гэх болов уу. Ази цустайг нь илтгэх хурц хар нүд, зальжин инээмсэглэл бүхий зургаараа түүхэнд үлдсэн Ленин гэж хэн байв?

Чинээлэг сэхээтний гэр бүлээс гаралтай Владимир Ильич Ульянов нь Швейцарь, Герман зэрэг Европын хөгжингүй орнуудад цагаачлан амьдарч байхдаа Ленин гэсэн нууц нэр (одоогийнхоор бол фейсбүүк, твиттер, мэйл, блог зэрэгт хэрэглэдэг никнейм) –ийн дор хаант засаг, хөрөнгөтөн ангийг эсэргүүцсэн хувьсгалч нийтлэл бичдэг байв. Хожим дэлхийн түүхэнд И.Ленин гэдэг нэрээр мөнхөрчээ.

Оргил цагтаа дэлхийн хуурай газрын зургааны нэгийг бүрхсэн социалист улсуудын холбоо буюу ЗХУ-ыг үндэслэгчдийн нэг нь Ленин юм. Дал орчим жил оршин тогтносон ЗХУ, коммунист удирдагч нарынх нь дэлхийн түүхэнд гүйцэтгэсэн үүргийг судлаачид олон янзаар тайлбарладаг. Зарим нь тариачны Орос орныг цөмийн зэвсэгтэй хэт их гүрний төв болгосон төдийгүй, дагуул орнуудаа бурангуй шашин суртал, язгууртны дарангуйллаас чөлөөлж нийтийн эрүүл мэнд, боловсрол, аж үйлдвэржилтийн хувьд дэвшилд хүргэсэн гэж үздэг. Түүний зэрэгцээ “ард түмний” нэр барин цуст аллага, дарангуйллыг өөгшүүлж, шашны болон сэтгэлгээний эрх чөлөөг боогдуулж байсны улмаас хожим АНУ-ын ерөнхийлөгч Роналд Рейган ЗХУ-ыг “Чөтгөрийн эзэнт гүрэн” гэж нэрлэсэн байдаг.

1920 оны өвөл Хятадын дарлалаас чөлөөлөх дайнд тусламж хүсч очсон Монголын төлөөлөгч нарт ленинистүүд “марксизм аж үйлдвэржсэн нийгэмд тохирох онол, гэхдээ та нар капитализмыг шууд алгасч болно, гол нь тусгаар улс байгууллаа гэхэд тэр чинь марксист байх ёстой” гэсэн тулгалт маягийн зөвлөгөөг өгсөн гэдэг. Ямартай ч Ленин хэмээх уран илтгэгчийн удирдсан Октябрийн хувьсгал зөвхөн Орос орныг биш харин бүх дэлхийг өөрчлөх ёстой гэсэн уриа Монголын тал нутагт олон арван жил цуурайтсан билээ.

Коммунист дагагч нартаа зориулсан гэрээслэлдээ Ленин хоёр зүйлийг онцлон захисан гэдэг. Эхнийх нь дээрэнгүй, сагсуу, мугуйд Сталиныг эрх мэдэл, албан тушаалаас нь авч хаях тухай байх бол, хоёр дахь нь төлөвлөгөөний комиссыг байгуулж, амины өмчийг хүлээн зөвшөөрсөн “Шинэ эдийн засгийн бодлого” гэгч хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарах ёстой аж. Гэвч зууны манлай “хор найруулагч” Сталин өөрийн тройка фракцынхныхаа тусламжтайгаар гэрээслэлийн утгыг саармагжуулж чадсан төдийгүй хожим Ленинээс ч илүү эрх мэдлийг гартаа хуримтлуулж чадсан юм.

Харин төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг байгуулах ажил нь ихэд балмад, зэрлэг аргаар хэрэгжиж эхэлж. Цагаан хаан болон бурханд итгэх ард түмний итгэлийг үгүй хийхэд нь өлсгөлөн туслах болно гэж коммунистууд тооцсон байдаг. Хуучин мөнгийг үнэгүйдүүлэхийн тулд зориуд олноор нь үйлдвэрлэж инфляцийг хэт зохиомлоор бий болгож байв. Банкуудыг толгой дараалан төрийн мэдэлд авч, эздийг нь хөөж гаргах эсвэл өмчийг нь хураах, цөлөх, буудан хороох ялыг бүх “пролетариудын өмнөөс” өгч байж.

Ленин тэргүүтэй большивекүүд эдийн засгийн цоо шинэ Марксист загварыг цогцлоож чадна гэсэн »



Шог зургийг А.Амарсайхан

итгэлтэй байв. Өлсгөлөн тариачдыг нэг бол уран илтгэлээр нэг бол өлсгөлөнгөөр буулгаж авч байснаас гадна тэдний зохион байгуулах авьяасыг дутуу үнэлж боломгүй. Улаан ба цагаан террористуудын хооронд үүссэн иргэний дайнд АНУ, Англи гэсэн гүрнүүд хаант засгийг дэмжиж орсон байдаг. Гэвч улаан армийг богино хугацаанд байгуулж цохилт өгч чадсан нь Лениний зохион байгуулах, уран илтгэх чадвартай нь холбоотой гэж харагддаг.

Дайнд сүйдсэн Орос орныг босгохын тулд ардын комиссаруудын зөвлөлөөс цахилгаанжуулалтын төлөвлөгөөг хамгийн анх баталсан бөгөөд энэ нь алдарт ...дугаар таван жилийн төлөвлөгөөнүүдийн эхлэл болсон юм.

Ленин чухам энэ үед "Зөвлөлт засаг дээр улс орны цахилгаанжуулалтыг нэмбэл Коммунизм гэдэг чинь тэр болно" гэсэн утга бүхий алдарт үгээ хэлсэн байдаг. Арван жилийн дотор 30 том цахилгаан станцыг холбогдох дэд бүтцийн хамт байгуулахаар төлөвлөж, улмаар гүйцэтгэсэн байна.

Сибириэр дамжин Ильичийн лампийг түгээх шугам Монгол руу дөхүүлэх ажил ч бас давхар хийгдсэн нь Монголын эрчим хүчний салбарын суурь болсон билээ. Үзэл суртлаараа хуваагдсан хүйтэн дайны үед БНМАУ ЗХУ-аас олон юм авсан бас хуулсан. Эрчим хүчний салбарт өнөөдөр ч энэ энерц хэвээр байгаа юм. Гэвч хувийн хэвшлийнхэн, ялангуяа хөдөө орон нутагт байгаа жижиг аж ахуйн нэгжүүдийн хувьд эрчим хүч толгойны өвчин болсон хэвээр байна.

Төр, засгаас эрчим хүчний шинэ эх үүсвэр болох V цахилгаан станцын талаар арван жил ярьж буй боловч бодит үр дүнг үзэх хугацаа тодорхойгүй байсан хэвээр байна.

Дулаан, цахилгааны станцууд нэг хэсэг гадны шууд тусламж болон төрийн татаасаар амь зогоож ирсэн. Өдгөө үнийн аажим чөлөөлөлтийн ачаар зах зээлийн зарчим руу шилжих эхлэл хийгдсээр байна. Гэвч томоохон хөрөнгө оруулалт хийх хэмжээнд хүрч бяд суусан нь үгүй. Хууль эрхзүйн шинэчлэлийг гаднынхны зөвлөлгөөг аван хийж байгаагийн дүнд, төрөөр өлгийдүүлж, татаасаар тэтгүүлсэн төрийн өмчит компаниудтай өрсөлдөхөөр орж ирэх хувийн компаниуд ч нэмэгдэх боллоо. Энэ гэхдээ тайвшрах шалтгаан биш.

Шинээр байгуулагдах Засгийн газрын хамгийн чухал ажил нь эрчим хүчний салбарын загварыг тодорхойлж, төр ба хувийн хэвшлийн үүрэг ролийг илүү тодруулах шаардлагатай. Төр үйлдвэрлэгч байх юм уу, зохицуулагч байх юм уу? Татаасыг шууд үйлдвэрт нь өгөх үү, эцсийн хэрэглэгчид нь өгч зах зээлээ дэмжих үү гэсэн асуултын зоримог хариуг шуурхай олох ёстой. Лениний заасан замаар урагшилахгүй гэдэг нь тодорхой болсон. Гэвч өөрсдийн гэсэн "капиталист" зам байна уу? ■

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

МОНГОЛ УЛС ДЭЛХИЙН ЗҮРХ БОЛЖ ЧАДАХ УУ

Сэргээгдэх эрчим хүчний хөгжлийг салбарын болоод эдийн засгийн шинжээчид компьютерийн бизнесийн эрс өсөлттэй харьцуулан тайлбарлаж байна.

Э.ЗОРИГТ

Тогтвортой хөгжил. Эл үгс эрчим хүчний салбарт ч мөн адил чухал. Өдгөө бид эрчим хүчний хэрэгцээг хангахын тулд чулуужсан түлшнээс ихээхэн хамааралтай байгаа. Тухайлбал, Монгол Улс цахилгаан эрчим хүчнийхээ 90 хувийг нүүрснээс гаргаж авдаг гэсэн судалгаа бий. Мөн оргил ачааллын үед хойд хөршөөсөө эрчим хүч авдаг. Энэхүү хамаарал нь Монгол Улсын эрчим хүчний аюулгүй байдлыг бууруулдгийг мэргэжилтнүүд хэлж, анхааруулсаар. Тэгвэл энэ нь тогтвортой хөгжил мөн үү.

Эрчим хүчний зохицуулах хорооны дарга Т.Цэрэнпүрэв “Эрчим хүчний тогтвортой хөгжил гэдэг нь хэрэглэгчдийг найдвартай эрчим хүчээр хангах явдал юм. Хаана, хэзээ, хэнд эрчим хүч хэрэгтэй байна тэр газарт эрчим хүч найдвартай хүрэх ёстой. Гэхдээ энэ нь анхан шатны шаардлага. Харин ирээдүйд эрчим хүчний салбар хэрхэн хөгжих асуудал улс орон бүрийн өмнө тулгамдаж байна. Өөрийн улсад тохирсон эрчим хүчний тогтвортой хөгжлийг бий болгохын тулд бид дэлхийн эрчим хүчний чиг хандлага,улс орныхоо бодлого, стратеги, хөгжлийн загвартаа тулгуурлан хэрэгжүүлэх эрчим хүчний шинэ бодлого гаргах хэрэгтэй” гэв.

Дэлхийн эрчим хүчний чиг хандлага ямар байна вэ?

Өнөөдөр дэлхий нийт ногоон өнгөнд “хайр зарлаад” байна. Эгэл жирийн иргэнээсээ аваад төрийн тэргүүнээ хүртэл ярьдаг хамгийн чухал сэдэв боллоо. Тэр тусмаа дэлхий нийт эрчим хүчний салбарыг ногоон болгохыг зорьж, сэргээгдэх эрчим хүч түлхүү ашиглах зорилгыг өмнөө тавьж байна. Тухайлбал, Олон улсын сэргээгдэх эрчим хүчний агентлагаас гаргасан тооцоогоор 2050 он гэхэд дэлхийн нийт эрчим хүчний 50 орчим хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс гарган авна гэжээ.

2008 оноос хойш дэлхийн улс орнууд цэвэр эрчим хүчийг түлхүү ашиглах болж, нийт эрчим хүчний 20 орчим хувийг сэргээгдэх эрчим хүчнээс гаргаж авсан байна. Энэ тоо жил ирэх тусам өсөн нэмэгдсээр байгаа юм. Тухайлбал, Японы Фүкүшимагийн ослын дараахан тавдугаар сард ХБНГУ цөмийн эрчим хүчнээс татгалзаж, өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэглээгээ сэргээгдэх эрчим хүчээр шийдэхээ илэрхийлсэн. Японучууд байгальд ээлтэй эх үүсвэрээс хангах том зорилго дэвшүүллээ. Энэ бүгдээс улбаалаад сэргээгдэх эрчим хүчний хөгжлийг салбарын болоод эдийн засгийн шинжээчид компьютерийн бизнесийн эрс өсөлттэй харьцуулан тайлбарлаж байна.

Манай улс ирээдүйн эрчим хүчний хэрэгцээгээ сэргээгдэх эрчим хүчээр хангах боломж бүрэн бий. Нарны эрчим хүчний нөөцөөрөө дэлхийд хоёрдугаарт ордог говьтой шүү дээ, Монгол орон. Мөн эрчим хүчний нөөц асар их бий. /Графикаас харна уу/ Эдгээр нөөцийг бага багаар ашиглаж эхлээд байна. Тухайлбал, “Ньюком” группын 50 мВт-ын анхны “Салхит” салхин станц, 2000 оноос хойш хэрэгжсэн “100.000 нарны гэрэл” төсөл зэргийг дурьдаж болох юм. Энэ бол ердөө эхлэл.

Монгол Улс эрчим хүчний диваажин орон болох боломж бидний

Дэлхийн нийт эрчим хүчний 16 хувийг сэргээгдэх эрчим хүчнээс гаргаж авдаг. Үүнээс

Биомасс	10 %
Том чадлын усан цахилгаан станц	4.3 %
Нар, салхи, болон бусад эх үүсвэр	3 %

Эх сурвалж: Эрчим хүчний газар

Монгол Улсын эрчим хүчний үйлдвэрлэл

Усан цахилгаан станц	0.3%
Дизель станц	1.3%
Оросоос импортлох эрчим хүч	8.1%
Салхины эрчим хүч	0.2%
Нарны эрчим хүч	0.25%
Дулааны цахилгаан станц	89.85%

Эх сурвалж: Эрчим хүчний газар



өмнө нээлттэй. Гэхдээ юманд учир, суманд занги бий. Ганц талыг барьж туйлшралгүй бүх төрлийн эрчим хүчний эх үүсвэрийг өөр хооронд нь уялдуулж ашиглах ёстой. Уламжлалт аргаас эхлээд сэргээгдэх эрчим хүчний зөв зохистой уялдаа холбоог олох хэрэгтэй болов уу.

“Манайд нар, салхи гэх сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр хангалттай бий, үүнийгээ хөгжүүлэх хэрэгтэй. Эдгээрээс усан цахилгаан станцыг түлхүү хөгжүүлэх нь бүр илүү чухал асуудал юм. Учир нь, том чадлын усан цахилгаан станц нь эрчим хүчний тогтвортой хөгжлийн зорилт болох хэрэглэгчдийг эрчим хүчээр найдвартай хангах шалгарсан арга” хэмээн Т.Цэрэнпүрэв дарга онцолсон.


Улстөрждөг ус

Монгол Улс цахилгаан, дулааны долоон станцтай бөгөөд жилдээ дөрвөн тэрбум кВт.ц эрчим хүч үйлдвэрлэдэг. Харин оргил ачаалалын үеэр тодорхой хэмжээний цахилгааныг ОХУ-аас 40-өөд жилийн туршид импортолсоор ирсэн билээ. Нэг л жишээ дурдахад, эрчим хүчний системийн оргил ачаалал 2010 онд 728 мВт-д хүрэхэд дулааны цахилгаан станцууд бүрэн хүчин чадлаараа ажиллаад дийлэхгүй байсан тул оргил ачааллыг хаахын тулд хойд хөршөөс 70 мВт эрчим хүч импортлоход хүрсэн аж.

Манай орны хэтийн хөгжлийн чиг хандлагаар 2020 оны түвшинд оргил ачаалал 1128 мВт-д хүрэх төлөвтэй гэнэ. Энэ хугацаанд ТЭЦ-үүд ашиглалтад орох хэдий ч хурдтай өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэглээг бүрэн хангаж чадахгүй юм байна. Тэгвэл яах вэ. Энэ талаар ЭБЭХ-ний сайд Д.Зоригт “Эрчим хүч төдийгүй бүх л зүйл даяаршиж байгаа энэ үед ОХУ-аас цахилгаан экспортлох нь тийм ч муу зүйл биш. Гэхдээ эрчим хүчний тогтвортой хөгжлийн үүднээс аваад үзэхэд бид эрчим хүчний уг хамаарлыг багасгах хэрэгтэй. Үүний тулд том чадлын усан цахилгаан станцын ажлыг яаравчлах ёстой” гэсэн юм.

Уг нь үе үеийн Засгийн газар 2000 оноос хойш л Орхон, Эгийн гол, Сэлэнгэ мөрний сав газарт их чадлын усан цахилгаан станц барих талаар ярьсаар ирсэн билээ. Харин энэ бүхэн ажил хэрэг болсон зүйлгүй улстөржөөд дуусдаг уламжлал тогтсон. Эхэн үед нутгийн иргэдийн дунд усан цахилгаан станц барих юм бол өнө эртний түүх домогтой гол мөрөн сүйдэж, тахиж ирсэн лус савдаг нь догширох гэх мэт олон жил бугшсан өрөөсгөл ойлголт энэ талын хөгжилд саад болж байсан. Харин Тайшир, Дөргөний усан цахилгаан станц ажиллаж, үр ашгаа өгч эхэлснээс хойш иргэдийн ойлголт өөрчлөгдсөн гэж хэлж болох.

Сүүлийн үед Сэлэнгэ мөрний сав газарт цуваа усан цахилгаан станц барих талаар идэвхтэй ярьж байна. Энэ удаа том чадлын усан цахилгаан станц барих бидний мөрөөдөл биелж магадгүй гэсэн горьдлого эрчим хүчний салбарынханд бий болжээ. Учир нь, Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Кувейт улсад айлчлах үеэрээ Сэлэнгэ мөрний сав газарт усан цахилгаан станц барих төсөл дээр харилцан хамтын ажиллагаа бий болгох талаар ярьсан нь найдлага дагуулаад буй хэрэг. Одоогоор уг ажлын хүрээнд Эрчим хүчний зохицуулах хорооноос ТЭЗҮ-ийг боловсруулах техникийн даалгаврыг хийж байгаа аж. Хэрвээ техникийн



Монголын нийт газар нутгийн 10 хувь (160000км²) нь салхины өндөр нөөцтэй болох нь тогтоогдсон

даалгаврын ажил амжилттай, шуурхай дуусвал ТЭЗҮ боловсруулахад бэлэн болох юм.

ЭБЭХ-ний дэд сайд Т.Энхтайван “Монгол Улс бараг хөндөгдөөгүй байгаа усны эрчим хүчний баялгаа эдийн засгийн эргэлтэд оруулснаар 100 жилийн хоцрогдлоосоо зургаан жилийн дотор гарах бүрэн боломжтой” хэмээн хэвлэлд өгсөн ярилцлагадаа хэлсэн байдаг. Салбарын ажилтнуудын мөрөөдөл биелэх аваас Монгол Улсын эрчим хүчний тогтвортой байдал тодорхой хэмжээгээр баталгаажих юм. Нэгэнтээ эрчим хүчний тогтвортой хөгжлийн талаар тогтож ярьсных мэргэжилтнүүдийн зүгээс ярьсан зарим нэг асуудлыг энд хөндөх нь зүйтэй болов уу.

1. Хүний хэрэгцээг хангах эд материалын болоод бусад бүх зүйл эдийн засгийн эргэлтэд ордог болсон өнөө үед эрчим хүч ч ялгаагүй бизнесийн нэг томоохон салбар болсон. Энэ үүднээс нь аваад үзвэл манай орны эрчим хүчний салбарт гаднын болоод дотоодын хувийн хэвшлийнхнийг оруулж ирэх хэрэгтэй талаар салбарынхан саналаа хэлдэг. Хэдийгээр ТЭЦҮ, “Салхит”-ын салхин парк гээд эл салбарт ганц нэг хувийн хэвшлийнхний оролцоо бий болж байгаа ч тийм ч хангалттай бус байна. Угаас эдийн засгийн ухаанд хэдий чинээ олон өрсөлдөгч байна төдий чинээ хэрэглэгчид хождог гэх гаргалгаа бий. Энэ энгийн бөгөөд үр дүнтэй аргыг эрчим хүчний салбарт хэрэглэх цаг нь болсон гэдгийг бизнесийн салбарынхан санаулж байгаа.

2. Цэвэр эрчим хүчний экспортлогч орон болох. Энэ нь хэтийн боловч хэрэгжих боломжтой ажил гэдгийг тус салбарын мэргэжилтнүүд хэлсэн. Саяхан Япон улсад “2012 оноос хойшхи эрчим хүчний шинэ прадигм” сэдвийн дор олон улсын чуулган болсон. Уг чуулганд манай улстай цэвэр эрчим хүч экспортлох чиглэлээр Япон тэргүүтэй орнууд хамтран ажиллах сонирхолтой байгаагаа мэдэгдсэн аж.

3. Манай улсын эдийн засаг, эрчим хүчний салбар түүхий нүүрснээс хэт хараат гэдгийг дээр дурьдсан. Цаашдаа ч энэ байдал удаан үргэлжлэх төлөвтэй байна. Өдгөө дэлхий дахинаа түүхий нүүрснээс эрчим хүч гаргаж авдаг ихэнх цахилгаан станц байгальд ээлтэй технологийг хэдийнэ нэвтрүүлчихсэн гэнэ. Тиймээс эрчим хүчний салбарт технологийн “аустсорсинг” хийх хэрэгтэй аж.

4. Хэрэглэгчдийн эрчим хүчний зохистой хэрэглээ, энэ талын ойлголтыг өөрчлөх. Эрчим хүчний тогтвортой хөгжлийг эдийн засгийн болоод, төр, засгийн бодлогын хүрээнд авч үзээд ярьж байна. Гэхдээ энэ салбарын эрэлтийг бий болгож, оршин тогтнох нөхцлийг бүрдүүлж байгаа зах зээл бол яах аргагүй энгийн иргэнээс аваад томоохон үйлдвэр гэх мэт эрчим хүч хэрэглэгчид. Тиймээс тэдний үзэл бодол, эрчим хүчинд хандах хандлагыг өөр шатанд аваачих хэрэгтэй ажээ.

Эдгээр асуудлыг шийдэж чадвал манай эрчим хүчний салбар хэр баргийн салхинд унахааргүй тогтвортой хүчирхэг болж чадах ажээ.

Төгсгөлийн оронд

Эрчим хүч ч бай, эдийн засгийн өсөлт ч бай хамгийн гол нь иргэддээ наалдацтай, ирээдүй хойчдоо балаг тарихааргүй байлгахыг л дэлхий нийт эрмэлзэж байна. Эл эрмэлзлэлээ тогтвортой хөгжил, ногоон ирээдүй гэж нэрлээд байгаа юм. Тогтвортой ч бай ногоон ч бай эдгээр хөгжлийн гол агуулга нь өдөр ирэх бүр өсөн нэмэгдэж буй дэлхийн хүн амын хэрэгцээг яаж илүү эрүүл, байгальд ээлтэй технологит тулгуурлан бүтээх вэ гэдэгт оршиж байна. Харин үүн дээр эрдэмтэд, эдийн засагчид толгойгоо өвтгөсөөр.

Өнөөдөр дэлхий дээр байгаа эрчим хүчний уламжлалт, бусад хэрэглээг хангах бүх төрлийн нөөц 10 тэрбум хүнийг л арай ядан тэжээж чадна гэдэг судалгаа бий. Тэгвэл 2050 он гэхэд дэлхийн хүн ам 10 тэрбум давах тэр үед бид яах вэ. Хариултын нэг нь сэргээгдэх эрчим хүч тэргүүтэй байгальд ээлтэй шавхагдашгүй нөөцүүдийг ашиглах. Харин манай оронд тэр бүх шавхагдашгүй нөөц байна. Тиймээс эдгээр нөөцөө бид ухаалгаар ашиглаж чадвал ирээдүйд Монгол Улс дэлхийн зүрх болох юм. ■



НОГООН

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

НОГООН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ

ҮЗЭЛБОДОЛ

СОРИЛТ БА БОЛОМЖ



П.ТОВУУДОРЖ
/ЭБЭХЯ-ны Эрчим хүчний бодлогын газрын дарга/

Монгол орны эдийн засаг хурдацтай өсөж байгаа энэ цаг үед эрчим хүчний салбарын хамт олны өмнө шинэ сорилт, шинэ зорилт, шинэ шалгуур тулгарч байна. Улс орны эдийн засаг хурдацтай, тогтвортой хөгжихийн тулд эрчим хүчний салбар түүнээ нь болж түрүүлж хөгжих ёстой. Өнгөрсөн 90 жилийн түүхээс харахад манай ахмадууд эрч хүчтэй хөдөлмөрөөрөө Эрдэнэт, Дархан, Улаанбаатарын станцууд бүхий эрчим хүчний системийг цогцлуулж, дараа үедээ хүлээлгэн өгсөн. Энэ бол зүй ёсны бахархал мөн.

Харин одоо биднийг шинэ сорилт хүлээж байна. Өмнийн говь, Дорнын талд шинээр байгуулагдсан уурхайнууд, тэдгээрийг дагасан суурьшлын шинэ бүсүүдийг эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах том зорилт бидний өмнө тулгараад байна.Энэ зорилт нь эрчим хүчний салбар өргөжин тэлэх, санхүүгийн хувьд хөл дээрээ баттай зогсох том боломжийг давхар нээж өгч байгаа юм.

Мөн одоо ажиллаж буй эрчим хүчний үйлдвэрүүдийн дийлэнх нь 1960-1970-аад онд ашиглалтад орж, технологийн хувьд хоцрогдож хуучирсан нь үйлдвэрийн технологийг үе шаттайгаар шинэчилж өргөтгөн, насжилтыг уртасгах зайлшгүй шаардлага үүсэж байна. Нэг ёсондоо, амь тариа хийх шаардлага тулгарсан гэсэн үг. Өнөөдөр төрийн өмчит эрчим хүчний үйлдвэрүүд хэлбэрийн хувьд хувьцаат компани боловч агуулгын хувьд жинхэнэ утгаараа ажиллаж чадахгүй байна.

Тиймээс эдгээр компанийг хувьцаат компанийн жинхэнэ сонгодог загварт оруулж тодорхой хувьцааг нь олон нийтэд нээлттэй зарлаж public компанийн хэлбэрээр ажиллуулж, мөнгө босгон технологийн шинэчлэлт, өргөтгөл хийж насыг нь уртасгах, зах зээлийн өрсөлдөөн бий болгох, олон нийтийн оролцоо хяналтыг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг түлхүү дэмжиж, үнэ тарифыг шат дараатайгаар чөлөөлөх зайлшгүй шаардлага байна.

Цаг хугацаа биднийг хүлээхгүй, ажлаа эрчтэй, хурдацтай эхлүүлэх нь чухал. Бидэнд гашуун туршлага бий. 1990 оны эхнээс яригдсан Эгийн голын УЦС-ын хувь тавилан үе үеийн Засгийн газрын үед Орхон, Сэлэнгэ, Бүрэн, Шүрэнгийн станц болж өөрчлөгдсөөр одоо хүртэл нүдэнд харагдах зүйлгүй байсаар. Хэрвээ том чадлын усан цахилгаан станц баригдсан бол Монголын эрчим хүчний салбарт бодитой хувь нэмэр оруулах байсан нь гарцаагүй. Боломж хэзээд байдаг. Гагцхүү тэр боломжоо тухайн цаг хугацаанд нь олж ашиглаж байж бид бусадтай хөл нийлүүлэн хөгжинө. Бурууг шийдвэр гаргагчдаас биш өөрсдөөсөө хайж, салбарын талаар УИХ-аас баталсан бодлогын баримт бичгүүдээ (Мастер план, Эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр) шинжлэх ухааны үндэстэй шинэчлэн боловсруулж ажил хэрэг болгохын төлөө тууштай байж, хамтдаа зүтгэцгээе. Алив нэгэн улс төрийн хүчин, нам эвслээс үл хамаарсан эрчим хүчний хар хайрцагны бодлогыг салбарын хэмжээнд дархлан тогтоож, нэгдсэн нэг санаатай, хамтын удирдлагын зөв тогтоцтой, санхүү эдийн засгийн хувьд бие даасан зах зээлийн горимд нийцэж ажиллаж чадахуйц салбар болон хөгжихийн төлөө бид ажиллах ёстой.

Дэлхийн банк, Сити групп зэрэг байгууллагын судалгаанд Монгол Улсыг ойрын 10 жилд эдийн засаг нь хамгийн хурдацтай хөгжих орнуудын нэгээр нэрлэж байна. Нэгэнт түрхрэн эргэлдэж эхэлсэн Монгол дахь уул уурхай дагасан мөнгөний урсгалыг алсын хараатай хурц ухаанаар зөв чиглүүлж дотооддоо эрчим хүчний салбартаа боломжит хэмжээгээр шингээе, томоохон уул уурхайн компаниудад эрчим хүчээ зардаг болъё.

Эдийн засгийн өсөлтийг хангахуйц эрчим хүчний эх үүсвэртэй болж улмаар эрчим хүч импортлогчоос эрчим хүч экспортлогч орон руу шилжиж чадвал энэ нь зөвхөн манай салбарын түүхэн том ололт төдийгүй Монгол Улсын бие даасан, хараат бус байдалд чухал нөлөө үзүүлэхүйц ажил болж чадах билээ.

Монгол инженерийн оюун ухаан хүч чадлыг харуулсан шинэ бүтээл оновчтой санал санаачлагыг шат шатандаа дэмжин ажиллаж, юм хийж байгаа хүнийг зөв хөгжүүлж, шударга үнэлэх үнэлэмжийг дээшлүүлье. Салбарынхаа боловсон хүчний өрсөлдөх чадварыг чанаржуулъя, хүнээ хөгжүүлье.

Дэлхийн хөгжлийн чиг хандлагатай хөл нийлүүлж сэргээгдэх болон бусад эрчим хүчний эх үүсвэрийг өргөнөөр ашиглаж, тогтвортой эрчим хүчний хөгжлийг хангая. Монгол орон нар, салхи, усны их нөөцтэй орон. Энэ боломжоо ашиглаж, хүн төрөлхтний хөгжлийн чиг хандлагыг мэдэрч ажиллах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Эрчим хүчний салбарын өнгө бол улс орны өнгө төрх юм. Бид найдвартай ажиллаж хүчирхэг, зөв тогтоцтой эрчим хүчний салбарыг цогцлоож гэмээнэ Монгол орны маань хөгжил өнгөтэй, өөдтэй байна. Бид өөр өөрийнхөө эрхэлсэн ажилдаа хэр идэвх санаачилгатай, сэтгэлтэй ажиллахаас энэ бүх зүйл шалтгаална.

Сорилтыг боломж болгохын төлөө хамтдаа зүтгэцгээе. ■

СУРВАЛЖЛАГА

МОНГОЛ МАЛЧДЫН ШИНЭ ЭРИН

2000 оны нэгэн орой хөдөө нутгийн айл өрхүүд таван ханатдаа лаа бус цахилгаан гэрэл асаажээ. Аймаг, сумын төвөөс алс суух малчдын дунд Монгол Улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр “100 000 нарны гэрэл” хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн нь энэ.

Э.ЗОРИГТ

Хөдөө нутаг угаас эл хуль. Хонь хурга майлах, үхэр мөөрөх, нохой хуцахаас өөр чимээ бараг үгүй. Ойр зуурын хов жив ч ховорхон. Тал нутагтаа тарж буусан гэрийн эзэд хийгээд эзэгтэй нар хааяа нэг хонины бэлчээр, худаг, адууны эрэлд золоор таарч хол ойрын сонин хачин солилцоно. Хаа нэгтээ болсон хэрэг явдал хэдэн сар заримдаа жилийн дараа ч хөдөөгийн түмэнд хүрэх нь энүүхэнд.

Хөгжилт нийгмийн хөдөлгүүр болсон эрчим хүчгүйгээр хөдөө нутгийнхан хүний наад захын хэрэгцээг хэрэглэж чадахгүй нүдэн балай, чихэн дүлий нарнаар босож, бүрийгээр унтаж өдөр хоногийг уйтай өнгөрүүлэх. Хот газар эрдэм сурахаар явсан хэдэн хүүхэд нь ямар байгааг мэдэхээр тэд хааяа нэг сумын төв орж утас цохино. Ихэнхдээ ээжүүд тэнгэр газартаа сүү өргөж хүүгээ даатгах. Цаг хугацаа, орон зайн хүлээсэнд уягдсан малчид лаа асаан тэрлэг эсгэж, дүү нар ном уншина. Лаа унтарлаа. Нам жим хөдөө нутаг улам л чимээгүй.

Хуучин хүүгээс шинэ хүү болсон нь

Төв аймгийн Алтанбулаг сумын I багийн Цагаан бургастай нутгийн айлууд хаваржаандаа буучихсан, нялх төлийн дуу цангинаж, нар дулаан элчээрээ ээнэ. Хавар цагийн анхны яргуй дэлбээлээд модод гөлөглөж, хөдөө нутаг сэтгэл татам болжээ. Жижиг дов толгодын орой эхнээсээ ногоорч, хорвоо дэлхий бага багаар өнгө нэмсэн харагдана.

Д.Батчулууных Цагаан бургастайн хаваржаа, Баамын булгын өвөлжөө хоёрын хооронд 40 гаруй жил нутаглажээ. Тэднийх Ган-Од, Оюунтүлхүүр гэдэг хүү, охинтой. Сумын төвөөс 20 орчим км-ын зайтай байдаг тэднийх гучин жилийг лаатай өнгөрөөсөн гэнэ. Харин өдгөө Батчулууны гэрийн баруун хойморт байруулсан 15 инчийн зурагтаар дуучин Rhinna-ын “We found love” дуу эгшиглэнэ. Мөн зурагтны доод талд жижиг, том хоёр аккумлятор байх аж. Уг зай хураагчаас түмэн янзын цахилгааны утас салбарласан



байх бөгөөд бусдаасаа бүдүүн хоёр утас гэрийн хана дагаж баруун, зүүн хоёр баганад өдрийн болоод улайсдаг чийдэнд холбогдсон харагдана.

65 настай Батчулуун гуай анх 2002 оны үед “100 000 нарны гэрэл” төсөлд хамрагдсанаар гэрэл цахилгаантай залгажээ. Тэрбээр “Гэрэлгүй байх үед бид Д.Нацагдоржийн “Хуучин хүү” шигл байлаа шүү дээ. Мэдээ мэдээлэл гэх юмгүй. Хэдэн хүүхдүүд л хотоос ирвэл энэ тэндхийн сонин хачин сонсоно. Ноосны үнэ мэдэх гэж л хаа байсан сумын төв рүү морьтойгоо шогшиж хэл ул авалцана. Харин одоо өөрийн орны байтугай дэлхий дахины мэдээллийг зурагтаар аваад, болсон үйл явдлын талаар зарим нэгтэйгээ мэтгэлцэж байна” гэв.

Монголын малчид өнөөдөр алдсан адуу, хонинд явсан хүү, хүний бэр болсон охиныхоо сургийг хүссэн үедээ гар утсаараа авчихаж байна. Хөдөлмөр цаг хугацаа хэмнэсэн техник, технологийн үнэ цэнийг малчид бага багаар хүртэж байгаа нь энэ. Өдгөө 27 настай Б.Оюунтулхүүр бүсгүй “Миний багад гэрэл цахилгаан байхгүй гэрийн даалгавраа хийх хэцүү асуудал байсан. Малчдын ажил ямар барагдах биш. Нэг мэдэхэд л нар бууж, бүрий болчихно. Тэгээд лаа, дэнлүүний гэрэлд гэрийн даалгавраа хийнэ шүү дээ. Гэхдээ лаагаа байнга асаагаад байж бас болохгүй. Сумын төв орж авдаг болохоор лаагаа гамнах хэрэгтэй” гэж ярилаа. Харин Ган-Од хүү гэрэлгүйгээр өдөр хоногийг төсөөлж чадахгүй байгаагаа нуусангүй. Учир нь, тэр “Би найзуудтайгаа мессеж бичих утасгүй, сагсан бөмбөг үзэх зурагтгүй болно гэдэг байж боломгүй асуудал” гэсэн юм.

Энэ мэт техник технологийн хөгжлийг мэдэрч, хөдөлмөрөө хөнгөвчилж буй малчид хэдхэн жилийн дараа, малынхаа бэлчээрт IPad хэрэглэж, интернэтэд холбогдох биз ээ. Арван жилийн өмнө малчдын хониныхоо бэлчээрт гар утсаараа ярих мөрөөдөл биелсэн шиг дээрх мөрөөдөл ч төд удалгүй амьдралд буух цаг айсуй.

Буман нарны энэхүү төсөл олон мянган малчдын амьдралд эргэлт хийж, гэрэл цахилгаантай залгуулж, шинэ мянганы хөгжилтэй хөл нийлүүлэх боломж олгосон билээ.



Өөрөөр хэлбэл, шинэ эриний малчид хэмээн нэрлэгдэх тэр л хөгжлийн эхлэлийг “100 000 нарны гэрэл” төсөл тавьсан юм. Тухайн үедээ алдсан оносон олон үйл явдалтай учирч байсан ч өнөөдрийн өндөрлөгөөс харвал тэдний амьдралд ямартай ч гэрэл гэгээ авчирчээ. Монголын өргөн уудам газар нутгаар тархсан малчдын гэрийн гадна 2-3 машин, жижиг цагаан тавган антенн, нарны хавтан зооллттой харагддаг. Энэ бол энэ л төслийн үр дүн.

Гэрэл асссан түүх

2000 оны нэгэн орой хөдөө нутгийн айл өрхүүд таван ханатдаа лаа бус цахилгаан гэрэл асаажээ. Аймаг, сумын төвөөс алс суух малчдын дунд Монгол Улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр “100 000 нарны гэрэл” хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн нь энэ юм. Хамгийн сүүлийн буюу 2008 оноос хэрэгжсэн “Хөдөөгийн цахилгаан хангамж, малчдыг сэргээгдэх эрчим хүчээр хангах нь” нэртэй төслийн хүрээнд 25 мянган нарны эрчим хүчний эх үүсвэрийг тарааснаар арав гаруй жил үргэлжилсэн “100 000 нарны гэрэл” хөтөлбөр өдгөө бүрэн хэрэгжиж дуусаад байгаа юм.

Хөдөө нутагт гэрэл хүргэх ажил тийм ч амархан явагдаагүй гэдгийг төслийн багийнхан ярьж байна. Тухайлбал, нарны толь хэрэглэж байгаагүй малчид аккумляторoо хөлдөөх, суулгах, нарны толио буруу байршуулах гээд мэдэхгүй асуудалтай мундахгүй тулгардаг байсан гэнэ.

Тус төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын малчин өрхүүдийг бараг 100 хувь гэрэлтэй болгочихоод байгаа аж. Та гайхаж магадгүй. 170 гаруй мянган малчин өрхтэй Монголд 100 мянган нарны гэрэл тараачихаад яагаад 100 хувь гээд байна гэж. Учир нь, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн өмнө төслийн баг хөдөө орон нутагт судалгааг нэлээд сайтар явуулсны үр дүнд 100 мянга гаруй малчин өрх XXI зуунд лаатай амьдарч байгааг тогтоожээ. Бусад нь ямар нэг байдлаар эрчим хүчний эх үүсвэрт холбогдсон байжээ.

Хөргөгчтэй болох мөрөөдөл

Хэдийгээр өнөөдөр малчид мэдээ мэдээллээр хангагдах жам ёсны эрхээ эдэлж байгаа ч олонх нь хөргөчинд махаа хөлдөөж, тоос сорогчоор хогоо соруулж, чадахгүй байна.

Энэ талаар Эрчим хүчний газрын Сэргээгдэх эрчим хүчний хэлтсийн дарга Ч.Батбаяр “Малчдыг гэрэлтэй болгох анхан шатны төслийн хүрээнд малчин өрхүүд нарны зай ашиглах тал дээр туршлагажиж, гэрэл цахилгааны үнэ цэнийг ойлгосон. Тиймээс малчдын дунд илүү үр ашигтай төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлага гарч ирж байна. Тухайлбал, малчдыг хөргөгчжүүлэх явдал юм. Зуны урин дулаан цагт малчид махаа богино хугацаанд идэхээс өөр аргагүй байдаг. Тиймээс Засгийн газар болоод холбогдох байгууллагууд энэ тал дээр анхаарах хэрэгтэй” гэв. Тэгэхлээр “100.000 хөргөгч” төсөл хэрэгжил цаг тун удахгүй нь гээд хэлчихэд хилсдэхгүй болов уу. ■

НОГООН ӨСӨЛТ

АЗИЙН ЭРЧМИЙН СУПЕР СҮЛЖЭЭ БА МОНГОЛ

Азид ийм сүлжээ байгуулагдсанаар хөгжлийн ирээдүйн гарц цэвэр эрчим хүч хэмээн тодорхойлсон дэлхийг хэрсэн сүлжээ бий болох аж.

Д.БЭХ


Европчууд Сахарын цөлийг ашиглаж, улс орноо байгальд ээлтэй эрчим хүчээр хангах бодлого явуулж байна. Хүн амьдрахын аргагүй энэ халуун газар дэлхийг тэтгэх гэрэл цахилгааны асар их нөөцийг агуулж байна. Африкийн хойд хэсгийн цөлийн нөөцийн гуравны нэгийг л ашиглахад Европ тивийг бүхэлд нь эрчим хүчээр хангана гэж судлаачид үзжээ. Гайхалтай байгаа биз. Өндөр технологи, асар их хэмжээний хөрөнгө мөнгө, хөдөлмөр шаардсан ажлыг европчууд хэдийнэ эхлүүлж, нарны хавтангуудыг байрлуулчихжээ.

Тэгвэл Монголын говь бас өөрийн баялгаа гайхуулсаар. Сахарын дараа орох сэргээгдэх эрчим хүчний нөөцтэй манай говь газар дээрээ ч бас их баялагтай ажээ. Байгальд ээлтэй, шавхагдашгүй нөөц юм. Энэ нөөц азичүүдийн сонирхлыг татлаа гэж хэлж болно. “Азийн эрчмийн супер сүлжээ” гэх санаачлагын тухай мэдээллийг “Mongolian Economy”сэтгүүл анхлан хүргэж байна.

Тус сүлжээг Японы Софт банк, Өмнөд Солонгосын КЕПКО, Монголын Ньюком компани санаачлан хамтарч ажиллахаар төлөвлөжээ. Гол зорилго нь Монголын сэргээгдэх эрчим хүчний нөөцийг судлах, эдийн засгийн эргэлтэд оруулж, Азийн зах зээл рүү экспортлох боломжийг хайхад чиглэсэн үйл ажиллагаа явуулах аж. Манай улсын хувьд ч Азидаа зөвхөн нүүрс бус сэргээгдэх эрчим хүчээр тэргүүлэгч орон болох зорилт тавьчихсан байгаа. Өөрөөр хэлбэл, 2020 он гэхэд Монгол Улсын эрчим хүчний хэрэглээний 20 хувийг сэргээгдэх эрчим хүчээр хангана гэсэн зорилт дэвшүүлээд баталчихсан. “Энэхүү зорилтод хүрэхэд дээрх сүлжээ багагүй хувь нэмрээ оруулна. Нөөц, бас боломж манайд байна. Боломжийг хөгжил болгон хувиргах ёстой” гэж “Ньюком” компанийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан үзэж байна.

“Азийн эрчмийн супер сүлжээ” санаачлагын тухай танилцуулга уулзалтыг саяхан “Ньюком” компани, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо хамтран хийсэн билээ. “Маш зөв, зүйтэй санаачлага. Монгол Улсын цаашдын хөгжлийн зөв алхам бол сэргээгдэх эрчим хүч учир ийм байгууллага, мэргэжлийн холбоодыг манай хороо дэмжиж байгаа” гэж Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун тэмдэглэсэн.

“Монголын говийн салхинаас жилдээ 682 тэрбум кВт.цаг цахилгаан



үйлдвэрлэх нөөцтэй. 2020 он гэхэд 200 ГВ-ын хүчин чадалтай нар, салхины хосолсон станц барих төлөвлөгөөг боловсруулж байгаа. “Энэ бол мөрөөдөл бус бодит ажил болно” гэж Б.Бямбасайхан захирал хэллээ.

Дээрх станцыг барихад нийтдээ 310 гаруй мянган ажлын байр бий болно гэсэн судалгааг хийжээ. Харин төрийн зүгээс уул уурхайн орд газруудыг цэвэр эрчим хүчний эх үүсвэрээр хангах, газрын сангийн мэдээллийг сайжруулах, газрыг уул уурхайн хайгуул, олборлолтын лицензтэй давхардуулан олгохгүй байх зэрэг асуудлыг шийдвэрлэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байгаа тухай Ньюкомын гүйцэтгэх захирал ярьсан юм. Азид ийм сүлжээ байгуулагдсанаар хөгжлийн ирээдүйн гарц цэвэр эрчим хүч хэмээн тодорхойлсон дэлхийг хэрсэн сүлжээ бий болох аж.

“Дэлхийн ногоон өсөлтийн чуулга уулзалт-2012”

Өнгөрсөн долоо хоногт Сөүл хүтноо “Дэлхийн ногоон өсөлтийн чуулга уулзалт-2012” хурал болсон билээ. Солонгосын Засгийн газар, “Дэлхийн ногоон өсөлт” институт, НҮБ, Эдийн засаг хамтын ажиллагааны байгууллагуудын хамтарч зохион байгуулсан тус хуралд дэлхийн өнцөг булан бүрээс төлөөлөгчид ирсэн байв. Зарим орны Засгийн газрын өндөр албан тушаалтнууд, байгаль орчин, эрчим хүчний мэргэжилтнүүд, хувийн хэвшлийнхэн, эдэмтэн багш нар, мэдээллийн технологийн компаниудын ажилтнууд оролцсон.

Тэд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хэрхэн тэмцэхэв, ногоон эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх, үүний тулд ямар арга зам, бодлого барьж ажиллах, ногоон хөгжлийн туршлагаас хуваалцах, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, усаа хайрлан хамгаалах, төрийн бодлогыг ногоорууулах зэрэг асуудлаар ярилцсан. Байгальд ээлтэй үйлдвэрлэл, өндөр технологи хоёрыг л хамтад нь хөгжүүлэх тухай онцгойлон авч үзэж байна. Ногоон эдийн засгийн хөгжил бол нэг нэгэнтэйгээ өрсөлдөх тухай яриа бус, хамтарч, харилцан ашигтай, нэгдэж нийлж ажиллахыг шаардаж байна гэдгийг тус хурлын төлөөлөгчид онцлон тэмдэглэв.

Монгол Улс энэхүү чуулга уулзалтын сэдвүүдийн нэг болсон юм. Сэргээгдэх эрчим хүчээр баян Монгол орны баялгийг хамтарч ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах замаар байгальд ээлтэй эрчим хүчээр Азийн гэрэл цахилгааны эрэлтийг хангах боломжийн талаар ярьж байна. Энэ бол өндөр технологи, нөгөө талдаа асар их хөрөнгө шаардсан ажил аж. Тиймээс Азийн эрчим хүчний сүлжээг бий болгож, хамтран ажилласнаар асуудлыг шийдэх бүрэн боломжтой гэж үзэж буй аж.

“Атомын станц ямархуу хор хөнөөлтэй байгааг бид бэлхнээ харсан. Одоо япончууд цэвэр эрчим хүчний эх үүсвэрийг ирээдүйн хөгжил гэдгээр харж, эргэлт буцалтгүй энэ зүг явахаар шийдсэн. Монгол Улсаас цаашдаа нар, салхины цэвэр эрчим хүчийг импортоор авах боломж байна. Үүний тулд эрх зүй, санхүү болоод бусад орчин бүрдүүлэх чиглэлээр ажиллах шаардлагатай” гэж Японы Софтбанкны гүйцэтгэх захирал Масауоши Сон ярилаа. Тэрбээр Азийн эрчмийн супер сүлжээ илтгэл тавьж хэлэлцүүлэхдээ Монгол орны нар, салхины нөөцийн талаар дэлгэрэнгүй ярьсан нь төлөөлөгчдийн сонирхлыг ихэд татсан юм. Иймхүү Төв Азийн жижиг орон уул уурхайгаас гадна газар дээрх, байгальд ээлтэй баялгаараа ч мөн гаднынхны сонирхлыг төрүүлж эхэлжээ.

Ногоон сэтгүүл зүй

Уг хурлын сэдвүүдийн нэг хэсэг нь ногоон сэтгүүл зүй байлаа. Дэлхийн хөгжлийн шинэ хандлага, шинэ эдийн засгийн хөгжлийг хэрхэн сурвалжилж, олон нийтэд хүргэх вэ, ногоон өсөлтийн тухай ойлголтыг яаж тодорхойлох, ногоон хөгжлийг ямар арга замаар дэмжих вэ гэсэн асуудлаар үзэгт нэгт нөхөд маань ярилцлаа. Дэлхий нийтээрээ нэгдэж, шинэ хөгжлийг бий болгоход сэтгүүлчдийн үүрэг оролцоо хамгийн чухал юм. Гэхдээ сэтгүүлчид ногоон эдийн засаг, ногоон өсөлтийн талаар зөв ойлголттой, энэ сэдвийн ач холбогдлыг төрийн бодлого тодорхойлогчдод болоод олон нийтэд хүргэх чинхүү эрмэлзлэлтэй байх ёстой гэдгийг хурлаар онцлон тэмдэглэсэн юм.

“Ногоон өсөлтөд сэтгүүл зүйн гүйцэтгэх үүрэг” салбар хуралд Солонгосын сэтгүүлчдээс гадна BBC, Нью Иорк таймс, Филиппин, Хятадын сэтгүүлчид харилцан туршлага солилцсон. Монголоос ногоон хөгжлийн төлөө уриа бүхий “Mongolian Economy” сэтгүүлийн сэтгүүлчид оролцсон билээ.

Дашрамд хэлэхэд, ийм эдийн засгийг хөгжүүлэхийн төлөө яваа улс орны хичээл зүтгэлийг ийм сэдэвт хурал семинаруудад хэр оролцож буй оролцоогоор дүгнэх нэг арга бий гэж НҮБ-ын төлөөлөгч тэмдэглэсэн. Тэгвэл байгальд жинхэнэ харш уул уурхайн баялгаа ухаж төнхөж буй Монголын төлөөлөл энд хэр байна вэ. Хоёр сэтгүүлч л иржээ.

Ногоон эдийн засаг, ногоон өсөлт, хөгжил дэлхий дахинаа маш хурдацтай хөгжиж, улс орнууд гол анхаарлаа үүнд хандуулж эхэлснийг дээрх хурлын уур амьсгалаас мэдэрлээ. Биднийг энд уул уурхай, газраа ухах тухай ярих зуур дэлхийн хөгжил шал өөр зүг рүү хэдийнэ чиглэжээ. Манай улс дэндүү удаан байгаа юм байна. Сэтгүүлчийнхээ хувьд улс орныхоо хөгжлийг яст мэлхийн хурдтай зүйрлэж олон арван нийтлэл бичиж байлаа. Тэгвэл ялангуяа ногоон хөгжлөөр манай улс бүр хамгийн удаан, хамгийн дор түвшинд явааг л харлаа.

Сүүлийн жилүүдэд Өмнөд Солонгос улс ногоон өсөлтөөр маш хурдацтай явж байгаа. Нууц нь юунд байгаа талаарх Монголын сэтгүүлчийн асуултад тэд төрийн бодлого тодорхойлогчид асуудлыг маш сайн ойлгож, бодитой дэмждэгт л байгаа юм гэсэн хариулт сонссон билээ. /Дэлгэрэнгүй сурвалжлагыг манай дараагийн дугаараас уншаарай./ ■

ТЕХНОЛОГИ

АРИУН БИЗНЕС


Монгол Улсын цэвэр нүүрсний технологийн суурь 1978 оноос эхтэй. Бидний зөвхөн дулаацаж, гэрэл гаргадаг хэмээн боддог нүүрс нь цэвэр технологийг ашигласнаар зөвхөн эрчим хүчний эх үүсвэр бус хуванцар эдлэл, газар тариаланд хэрэглэгддэг төрөл бүрийн бордоо, химийн бүтээгдэхүүнүүд гээд тоочиж барамгүй олон зүйлийн голлох суурь нь болж байдаг байна.

Б.ЭНХЦЭЦЭГ

Өвөлжингөө утаа мананд хахаж цацаж аргаа барсан нийслэлчүүдийг байгаль дэлхий өрөвдсөн юм болов уу гэлтэй хүйтэн салхи, хуурай шороогоор хайр найргүй нүддэг хаврын адаг сард налгар зуны өдрүүд цагаасаа эрт залран солбилоо. Уужим тэнгэр байтугай урдах зам харагдахаа байсан “Утаанбаатар” хотын өвөл энэ жилийн хувьд ингэж нэг шувтарч байна аа. Түмэн олны зоо тэнийсэн зун цаг нүүгэлтсэн хар нүүрсний утааг хэсэгтээ л мартагнуулдаг нь зан биш заншил болжээ. Гэвч нүүрсийг хор гэж үздэг нэг хэсэг байхад үлдэгдэлгүй дуусдаг үнэт эрдэнэ гэдэг нөгөө хэсэг байх.

Нүүрс хэдийгээр шавхагдах баялаг ч гэлээ дэлхийн өнцөг булан бүрт хамгийн их тархсан нөөцөд тооцогддог байна. Дэлхийн нүүрсний ассоциациас гаргасан судалгаагаар манай гаригийн нүүрсний батлагдсан нөөц нь 847 тэрбум тонн ажээ. Үүнийг одоогийн хэрэглээгээр тооцвол ирэх 118 жилийн туршид хүрэлцэх нүүрс бидэнд байна гэсэн үг.

Харин ашигт малтмалын газраас гаргасан судалгаагаар Монгол Улсын хувьд батлагдсан нөөц нь одоогоор 8,4 тэрбум тонн бөгөөд жигд нэлэнхүйдээ тархсан байдаг. Нүүрс нь өнөөдөр дэлхийн голлох эрчим хүчний хэрэглээний 42 хувийг дангаар нуруун дээрээ үүрдэг ажээ. Тэгвэл манай орны хувьд нийт нүүрсний олборлолтынхоо гуравны нэг хувийг дотоодын хэрэгцээндээ шингээдэг. Үүний 80 гаруй хувь нь цахилгаан дулааны хэрэглээнд зарцуулагддаг.



Эх сурвалж: Дэлхийн нүүрсний ассоциаци

Ингэхээр нүүрс үгүй аваас бид бүгдийн улмаар хүн төрөлхтний амьдрал долоо ч хонохгүй нь. “Пийбоди Энержи” компанийн Монгол, Энэтхэгийг хариуцсан ерөнхийлөгч Аршад Саиед “Өсөн нэмэгдэх энэхүү хэрэгцээг хамгийн боломжит бага өртгөөр хангаж чадахуйц эх үүсвэрүүдийн нэг нь яах аргагүй нүүрс мөн” гэв.

“Улс хөгжихөд хамгийн хэрэгцээтэй хоёр түүхий эд байдгийн нэг нь нүүрс нөгөө нь төмөр байдаг” хэмээн ЭБЭХЯ-ны Түлшний бодлогын газрын дарга Н.Болдхүү хэлсэн юм. Тэгвэл агаарын бохирдол хүлэмжийн хий гэх мэт даяарчлагдсан асуудлаас нүүрсний хэрэглээг багасгалгүйгээр салах ямар арга бидэнд байна вэ гэвэл нүүрсний цэвэр технологи. Энэ технологиор нь нэг талаас олон төрлийн бүтээгдэхүүн хийдэг бол нөгөө талаас агаар мандалд хүлэмжийн хий ялгаруулдаггүйгээрээ онцлог давуу. Өнөө жил Дэлхийн цэвэр нүүрсний технологийн институцийн 100 жилийн ой тохиож байгаа бөгөөд энэ хугацаанд нүүрснээс 200 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн гаргаж авч чаджээ. Харин Монгол Улсын цэвэр нүүрсний технологийн суурь 1978 оноос эхтэй. Бидний зөвхөн дулаацаж, гэрэл гаргадаг хэмээн боддог нүүрс нь цэвэр технологийг ашигласнаар зөвхөн эрчим хүчний эх үүсвэр бус хуванцар эдлэл, газар тариаланд хэрэглэгддэг төрөл бүрийн бордоо, химийн бүтээгдэхүүнүүд гээд тоочиж барамгүй олон зүйлийн



голлох суурь нь болж байдаг байна. Энэ нь агаар мандалд ялгардаг угаарын хий, хүхэрлэг азот гэх мэт элемент агаарт цацагдахад хор болох биш, бүтээгдэхүүн болон хувирдаг гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, нүүрс нь цэвэр технологийн үйлдвэрлэлээр дамжвал хаягдалгүй бүтээгдэхүүн болон хувирдаг. Ингэхээр нүүрсийг зөвхөн эрчим хүчний нүдээр харвал дэндүү нэг талыг барьсан өрөөсгөл ойлголт болох биз ээ.

Нэг баррель газрын тосны үнэ 50-70 ам.доллар давсан тохиолдолд нүүрснээс олон төрлийн бүтээгдэхүүн гаргаж авах нь ашигтайд тооцогддог байна. Дэлхий 2007 оноос хойш газрын тосны дээрх үнийн амтыг багагүй мэдэрсээр ирлээ. “Нэг баррель газрын тосны үнэ тэртээ 1950 оны үед нэг ам.доллар байсан бол өнөөдөр 100 гаруй ам.доллар. Дээр нь газрын тосны нөөц багассаар. Энэ нь нүүрснээс нефтийн бүтээгдэхүүн гаргаж авахад эдийн засгийн хувьд ашигтай болсныг харуулж буй аж. Нүүрснээс гаргаж авч болох зөвхөн нэг л төрлийн бүтээгдэхүүн нь нефть.

Нүүрсний цэвэр технологи буюу гүн боловсруулалт гэдэг нь нүүрсийг тодорхой температурт өөрчлөлтөд оруулж түүнээс гарсан хийг нь эргүүлээд бүтээгдэхүүн гаргаж авахад ашигладаг технологийг хэлдэг болно. Энгийнээр хэлбэл хаягдал хор түмэнд тустай бүтээгдэхүүн буюу мөнгө болж буй нь энэ ажээ.

Дэлхийн нийт нүүрс хэрэглэгчдийн 60 гаруй хувь нь Монгол Улсыг тойрон оршдог байна. Ингэхээр бидэнд томоохон тоглолт хийх боломж тэр хэмжээнд бас байна аа гэсэн үг. Тэгвэл хаанахын ямар технологийг нутагшуулбал зүгээр вэ. “Муу нүүрс, муу технологи гэж байдаггүй. Харин ямар нүүрс ямар технологид тохирох вэ гэдэг зохицлын л асуудал байдаг юм. Тухайлбал, тэр муу гээд байдаг хүрэн нүүрс эсрэгээрээ задрахдаа сайн агаад хийжүүлэхэд хялбар байдаг” хэмээн Н.Болдхүү дарга тайлбарласан.

Өнөөдөр дэлхий дээр цэвэр технологиороо Өмнөд Африкийн Бүгд Найрамдах улс аваргалдаг бол Европын холбооны улсууд болон АНУ түүний дараагаар тэргүүлэгчдийн эгнээнд багтдаг байна. Харин Азийн зах зээлээс Япон, Хятад улс манлайлдаг ажээ. Иймээс хаанахын хэний технологийг авах вэ гэдэг асуултад тохирох хариулт нэг биш нэлээд байж болох нь ээ.

Өнөөдрийн байдлаар манайд нүүрс шингэрүүлэх ба хийжүүлэх таван төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд үүнээс гурвынх нь урьдчилсан ТЭЗҮ гарчихсан байгаа юм байна. Засгийн газраас татварын таатай нөхцөл бий болгож зах зээл дээр худалдаалах боломжийг олгоно. Мөн хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээний дагуу хоёр орны аж ахуйн нэгжүүд хоорондоо шууд гэрээ байгуулах бололцоог бүрдүүлж буй аж. Үүний нэг жишээ нь саяхан манай улсын Ерөнхийлөгч ХБНГУ-д айлчлах үеэр нүүрс шингэрүүлж түлш үйлдвэрлэх төслийг хэрэгжүүлэх тухай санамж бичигт Монгол Улсын Эрдэс баялаг, эрчим хүчний дэд сайд Ц.Гарамжав, “Tyssen Krupp Удэ” компанийн гүйцэтгэх захирал А.Хофман нар гарын үсэг зурсан билээ. Нүүрс, занар, газрын тосноос шатахуун гаргаж авах тал дээр төрөөс хууль эрх зүйн хүрээнд дэмжих хэдий ч хөрөнгө оруулалтын тал дээр төрөөс баталгаа гаргаж өгөхгүй юм билээ. Манай улсын хувьд Герман улсаас гадна Солонгос, Япон улстай цэвэр технологийн хувьд хамтран ажиллаж байгаа юм.

Цэвэр нүүрсний технологи өөд манай дотоодын компаниуд ч мацаж эхэлсний илрэл нь “Энержи Ресурс”, “Эс Жи Эс”, МАК зэрэг компанийн энэ жилдээ багтаад ашиглалтад өгөхөөр төлөвлөж буй баяжуулах үйлдвэрүүд юм. Эдгээрийн нийт хүчин чадал нь 23 сая тонн нүүрс баяжуулах ажээ. Мөн дэлхийд ногоон нүүрсний технологиороо тэргүүлэгч “Пийбоди Энержи” нь Монгол Улсад хамгийн дэвшилт технологид суурилсан нүүрснээс гарах хорт ялгарлыг бараг бүрмөсөн тэглэх ногоон нүүрсний үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа юм байна. Тус компанийн Хятадад хэрэгжүүлж буй “Грийнжен” төсөл амжилттай хэрэгжсэнээр хорт ялгарлыг бүрмөсөн тэглэж чадсан дэлхийн хамгийн том цахилгаан, дулаан хослон үйлдвэрлэгч нүүрсний станц болох ажээ.

Энэхүү улс төр, эдийн засгийн ач холбогдолтой стратегийн бүтээгдэхүүнийг цэвэр технологи ашиглан гаргаж авах нь нэн тэргүүний давуу тал болох. Мөн өөрийн газар шороонд тухайн технологийг ашиглан нутагшуулснаар хямд үнэ баталгаат чанарыг ард түмэндээ хүргэх боломж бүрдэнэ. Нөгөө талаар дэлхийн долоон тэрбум иргэний нийтийн хөрөнгөөс бид хуваалцаж амьдардгийн хувьд байгаль орчноо хамгаалах даяаршсан үүргээ эх орныхоо болон дэлхийн өмнө биелүүлж буй томоохон алхам юм. Нүүрсний цэвэр технологи нь хаягдлыг хүртэл хаялага болгодог ариун бизнес ажээ. ■

ТОВЧХОН

ЭБЭХЯ-наас 2009-2011 онд хэрэгжүүлсэн томоохон арга хэмжээ

● Оюутолгой төсөлд давхардсан тоогоор Монголын 2400 аж ахуйн нэгж хамтран ажиллаж байна. Оюутолгойн төсөл дээр нийт 17817 ажилтан ажиллаж байгаагийн 11241 нь буюу 63.09 хувийг монголчууд эзэлж байна. Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш давхардсан тоогоор Монголын 2400 аж ахуйн нэгж Оюу Толгойд 887 сая ам.долларын хангамж, туслан гүйцэтгэх ажлыг хийж гүйцэтгэжээ.

● Тавантолгойгоос нүүрс экспортлож эхлэв. “Эрдэнэс Монгол” төрийн өмчит компани Тавантолгой төслийн хүрээнд наймдугаар сард нүүрсний экспортыг эхлээд 2011 онд 800 мянган тонн нүүрс олборлож, “Хүний хөгжил “санд 217 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна.

● Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тоог бууруулаа. 2005 онд Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 44.5 хувийг ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр хамарсан байсан бол 2009 онд 25.2, 2010 онд 16, 2011 онд 14.3 хувь болон буурчээ.

● 2009 онд 14, 2010 онд 12 уурхай, 2011 онд 19 уурхай шинээр ашиглалтад орлоо. Эдгээр уурхайд 8700 ажлын байр шинээр бий болж, уул уурхайн салбарт нийт 50 орчим мянган хүн ажиллаж байна. Хувираа ашигт малтмал олборлогчдын эрх зүйн орчныг бүрдүүллээ. Ингэснээр тэд хуулийн хүрээнд ажиллаж амьдарч, улсад татвар хураамж төлж нийгмийн халамжид хамрагдах нөхцөл бүрдээд байна.

● Нүүрсний экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлснээр 2006 онд 2,5 сая тонн байсан бол 2010 онд нүүрсний экспорт 15 сая тонн, 2011 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 24 сая тоннд хүрэх төлөвтэй байна.

● Нүүрсний уурхайнууд болон станц хоорондын хуримтлагдсан өр авлага 57.3 хувиар буурлаа. Төвийн бүсийн нүүрсний уурхай болон дулааны цахилгаан станц хоорондын өр авлага 2011 оны есдүгээр сарын байдлаар 57.3 хувиар буураад байна. Эрчим хүчний салбарын авлага, өглөгийн хэмжээ буурч, эх үүсвэргүй өрийн хэмжээ эрс буурснаар салбарын санхүү, эдийн засгийн байдалд эерэгээр нөлөөлсөн.

● Эрчим хүчний компаниуд 2008 онд хамгийн их буюу 30.1 тэрбум төгрөгийн авлагатай, 20.2 тэрбум төгрөгийн эх үүсвэргүй өртэй байсан бол сүүлийн жилүүдэд хийсэн тарифын зохицуулалт, Засгийн газраас хэрэгжүүлсэн зарим арга хэмжээний дэмжлэгтэйгээр эрчим хүчний системийн хэмжээгээр өр авлагын харьцаа зохистой түвшинд хүрчээ.

● Дөргөн,Тайширын усан цахилгаан станц ашиглалтад орсноор Баруун бүс эрчим хүчний бие даасан сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй боллоо.

● Төр ба хувийн хэвшлийн хамтын ажиллагаа эрчим хүчний салбарт бодитой хэрэгжиж эхэллээ. Улаанбаатар хотод баригдах шинэ эх үүсвэр ТЭЦ-V төслийн хөрөнгө оруулагчийн сонгон шалгаруулалт эхлэв.

● Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Өмнөговь аймгийн Ухаа худагт 18 МВт-ын цахилгаан станц 2011 оны есдүгээр сард ашиглалтад орлоо.

● Могойн голын нүүрсний уурхайг түшиглэн Завхан аймгийн Тэлмэн сумын нутагт 60 МВт-ын цахилгаан станц барих төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээг байгуулж, ажил эхлүүлээд байна.

● Сэргээгдэх эрчим хүчний томоохон төсөл болох 50МВт-ын салхин паркийг барихаар “Ньюком групп” Салхитын хөндийд ажлаа эхлүүлээд байна.

● Гэр бүхэн гэрэлтэй боллоо. “100 мянган нарны гэр” хөтөлбөрийн хүрээнд сүүлчийн 10000 нарны цахилгаан үүсгүүр тараагдаж байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын 160 мянган малчин өрх гэрэлтэй болов.

● 2011 онд Говь-Алтай аймгийн бүх сум, Завхан аймгийн 21 сум эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбогдлоо. 2012 онд Завхан аймгийн хойд талын гурван сумыг эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбосноор Монгол Улсын нийт 333 сум, суурин эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй болж байна.

● Газрын тосны олборлолт, экспортоос 2009 онд 29.7, 2010 онд 57. 2, 2011 оны арваннэгдүгээр сарын 1-ний байдлаар 51.9 тэрбум төгрөгийг тус тус улсын төсөвт оруулаад байна.

ТӨСӨЛ

АМЬДРАЛ ТЭТГЭХ ХҮЛЭМЖ

Төслийн гол зорилго нь дэвшилт технологийн тусламжтайгаар дэлхийн цөлөрхөг хэсэгт сэргээгдэх эрчим хүч, ундны ус бий болгоход орших юм. Мөн толийг ашиглан нарны тусгалыг ус халаах, ууршуулах санаа нь бусад ижил төрлийн төслөөс ялгарах онцлог.

Б.ҮҮРИЙНТУЯА

Эцэс төгсгөлгүй мэт үргэлжлэх элсэн далайн цорын ганц гоёл нь дромедарын цуваа. Эл газар дэлхийн хуурай газрын найман хувийг буюу 9,4 сая ам км газар нутгийг бүрхэх аж.

Манай гарагийн хамгийн хуурай бас халуун цэг Алжир, Египт, Морокко гээд нийт 12 улсыг дамнадаг. Нохой гаслам 58 хэмийн буцлам халуун, дэлхийн дээд рекордыг тогтоох усаар хомс Африкийн хойд хэсгийг Сахарын цөл хэмээн нэрийддэг билээ.


Энергийн их уурхай гэхэд хилс-дэхгүй Сахарын цөлийн дөнгөж гурван хувийг нарны эрчим хүч хуримтлуулахад зориулбал Европ тивийг бүхэлд нь цахилгаанаар хангах боломжтой аж. Энэ талаар Европын их гүрнүүд удаан хэлэлцсэний үр дүнд Хойд Африкийн бүсэд нарны хавтан суурилуулах төслийн санаачилга гарсан юм. Үүний нэг нь Герман болон тус улсын Desertec Foundation хамтран Сахарын Можавэ цөлд хэрэгжүүлэх “Desertec” төсөл. Уг төсөлд 100 гигаваттын хүчин чадал бүхий цахилгаан станц барихаар тусгажээ. Энэ нь Европ тивийн нийт цахилгааны хэрэглээний 15 хувийг хангах ба цөлийн хэд хэдэн хэсэгт хэрэгжих аж.

Газар дундын тэнгисийн гүнд суурилуулах өндөр хүчдэлийн



шугамын тусламжтайгаар Можавэ цөлд хуримтлуулсан эрчим хүчийг Европ тив рүү татах эл төсөл нийт 400 тэрбум еврогийн хөрөнгө оруулалт шаардах юм байна. Хэдийгээр евро бүсэд хямрал нүүрлээд байгаа ч Siemens, Deutsche Bank, Германы эрчим хүчний RWE, E.on компаниуд болон Munich Re зэрэг байгууллага төслийг сонирхож буйгаа илэрхийлсэн. Эдгээр байгууллага төслийг цаг уурын өөрчлөлттэй тэмцэх нэг хэлбэр төдийгүй 2050 онд дэлхий нийтэд нүүрлэх эрчим хүчний хомсдолыг сааруулах арга зам хэмээн тайлбарлаж байна.

Эрчим хүчний хомсдолд орохоос урьтаад дэлхий дахинаа усны хомсдол хаяанд ирчихээд байна. Шар цөлийг цэвэр усаар хангах, улмаар ногоо тариалж хөдөө аж ахуй хөгжсөн “ногоон” цөл болгох боломжтойг Венец хотноо 2008 онд болсон “Шинжлэх ухааны хэтийн төлөв” сэдэвт олон улсын хурал дээр зарласан. Жилийн дундаж хурын хэмжээ ердөө 10 см байдаг ийм хуурай газрыг усны ундарга болгоно гэдэг үлгэр мэт боловч амьдралд хэрэгжүүлэх боломжийг Сахарын цөлийн төсөл (Sahara Forest Project) 100 хувь бүрдүүлж байгаа аж. Төсөлд



Сахарын цөл дэх “Desertec” төсөл

хамрагдах бүсэд хүнс, ус болон эрчим хүчний эх үүсвэрийг нэгэн зэрэг бий болгох ингэхдээ “Desertec” төсөлтэй ижил системийг ашиглах юм байна.

Эхний ээлжинд туршилт хийх үүднээс Улаан тэнгисийн ойролцоо буюу Жорданын зүүн эрэгт байрлах Акаба хотын 200 мянган ам.метр газрыг сонгожээ. Туршилт амжилттай хэрэгжвээс төслийг өргөтгөн дахин хоёр сая ам км газарт хэрэгжүүлэх гэнэ. Норвеги улсын санхүүжилттэйгээр төслийн багийнхан Жорданын бүсэд хэд хэдэн судалгаа хийх бөгөөд Норвегийн төслийн баг болон Жорданын Засгийн газар Сахарын судалгааны төслийн гэрээнд гарын үсэг зуржээ.

Ногоон манхан

Төвлөрсөн нарны хавтангууд болон далайн усны хүлэмжийг байршуулах нь үржил шимгүй их элсийг ургацын далай болгох “зэмсэг” болох юм. Хүлэмжийг тойруулан жадропа цэцгийг ургуулснаар био түлш гарган авах боломжийг ч бүрдүүлэх аж.

Төслийн гол зорилго нь дэвшилт технологийн тусламжтайгаар дэлхийн цөлөрхөг хэсэгт сэргээгдэх эрчим хүч, ундны ус бий болгоход орших юм. Мөн толийг ашиглан нарны тусгалыг ус халаах, ууршуулах санаа нь бусад ижил төрлийн төслөөс ялгарах онцлог, давуу талыг харуулах аж. Газар нутгийн хувьд ч тун ашигтай. Учир нь, төслийг хэрэгжүүлэхээр сонгосон бүс нутаг нь далайн түвшингөөс доор, эрэг дагуу байрлах нь далайн усыг төслийн газар руу урсгах боломжийг олгож байгаа юм.

Сахарын цөлийн төсөлд ашиглагдах уг технологийн онцлог нь халуун, хуурай уур амьсгалд тун тохиромжтойд оршино. Учир нь, дээрх хүлэмж нь зөвхөн нарны энерги ашиглан далайн шорвог усыг конденсацид оруулна. Төвлөрсөн нарны хавтан болон толины тусламжтайгаар далайн усыг +538 градус хүртэлх хэмд халаан улмаар ууршуулна. Хуримтлуулах уурыг цахилгаан гаргах сэнсэн хөдөлгүүрт ашиглах эсвэл зориулалтын газар хөргөн давсыг нь шүүж цэвэршүүлэх юм байна. Конденсацийн аргаар цэвэршүүлэх нь олон давуу талтай. Нэгдүгээрт, ойр хавийн иргэдийг ундны усаар хангаад зогсохгүй тариалангийн талбайг тэтгэх усалгааны системийг бий болгоно. Хоёрдугаарт, далайн уснаас гаргаж авсан давсыг эрүүл мэндийн зориулалтаар хэрэглэж болно.

Элсэн цөлийн хамгийн том аюул нь шороон цунами гэж болох элсэн шуурга байдаг. Энэ “цунами” Их Британи, АНУ гээд тив алгасан үргэлжлэх нь бий. Нарийн ширхэг бүхий элс техник, төхөөрөмжид гүн шигдэх бөгөөд дахин засварлах боломжгүйд хүргэдэг байна. Иймээс төслийг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулах талтай. Шуурганаас үүдэлтэй эвдрэл, бохирдол гарах эрсдэлийг гаргаж магадгүй гэнэ. Харин далайн ус цэвэршүүлэх явцад гарах саарал усыг эргээд нарны хавтан, хүлэмжийн ойр орчин зэрэг төслийн техник хэрэгслийг цэвэрлэхэд ашиглах ажээ. Сахарын төслийг бүрэн хэрэгжүүлснээр Европ болон Африк тивийг бүхэлд нь сэргээгдэх эрчим хүчээр хангах цогц шийдэл болно. Хэдэн жилийн өмнө эрдэмтэд Сахарын цөлд хэдий хэмжээний нарны эрчим хүч хуримтлуулах талаар судалсан байдаг. Онолын дагуу цөлийн зөвхөн 90 мянган ам.км газраас дэлхийн бүх цахилгаан станцын гаргах эрчим хүчтэй тэнцэхүйц хэмжээний цахилгаан авах боломжтой гэжээ. Харин АНУ-ын Коннектикат мужийн газар нутагтай тэнцэхүйц буюу 15,5 мянган ам км газарт Европын 500 сая хүн амыг бүхэлд нь эрчим хүчээр хангах хэмжээний энергийг хуримтлуулж болох нь ээ.

Сайны хажуугаарх саар

Сахарын цөлийн төсөл хэдэн тивийг нэгэн зэрэг цахилгаанаар хангах хүчин чадалтай гэдэг утгаараа дэлхийн хамгийн том сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр болж буй. Гэсэн хэдий ч бүтээн байгуулалтыг эхлүүлэхэд шаардагдах хөрөнгийн асуудал холбогдох хүмүүсийн өдрийн бодол, шөнийн зүүд болж байгаа юм. 40 гаруй жил үргэлжлэх бүтээн байгуулалтын доод зардлыг

465 тэрбум ам.доллар байна хэмээн таамаглажээ. Өөр нэг асуудал бол дэд бүтэц. Европын Парламент 2020 он гэхэд цахилгаан хэрэглээнийхээ 20 хувийг Сахарын цөлөөс татна гэсэн зорилт тавьсан. Харин шаардлагатай дэд бүтцийг бий болгоход хангалттай хугацаа үгүй тул 2020 онд 20 хувь гэдэг мөрөөдөл төдий зорилго болж байгаа юм. ABB Power Technologies-ийн өндөр хүчдэл дамжуулах кабелийн судалгааны ахлагч Гуннар Асплунд “Энэ төсөл мэдээж их хэмжээний хөрөнгө шаардана. Нүүрс түлэх нарны энерги цуглуулахаас хямд байх нь тодорхой. Европын эрчим хүчний хэрэглээний зөвхөн 20 хувийг хангахын тулд Газар дундын тэнгист 19,300 километр урттай цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн кабель суурилуулах шаардлагатай” гэжээ.

Европыг бүхэлд нь хангах эрчим хүчийг ийм төрлийн кабелиар дамжуулахаас өөр аргагүй. Одоо байгаа хамгийн дэвшилт арга бол энэ. Харин цөлд хуримтлуулах эрчим хүчийг дамжуулахын тулд цоо шинэ сүлжээг бий болгох хэрэгтэй ажээ. Шинэ сүлжээ цаг хугацаа, хөрөнгө хүч их шаардах болно. Германы Засгийн газрын өмчид харъяалагдах эрчим хүчний судалгааны Aerospace төвөөс мэдэгдэхдээ “Одоо ашиглаж байгаа сүлжээг зөвхөн нүүрс шатаагч эрчим хүчний эх үүсвэрт хэрэглэдэг. Харин эдгээрийг шинэчлэхэд Сахарын цөлийн төслийн төсөвтэй тэнцэх хэмжээний буюу 465 тэрбум ам.доллар хэрэгтэй гэсэн үг. Хэрэгжүүлэгч бүсийн Засгийн газруудаас хандивын давалгаа орж ирэхгүй л юм бол энэ төсөл зөвхөн цаасан дээрх бэх болж үлдэнэ” гэжээ.

Франц улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар Европ, Газар дундын тэнгисийн бүс нутаг болон Хойд Африкийн орнууд хамтран Mediterranean Union гэх нийт 43 улсын гишүүнтэй холбоог өнгөрсөн жил байгуулсан. Холбооны гол зорилго нь Н. Саркозигийн Сахарын цөлд хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн нарны эрчим хүчний шинэ төслийг үр дүнд хүргэхэд орших аж. Гэвч шүүмжлэгчдийн хэлж буйгаар амбиц ихтэй төслүүд шил шилээ даран гарч байгаа ньтэдгээрийн өртөг, хамрах нутаг дэвсгэрийн улс төрийн асуудлыг уландаа дэвсэлж байна гэжээ.

“Төслийн өртөг, зарлагыг авч үзвэл Европын хүн ам хямд үнээр цахилгаан хэрэглэх болно гэдэг бол худлаа зүйл” хэмээн Германы Парламентийн гишүүн Херман Шхийр хэлсэн удаатай. Тэрбээр өөрийн улсад Засгийн газрын санхүүжилттэй хэрэгжсэн өрх бүрт нарны хавтан суурилуулах төслийг санаачлан удирдаж байжээ.

Өнгөрөгч оны арваннэгдүгээр сард Парис хот

НЭГ ӨДӨР

ИЛЧ ГЭРЛИЙН ЭЗЭН

Тэрбээр станц хэвийн ажиллаж байгаа эсэхийг сонсоод л шууд мэддэг. Чих дөжрөм дуу чимээн дунд явж орчихоод манай станц ч өнөөдөр ёстой залуу хүн шиг л эрч хүчтэй байх чинь. Доголдсон төхөөрөмж байхгүй бололтой эвгүй чимээ сонсогдсонгүй гээд ярих.

Э.СОЁОНОО

Манай сэтгүүл энэ удаагийн дугаартаа эрчим хүчний талаар бичиж байгаатай холбогдуулан Монгол Улсын хамгийн том цахилгаан станц болох дөрөвдүгээр станцын “Цахилгаан цех”-ын дарга С.Алтанхуягийн нэг өдрийг сонирхлоо. Түүний удирдсан цех станцынхаа 2010, 2011 оны аваргаар шалгарчээ.

05:15 цаг. 2012.05.09

Хэдийгээр нар мандаагүй ч хорвоо дэлхий хэдийнэ нойрноос сэрж, гэгээ оржээ. Гэхдээ их хөлийн хот нам унтчихсан мэт чимээгүй, болжмор жиргэхээс өөр аниргүй. Гэнэт болжморын жиргэх дуун “хүүе хаая” гэх хэн нэгэн эрэгтэйн хашгирах дуунаар солигдоход Алтанхуяг цочин сэржээ. Угаас сэргэг нойртой тэрбээр орноосоо шуртхийн босоод цонхоороо харвал хэсэг залуус муудалцаж, улмаар цагдаа ирчихсэн байх аж. Залуусын хашгирах дуунаар үргэгдсэн түүний нойр хулжин оджээ.

дахь Францын Байгаль, орчны яамны хурлын танхимд Европын болон Хойд Африкийн 60 гаруй инженер цуглан хуралдсан билээ. Хуралдааны үеэр төсөлд ахиц байгаа эсэх холбогдох улсуудын Засгийн газрын хандлага зэргийг хэлэлцсэн аж.

Инженерүүдийн дийлэнх нь Засгийн газрууд үл ойшоосон байдалтай, хэрэгжилтийг хурдасгах ямар ч арга хэмжээ авахгүй байгааг онцолжээ. Хурлыг зохион байгуулагч Николь Дунлоп хэлэхдээ "Эрчим хүч дамжуулах асар том сүлжээг хүлээж суух хэрэггүй. Харин Хойд Африкт барих цахилгаан станцууд ашиглалтад ормогц одоо ашиглаж буй өндөр хүчдэлийн кабелийн сүлжээгээр дамжуулан төвлөрүүлсэн эрчим хүчийг зохих хэмжээгээр татаж эхлэх нь зөв. Төслийг хэсэгчлэн хэрэгжүүлэх боломжтой тул үүнийг "лего"-ны арга гэж хэлж болно. Сахарын цөлийн төслийг багахан хэсгээс ашиг олоод ирмэгц хөрөнгө оруулагчид, Засгийн газрууд сонирхож эхэлнэ" гэжээ.

Аялах зуураа элсэн далайг ширтэж, Сахарын цөлийн "ногоон байгууламж"-ийг гайхшрах мөч удахгүй биелэх биз ээ. ■

05:30 цаг

Өрөөнд нарны анхны алтан цацраг тусахтай зэрэгцээд Алтанхуяг цай аягалж, станц руугаа утас цохилоо. "Байна уу жижүүр үү. Өчигдөр станц хэвийн ажилласан уу. За ойлголоо. Дулааны улиралтай холбогдуулан станцад хэт халалт хоёр ч удаа гарсан мэдэж байгаа биз. Одоогоор янз бүрийн зүйл болоогүй биз дээ" хэмээн анхаарал сэрэмжтэй байхыг сануулав.

07:24 цаг

Тэрбээр ажил дээрээ ирээд хувийнхаа бэлтгэлийг хангачихаад гадагш гарав. Цахилгаан цехийн 100 гаруй ажилтан аль хэдийнэ гадаах талбайд цугларчихсан харагдана. Зарим нь өөр зуураа янжуур солилцонгоо мэнд мэдэлцэх аж. Цехын даргынхаа барааг хармагц бүгд бэлэн байдалд, зүрхэн тушаа гараа авч тангаргаа өргөлөө. "Хийх хүн арга хайдаг. Хийхгүй хүн шалтаг эрдэг..." гээд л. Тангаргын ерөнхий утга нь ажилчид эрүүл саруул ажилдаа ирсэн



Фотог зохиогч

Зүүн гар талаас С.Алтанхуяг ажилтантайгаа

шиг энх тунх гэртээ харих талаар байх бөгөөд өөрсдийн ажилд чин сэтгэлийн угаас хандах тухай ч мөн байлаа.

08:00 цаг

Алтанхуяг зарим өглөө хоёр, гурван ч удаа шуурхай хуралддаг ажээ. Гэхдээ энэ удаа станцад ямар нэгэн доголдол гараагүй учраас хуралд нэг их цаг гаргасангүй.

08:23 цаг

Алтанхуяг дарга эмнэлгийн зүг яарна. Шөнийн ээлжээс буусан мөн өнөөдөр ажилд гарч байгаа ажилчдынхаа эрүүл мэндэд ямар нэг өөрчлөлт гарсан эсэхийг шалгах гэж байгаа нь энэ юм. Эмнэлгийн үүдэнд цахилгаан цехийн ажилтан Мягмарсүрэн эмчид үзүүлэхээр зогсож байв. Юу болсныг асуувал түүний хамарт мах ургасны улмаас эмчээс зөвлөгөө авахаар ирсэн аж. Үүнийг сонссон цехын дарга нь түүнээс ямар зовиуртай байгаа, ямар дусаалга хэрэглэж буйг нь сонирхоод “Өө хө чи чинь хэрэглээнээс гарчихсан дусаалга хэрэглээд байгаа юм байна. Нафазолиныг чинь сараас дээш тусаавал хамарт мах ургах, судас нарийсах гээд олон сөрөг үр дагавар авчирдаг юм. Эмчээс өөр дусаалга ав” гэлээ. Мягмарсүрэн ч эмчийн өрөө рүү яваад орчихов. Төд удалгүй гарч ирэхдээ тэрбээр “Цехийн даргаа таны хэлснийг л эмч хэллээ шүү” гээд ажлын байрныхаа зүг яарлаа. Хамт ажиллагсад нь “Манай Алтанхуяг дарга бидэнд ажил мэргэжлийн тал дээр зааж зөвлөхөөс гадна ахуй амьдрал, эрүүл мэнд гээд ажилчиддаа тохиолдсон түмэн зовлонг хуваалцдаг ёстой аавын дайтай дарга даа” хэмээн магтаж байсан юм.

09:00 цаг

Чих дөжрөм дуу чимээ, бүгчим агаар өөдөөс цоргино. Энэ бол станцын зүрх болсон газар. Генератор, турбин, зуух гээд Монгол Улсын гал голомтыг бадраах эд эс бүхэн энд зогсолтгүй ажиллана. Станцын ажилчид өөр хоорондоо хашгирч ярих агаад зарим нь дохио зангаа ч хэрэглэж харагдана. Алтанхуяг дарга Генераторын “асаах унтраах



Түүний хамгийн орох дуртай өрөө

товч” буюу генераторын тасалбарыг шинэчилж байгаа ажилтай танилцаж, холбогдох зарим үүрэг даалгавар өгөөд цааш явлаа. Тэрбээр станцын булан тохой, нүх сүв бүрийг биечлэн шалгадаг аж. Лабораториор орж генераторын болоод өндөр хүчдэлийн туршилт, цахилгаан тоноглолыг хаягжуулах, хяналтын системийн аюулгүй ажиллагаа зэрэг олон ажлыг өөрийн нүдээр харж шалгаж, зааж зөвлөнө. Тэрбээр станц хэвийн ажиллаж байгаа эсэхийг сонсоод л шууд мэддэг гэнэ. Тухайлбал, чих дөжрөм дуу чимээн дунд явж орчихоод манай станц ч өнөөдөр ёстой залуу хүн шиг л эрч хүчтэй байх чинь. Доголдсон төхөөрөмж байхгүй бололтой эвгүй чимээ сонсогдсонгүй гэв. Үүнийг нь ч ажилчдынх нь ажлын тайлан батлах аж.

Цахилгаан станц гэх Монгол Улсын гал голомтын эрэг боолт нэг бүрийг шалгаж, доголдсон газрыг засаж сэлбэж, зааж зөвлөж хөлсөө гартал алхсаар тэрбээр 61 метрийн өндөрт гараад иржээ. Станцын хамгийн өндөрлөг хэсэг бол энэ юм. Харин одоо эргээд доош бууна. Түүнийг дагаж алхсан миний хөл эцэж, чих шуугиад бушуухан эндээс гарахыг хүснэ. Станцад цахилгаан шат байсан ч болоосой хэмээн “мөрөөдөж” ч үзлээ. Харин 50 насны босго давсан Алтанхуяг дарга ажирсан шинжгүй. Доош буцаж буухдаа ч бас л энэ тэнд хийгдэх засвар үйлчилгээний ажлыг шалгасаар. Тус станцын дөрөв болон тавдугаар турбин засварт орсонтой холбоотой ажлыг явцыг сайтар шалгаж яваа хэрэг. Нэг мэдэхнээ 11 цаг аль хэдийнэ өнгөрчээ. Ажилчдын зарим нь цайндаа орохоор яарах аж. Харин Цахилгаан цехийн дарга их дуу чимээ, бүгчим халуунд ажилласаар. Өдгөө дөрөвдүгээр станц 1000 гаруй ажилтантай бөгөөд 11:00 цагаас эхлэн ээлжээр үдийн цайндаа ордог юм байна.

Өнгөрснийг дурсахуй

11:35 цайны цаг

Дөрөвдүгээр цахилгаан станцын хувьд 1991-1996 он бол хамгийн хүнд хэцүү үе байсан. Ажилчид нь ёстой л дайтаж явсан гэхэд хилсдэхгүй. “Орос ах” нар станцыг орхиод нутаг буцчихсан, зарим нэг монгол ажилчид зах зээлийн сургаар Эрээн рүү ганзагын наймаанд мордсон. Элэгдэлд орж эхэлсэн техник технологи, дээрээс нь Багануурын нүүрс хэтэрхий тэсрэлт ихтэй. Үүний улмаас тоосжуулалтын систем салхижуулах үйл явц байнга



доголддог. Түүнийг гар аргаар залгана гэдэг ажилчдын хувьд айдас болгоомжлол ихтэй байжээ. Тухайн үед Засварын цехэд хуваарилагдсан залуухан инженер Алтанхуяг ажил дээрээ хонох үе цөөнгүй байв. Нэг, хоёр хоног биш, бүтэн нэг сарын турш ажил дээрээ хоносон үе ч түүнд бий.

Тэрбээр “Гэр бүлээ ажлынхаа дараа тавьдаг байлаа. Хуучирсан, нүүрсний чанар тохирохгүй технологийг монголчилж л улсыг гал алдуулчихалгүй аргалдаг байсан юм. Гэрэл таслах үе цөөнгүй байсан. Тиймээс тухайн үед биднийг төр, засгийнхан болоод иргэд хүртэл буруушааж ажлаа хийж чадахгүй байна гэдэг байлаа. Ямар сайндаа Цагаан сар болохоор л сонин хэвлэлээр “Бууз түүхийрэх үү” гэх санал асуулга явдаг байсан. Тэгээд л станцынхныг элдэвлэж гарна. Гэхдээ бид тэр хүнд хэцүү үеийг өдгөө нэгэнт давжээ” хэмээн дурсан ярина. Харин өдгөө дөрөвдүгээр станцын техникийн шинэчлэл дэлхийд өрсөлдөхүйц болсон аж.

12:05 цаг

Тэрбээр наран талдаа цонхтой жижигхэн ч гэлээ тохь тухтай цэвэрхэн өрөөндөө орж ирээд баахан бичиг цаас өмнөө гаргаж ирээд суучихлаа. Түүнд станцын бүхий л үйл ажиллагаанд хяналт тавихаас гадна уншиж, танилцах ёстой бичиг цаасны ажил мундахгүй. Шинээр орж ирсэн техник технологийн бүртгэлээс авахуулаад өвчтэй, чөлөөтэй ажилчдыг бүртгэх, тэдний санал гомдолтой танилцах гээд хийх ажил их. Завсар хооронд нь станцын ажлын үйл явц, ирээдүйд хийгдэх ажил зэргийг танилцуулах, заавар зөвлөгөө авах гэсэн хүмүүс өрөөнөөс нь салахгүй.

14:45 цаг

Станцад ийм чимээгүй орчин байдаг юм болов уу гэж бодогдмоор нам гүм рүү ороод явчихав. Энэ бол станцын төв “шит” буюу станцын удирдлагын төв өрөө. Тэрбээр энэ өрөөгөөр бахархдаг. Учир нь, 2006 оныг хүртэл оросуудын үлдээсэн хуучин техникийг ашиглаж, нэг боолт эвдэрсэн ч биеэр очиж шалгадаг, мэдээллэдэг байсан тэр үеийг Алтанхуяг болон түүнтэй мөр зэрэгцэн ажиллаж байсан нөхөд нь өөрчилж, станцын удирдлагын өрөөг тэр чигт нь хамгийн дэвшилт технологиор шинэчилжээ. Тухайн үед уг шинэчлэлийг хийхийн тулд төвийн бүсийн эрчим хүчийг тодорхой хугацаагаар хязгаарлах шаардлага гардаг байсан учраас удирдлагууд энэ ажлыг хийхийг дургүйцдэг байсан аж. Гэхдээ ажилчид арванхоёрдугаар сар буюу оргил ачааллын үеэр зориг гарган хөдөлж, 2006-2007 онд нэг ч удаа төвийн бүсийн эрчим хүчийг тасалдуулалгүй амжилттай ажилласан байна.

Уг өрөөнд станцын бүхий л техникийн үзүүлэлтүүд болон эрчим хүчний нийлбэр ачаалал, ажлын төлөвлөгөө ханын болоод компьютерын дэлгэц дээр харагдах аж. Тэр ч бүү хэл, станцын үйлдвэрлэж байгаа эрчим хүч болон хойд хөршөөс авч байгаа эрчим хүчний хэмжээ гарч ирдэг юм байна. Одоогоор ОХУ-аас 59.9 мВт-ыг авч байгаа аж.

15:00 цаг

Хурлын танхимд цахилгаан цехийн бүх ажилчтан цугларчээ. Тэд өнөөдөр орой хийх ажлын талаар ярилцах аж. Тухайлбал, IV генераторын элэгдсэн хэсгийг салгаж, нэгдсэн засварын газарт өгөх, зарим нэг том оврын эд ангийг тээвэрлэлтэд бэлдэх. Улирлын чанартай станцын зарим хэсэгт хэт халалтыг ажиглах зорилгоор ажилчдыг хуваарилах гэх мэт.

21:30 цаг

Хэдийгээр хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу эдний ажил 17:00 цаг гэхэд тарах ёстой ч Алтанхуяг тэргүүтэй хэсэг хүн ажилласаар. 15:00 цагийн хурал дээр ярьж төлөвлөсөн ажлаа хийж дуусгахаар үлдсэн нь тэр. Дээрээс нь цехийн дарга ажилчдын дунд маргааш болох сургалтын материалтай танилцах гээд нэлээд завгүй.

22:05 цаг

Наран авхай аль хэдийнэ уулын цаагуур унаж, хорвоо ертөнцөд бүрэнхий айлчилжээ. Өдрийн нуруу тэнийлгэх завгүй их ачааллын ард гарсан Алтанхуяг сая нэг юм амс хийж хол ойрын бараа харж зогсоно. Тэрбээр хотын зүг урамтай гэгч нь ширтээд “Бидний хийсэн ажил энэ шүү дээ” гээд их хотын зүг заана. Их хот очир эрдэнэ мэт гялтганах агаад гэрэл гэгээтэй сайхан харагдах ажээ. Илч гэрлийн эздийн хийсэн ажил чухам энэ буюу. ■

ТЭД БИДНИЙ ТУХАЙ

ГАДНЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НОМХОТГОХ ХУУЛЬ БА МОНГОЛ УЛС

Лислай Хуук, Бээжин, Financial Times 2012.05.02



Төслийн асуудалтай тун ойр нэгэн хэлэхдээ хуулийн гол зорилго нь Монгол Улс дахь гаднын эзэмшлийн байгууллага, компаниудын оролцоог хязгаарлах гэжээ.

Б.ТУЯА

УИХ-аар гадаадын хөрөнгө оруулалтыг "чөдөрлөхөд" чиглэсэн хуулийн төслийг хэлэлцэх үеэр Financial Times сонинд энэ талаарх нийтлэл гарсныг орчуулан хүргэж байна.

Монголын Засгийн газар гаднын хөрөнгө оруулагчдыг "номхотгох" нэгэн шинэ хууль батлахаар хэлэлцэж байна. Хуулийн төсөлд гадны хөрөнгө оруулагчдын улсын эдийн засаг дахь оролцоог 49 ба түүнээс доош хувьд хязгаарлах аж.

Байгалийн баялгаар элбэг Монгол Улсын эдийн засгийг 8.5 тэрбум ам.доллараар үнэлж байна. Эдийн засгийн гол хөшүүрэг болж буй уул уурхайн салбар руу хөрөнгө оруулагчид "шуурах" болсон. Гэсэн хэдий ч өнгөрсөн сард гарсан Хятадын санхүүжилтийн гэрээнээс үүдэлтэй шуугиан гадны хөрөнгө оруулалтын асуудлыг хурцатгах нөхцөл болсноор ирэх зургадугаар сард болох УИХ-ын сонгуулийн анхаарлын төв ороод байна.

Хууль батлагдсан тохиолдолд стратегийн гэгдэх эрдэс баялаг, тээвэр жуучлал, хүнс, үл хөдлөх болон мэдээлэл харилцаа, хөдөө аж, ахуйн салбарын ашгийн дийлэнх хувь Монголын эзэмшилд очих юм байна. Хуулийн төслийг өнгөрсөн жил боловсруулж дуусан ч "Хятадын Чалко компани Монголын говь нутагт орших нэгэн уурхайд нэг тэрбум ам.долларын хөрөнгө оруулах гэж байна" гэх мэдээллийн дараагаар буюу энэ оны дөрөвдүгээр сарын 24-ний өдөр УИХ-д өргөн барьсан юм.

Хятадын төрийн өмчийн компаниуд баялаг ихтэй Казахстан, Мьянмар зэрэг хөршүүдээ санхүүжүүлэх нь элбэг. Харин сүүлийн жилүүдэд хил залгаа орнуудын баялгаа хамгаалах эх оронч үзэлтэй тулгарах болжээ.

Тухайлбал, хойд хөрш Мьянмар улсад усан цахилгаан станц барихаар төлөвлөж байсныг тус улсын Засгийн газар Хятадын санхүүжилттэй төслийг цуцлах болсноо мэдэгдсэн. Харин манай улсын хувьд хоёр орны харилцааны түүхэн хуудсанд тэмдэглэсэн үл итгэлцэл түншлэлийн "хазаар" болдог аж.

Өнгөрсөн жилийн ДНБ-ий 62 хувийг гадаадын хөрөнгө оруулалт бүрдүүлсэн баримт мөн дотоодын улс төр болон ирэх сонгуульд үзүүлэх нөлөөг харгалзан УИХ-д өргөн барьсан энэ хуулийн төсөлд өөрчлөлт оруулах магадлал бий.

Монголын бизнес эрхлэгчид хуулийн төсөл хэрэгжиж эхэлбэл тус салбарт хэрхэн нөлөөлөх талаар санал, бодлоо хуваалцсан. Харин Монголын бизнесийн зөвлөлөөс өнгөрөгч долоо хоногт хуулийн төсөлтэй хобогдуулан мэдэгдэл хийжээ. "Ньюком" компанийн гүйцэтгэх захирал Б. Бямбасайхан хэлэхдээ "Хэрэв хуулийн төслийг баталвал Монгол Улс урагшилж, ахих зүйлгүй болж хэн ч хөрөнгө оруулалт хийх гэж манайхыг зорихгүй. Гэхдээ сийрэг сэтгэгчид ялна гэдэгт итгэж байна" хэмээжээ. Төслийн асуудалтай тун ойр нэгэн хэлэхдээ хуулийн гол зорилго нь Монгол Улс дахь гаднын эзэмшлийн байгууллага, компаниудын оролцоог хязгаарлах гэжээ. Гэсэн ч одоо байгаагаар нь баталбал Монгол Улсад орж ирэх гадны санхүүжилтийг бүрэн хаах бөгөөд стратегийн салбарууд дахь хөрөнгө оруулалтын үйл явцыг бүхэлд нь хяналтад оруулж буй хэрэг болох аж.

Чалко компаниас гаргасан хөрөнгө оруулалтын саналн имгэн мөсөн дээрх мөнгөн аяга болов. Тус компанийн саналд Канад, Хонконгд бүртгэлтэй "Саусгоби Сэндс" компанийн хувьцааны дийлэнхийг 925 сая ам.доллараар худалдаж авахаар тусгажээ. Энэ нь урд хөршөөс манай улсад хийх хамгийн том санхүүжилт болох юм байна. Харин хүчтэй эсэргүйцэл, Засгийн газраас тус байгууллагын хайгуулын лицензийг хураах шийдвэртэй тулгарсан тул асуудлыг хойшлуулсан байна.

"Хятадын төрийн өмчийн томоохон компаниуд Монголын бизнес эрхэлдэг аль ч байгууллагыг худалдан авах бүрэн чадалтай. Монгол Улс Бээжин хотын эдийн засгийн нэгэн бүс хот болж хувирах вий гэдгээс монголчууд эмээж байна" хэмээн Улаанбаатар хот дахь нэгэн уул, уурхайн компанийн гүйцэтгэх захирал хэлжээ.

ЭРҮҮЛ МЭНД

ДОНОРЫН ТУХАЙ ХУУЛИА ХУРДАН ХЭЛЭЛЦЭЭЧ, ГУЙЯ

2000 онд баталсан Донорын тухай хуулийн "Шилжүүлэн суулгах эд, эрхтнийг донороос авах тохиолдолд зөвхөн ураг төрлийн хүмүүсийн эмгэггүй эрхтнийг шилжүүлж болно" гэсэн заалт олон аавын хүүг хад мөргүүлж, өнчрүүлсээр.

Б.ЭНХМАРТ

УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороо тэргүүтэй Засгийн газрын эрхэм түшээд, хууль, журам баталдаг эрх бүхий гишүүдээс гуйх гуйлт байна. Донорын тухай хуульд оруулахаар найруулсан нэмэлт, өөрчлөлтийг шуурхай хэлэлцэж, баталж өгөөч. Би аавыгаа аврах гэсэн юм. Миний аавд элэгний донор хэрэгтэй. Цусан төрлийн ах дүү, төрөл төрөгсдөөс нь донорын шаардлагад нийцэх хүн олдсонгүй. Тэгээд ч амьд донороос эрхтэн шилжүүлэх боломжгүй, хуулиараа. Үхсэн донор олдож байгаа ч тэр нь цусан төрлийнх нь биш тул манай хуулиар мөн л боломжгүй. 2000 онд баталсан Донорын тухай хуулийн "Шилжүүлэн суулгах эд, эрхтэнийг донороос авах тохиолдолд зөвхөн ураг төрлийн хүмүүсийн эмгэггүй эрхтнийг шилжүүлж болно" гэсэн заалт олон аавын хүүг хад мөргүүлж, өнчрөл хагацал авчраад зогсохгүй өвчин эмгэгтэй энэлэн шаналж буй иргэдийг тарчлааж байна.

Харин эд, эрхтэний доноргүйн улмаас сэтгэл санаагаараа үхэж байсан миний аав шиг мянга мянган хүнд "Донорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах" санал итгэлийн гэгээ хайрласан. Гэхдээ хуулийн төсөл батлагдах гэж дуншиж буй энэ хугацаанд ч хэн нэгэн энэ шалтгаанаар нөгөө ертөнцөд одож байгааг битгий мартаач. Хором бүр бидэнд, өвчиндөө шаналан, тарчилж буй мянга мянган хүнд үнэтэй байна. Өнгөрсөн гуравдугаар сард өргөн барьсан холбогдох хуулийн шинэчлэл сонгуультай холбоотой элдэв ярианы сүрд дарагдаж, хэлэлцэгдэхгүй хэтэрхий удаж байна. Тэр бүү хэл, Донорын тухай хуульд



нэмэлт өөрчлөлт оруулах гэж байгааг төрийн түшээдийн ихэнх нь мэдэхгүй байх юм. Зарим нь бүр “Сонсоо ч үгүй юм байна” хэмээн хээв нэг хариулж сууна. УИХ-ын С.Бямбацогт, С.Эрдэнэ гэсэн гишүүдтэй утсаар холбогдож, энэ хуулийн төслийг хэлэлцэхгүй удаж байгаагийн шалтгааныг лавлахад тус хуулийн төслийг санаачлагч С.Ламбаагаас бусад нь “Мэдэхгүй” гэх хариулт өгсөн юм. Учир нь энэ асуудал тэдэнд нэг их ач холбогдолгүй, чухал бус сэдэв гэсэн. Эрүүл мэндтэй холбоотой энэ мэт асуудлыг “Нэг их ач холбогдолгүй сэдэв” хэмээгчид өвдөж, зовдоггүй гэж үү. Үр хүүхэд, ах, дүүс нь үргэлж эрүүл саруул байдаг юм гэж үү. Үгүй. Тэд Монголын эмнэлэг, эмчид хандахаа байгаад удаж байгаа гэсэн. Толгой нь эргэх, гэдэс нь эвгүйрхэх тэдийхэнд өндөр хөгжилтэй гаднын орнуудыг зорин нисдэг нь нууц биш. Эх оронд нь худалдаалагдаж байгаа эм, тариаг ч тэд хэрэглэдэггүй. Тийм болохоор энэ салбарт хамааралтай хууль, элдэв асуудал тэдэнд огт падгүй ажээ.

Монголын эрүүл мэндийн салбар хэрхэн доройтож, өөдөлж дэвшиж байгааг Төрийн ордонд суугчдын ихэнх нь мэдэхгүй. Гэхдээ хамгийн чухал бөгөөд үнэн зүйл нь тэднийг өвдөж, сандаргахад гаднын орноос түргэн тусламж ирж амжихгүй нөгөө гологдож, орхигдсон түргэний эмч нар л очно гэдгийг мартаж боломгүй юм.

Гаднын орнуудад ашиглагдахаа больсон, үеэ элээж, тэтгэвэртээ гарсан хуучин аппарат, хөл нь эвдэрч хүн даахгүй болсон ор зэргийг хандиваар авчирч өгснийгөө Эрүүл мэндийн салбарт шинэчлэлт хийсэн дайны юм ярьдаг. Гэвч бодит байдал дээр хуулийн ганцхан заалтаас болж хэдэн зуун хүн хорвоог орхиод байгааг бид таашгүй. Тийм судалгаа, тоо ч байхгүй. Харин эмч нарын баримт цохон хэлснээр бол нийслэлийн хэмжээнд элэгний донорын хагалгаанд нэн яаралтай орох шаардлагатай 50 орчим хүн эрхэм түшээдийн шийдвэрийг тэсэж ядан хүлээж байна.

Өмнө минь Донорын тухай хууль болон нэмэлт, өөрчлөлт оруулахаар найруулсан хуулийн төсөл дэлгээтэй байна. Олон зуун хүнд амьдрал бэлэглэхэд ердөө дөрөвхөн үг л хэрэгтэй ажээ. “Эд эрхтнээ бэлэглэхийг хүссэн” гэх амины үнэтэй дөрөвхөн үг. Одоогоос 12 жилийн өмнө батлагдсан Донорын тухай хуулийн энэ заалтад байсан алдааг засахыг олон зуун хүн хүлээж байна. Тэр дундаа амьд донороос эд, эрхтэн шилжүүлэн суулгах хүрээг тэлэх хэрэгтэй гэдгийг эмч, мэргэжилтнүүд хэлдэг. Эрхэм түшээдээ гуйя. Донорын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг сонгуулиас илүү ард иргэдээ бодоод хурдан хэлэлцэж, батлаг өгөөч. Тэгвэл та бүхэн УИХ-д дахин нэр дэвшихдээ ядахдаа хэлэх нэг сайн зүйлтэй болно шүү дээ


Но байна гэв үү

Эд, эрхтний донороос гадна цусны донор гэж бий. Дэлхийн сая сая иргэн цусны донорын ачаар өдгөө эрүүл саруул амьдарч буй. Харин манай орны хувьд 20 мянга гаруй цусны донор байдаг гэх албан ёсны тоо байна. Донорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд цусны донорт хамааралтай, хамгийн чухал хоёр заалтыг хассан тухай Монголын доноруудын холбооны ерөнхийлөгч М.Сосорбарам учирлаж байсан. Тэрбээр “Эрүүл мэндийн яамны С.Ламбаа тэргүүтэй төсөл санаачлагчид донортой холбоотой байгууллагуудын төлөөлөлийн санал, оролцоогүйгээр шинэчилсэн найруулга бэлдэж, УИХ-д өргөн барьсан. Гэтэл уг төсөлд хэд хэдэн ноцтой алдаа байгаа. Монголын ард түмний амьд явах үнэт зүйл болох цусны донорууддад тавих халамж, тэдний нийгмийн амьдралтай холбоотой хоёр заалтыг шинэчилсэн төсөлдөө хасаж, найруулсан байна. Уг нь жил ирэх тусам өсөн нэмэгдэж байгаа ард түмэнд, тэр дундаа Эрхтэн шилжүүлэн суулгах төвтэй болох гэж байгаа энэ үед цусны донор юу юунаас үнэтэй билээ. Уг хуулийн төсөлд цусны донорт үзүүлэх тусламжийг 35-аас дээш удаа цусаа өгсөн хүнийг жилд нэг удаа сувилалд үнэгүй амраах эрхээр сольсон. Донор жилд дөрвөн удаа цусаа өгөх ёстой бөгөөд энэ тооцоогоор бодож үзвэл нэг хүн 10-12 жилийн дараа сувилалд амрах эрхийг эдлэх болж байгаа юм. Уг нь бол цусаа өгөх бүрт нь сэтгэл зүйн болон эд материалын багахан ч болов халамж үзүүлдэг байх нь донорууддын тоог нэмэгдүүлэхэд чухал нөлөө болно” хэмээн ярьсан.

Хэдийгээр эд, эрхтэнийдонорууддын хувьд ээлтэй, чухал хуулийн заалт байгаа ч энэ мэт жижиг сажиг алдаа байгааг хэлэх хүн байна. УИХ, эрх бүхий түшээд уг хуулийн төслийг хэлэлцэж, шийдвэрлэхдээ 2000 онд баталсан Донорын тухай хууль шиг хүний амь настай холбоотой асуудалд нухацтай хандана гэдэгт итгэж байна. ■

НОМЫН БУЛАН

ТАНЫ АМЬДРАЛД ӨӨРЧЛӨЛТ АВЧИРСАН НОМОО НЭРЛЭХГҮЙ ЮУ?



Ц. Оюунчимэг /Жендерийн сургагч багш, чөлөөт сэтгүүлч/

Сүүлийн үед уншсан номнуудаас хамгийн их гүнзгий сэтгэгдэл үлдээсэн нь АНУ-ын зохиолч, монголч эрдэмтэн Жак Уэтерфордын “Монгол хатдын нууц түүх” юм. Энэ номноос анхаарал татсан зүйл нь Чингис хаан XIII зуунаас улсаа хүчирхэг байлгасан бүх үедээ жендерийн бодлогыг маш зөв харьцаатай хэрэгжүүлж, нийгмийн бодлогоороо тэргүүлдэг байж. Жишээлбэл, Их хуралдайд гэхэд хатдын суудал гэж тусгайлан байдаг. Мөн Чингис хааны охидууд их хатан болоод эзэн улс орнуудыг захирахаар явдаг байжээ. Харин охинтой гэрлэсэн ханхүү нарыг хүргэн ханхүү гэж нэрлэдэг байсан бөгөөд тухайн улсыг захирч буй гол удирдагч нь их хатад буюу Чингис хааны охид байсан.

Манайд үен үеийн эрчүүд дайтаж улсаа авч явдаг гэсэн ойлголттой байсан бол энэ номд ийм сонирхолтой баримтуудыг дэлгэснээрээ ач холбогдолтой.

Эцэст нь хэлэхэд монголчууд эх түүхээ жинхэнэ эх сурвалжаас нь уншиж, бодит мэдээллийг уг номноос олж авах тул хөгжил өөд тэмүүлдэг хүн бүхнийг уншаарай гэж уриалъя.




Л.Золзаяа / “Нью медиа” маркетингийн агентлагийн мэргэжилтэн/

Үргэлж эрч хүчтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай болоход нөлөөлсөн тэр ном бол Японы эрдэмтэн, судлаач Сайшо Хирошигийн “Өглөөний хүн” юм.

Би хоёр жилийн өмнө энэ номыг анх уншиж байсан. Хувь хүний хөгжлийн чиглэлийн ном олон төрөл байдаг. Энд хэрэв та өглөөний хүн болж чадвал цаг хугацааг хэмнэн, ажлын бүтээмжээ дээшлүүлж, цаг хугацааг үр дүнтэй ашиглаж, өөртэй ч цаг гаргаж чадах болно. Тиймээс таныг өөрийнхөө цаг хугацааг захирч сурахад энэ ном туслах болно гэдэг итгэлтэй байна. Би өөрийнхөө туршлагыг сонирхуулахад өглөөний хүн болсноос хойш хүмүүс надаас “Чи энэ олон ажлыг яаж амжуулдаг байна аа” гэж гайхаж асуудаг. Би өөрийнхөө амьдралын хэв маягт багагүй шинэчлэл хийж, өглөөний толгой сэргэг, хөдөлмөрийн бүтээмж өндөртэй цагийг илүү үр дүнтэй ашигладаг болсон. Тиймээс наад зах нь өглөө ажилдаа ирээд интернэт хэсэж, facebook ухаж, мессенжерт оролгүй хамгийн чухал ажлуудаа амжуулчихаад үдээс хойш бүтээмж буурах үеэр дуртай зүйлээ хийх жишээтэй.

“Ядуу хүний онцлог шөнө дөл болтол унтах бол баян хүний онцлог эрт босох явдал юм” гэсэн мэргэн үг бий. Хамтдаа цагийг захирагч болохын төлөө хичээцгээе.



С. Одонтуяа /Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч /

Би хэдэн жилийн өмнө гадаад явж байхдаа “Эдийн засгийн алуурчны өчил” номыг санамсаргүй байдлаар олж уншсан. Жон Перкинс хэмээх эдийн засгийн “алуурчны” ажлыг хийдэг байсан хүн туулж өнгөрүүлсэн намтраараа сэдэвлэн энэхүү номыг бичсэн. Хэвлэгдсэн даруйдаа дэлхий даяар олныг цочроож, “Нью Йорк таймс” сонины хамгийн их борлуулалтай номоор шалгарч, 30 орны хэл дээр орчуулагдан гарсан.

Эдийн засгийн алуурчид гэдэг нь энгийнээр хэлбэл8 дэлхийн улс орнуудаас триллион триллионоор нь мөнгө хүүлдэг өндөр цалинтай эдийн засгийн зөвлөх мэргэжилтнүүд юм. Тэд санхүүгийн тооцоонд манипуляци засвар хийх, сонгуулийн үр дүнг урьдчилж зохицуулах, авлига, айлган сүрдүүлэг, аллага хийдэг гэдгийг тэрбээр номондоо маш дэлгэрэнгүй бичсэн.

Түүнчлэн өөрөө Индонези, Панам, Экватор, Колумб, Саудын Араб, Иран зэрэг улсад томоохон хэмжээний эдийн засгийн тусгай ажиллагаа зохион байгуулдаг байснаа ч бичсэн байдаг. Тиймээс энэ байдал манайд тулгарч ч болох магадлалтай тул сэрэмжлүүлэг болгон үүнтэй холбоотой өөрийн илтгэлээ бичсэн байгаа. Өнгөрсөн бороонь хойноос цув нөврехгүйн тулд бид ирж болох эрсдэлийг хүлээж суух биш, урьдчилан мэдэх нь чухал юм. Тиймээс дэлхий нийтийг шуугиулсан эл номыг манайхан уншаасай гэж хүсэж байна.

www.mongolianeconomy.mn

MONGOLIAN ECONOMY

ТОД ТАМГА

БИШИРТҮГЭЙ! АЮУТУГАЙ!



ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ ХҮРТ!

Утас: 91919499, 323454 www.todtamga.mn
Хаяг: ЧД, Татварын Ерөнхий газрын ард
“ТОД ТАУЭР” оффис, 101 тоот
Утас: 98907234

САЛБАРУУД:

Баруун 4 зам	**Утас: 98626587 todtamga2@yahoo.com**
Зуун айл	**Ута: 98907912 todtamga1@yahoo.com**
Түгээмэл	**Утас: 98630499 todtamga3@yahoo.com**